

Лиахоно

Эзра, Флора
Бэнсон хоёр
Их Эзэний
ажилд нэгдмэл
байв, 32-р хуудас

Аврагчийн заасан аргаар
зааж сурах нь, 24-р хуудас

Таны амьдрал дахь хамгийн
чухал хүн, 56-р хуудас

Бяцхан гарууд, том өөрчлөлт,
64-р хуудас



*“Давс бол сайн
юм. Харин давс
нь амтгүй болбол
юугаар давслаг
болгох билээ?”*

Лук 14:34

Зүүн талд: Урд хэсэгт давстай
Сөнөсөн Тэнгисийн Эйн Геди
далайн эрэг дээрх өвлийн нэгэн
өглөө үүр цайж байгаа нь.



ЗАХИАСУУД

- 4** Тэргүүн Зөвлөлийн захиас
бичиг: Бошиглогчдыг дага
Ерөнхийлөгч Томас С.Монсон
- 7** Айлчлагч багшийн захиас
бичиг: Есүс Христийн зан
чанарууд: Дуулгавартай Хүү

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

- 18** Та нар юу сонгох вэ?
Ахлагч Рассэлл М.Нэлсон
*Амьдрал тань сонголтуудаар
дүүрэн байгаа үед зөв сонгол-
тууд хийхэд анхаар.*

ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн тада: Сүмийн түүхийн номын сангийн зөвшөөрлөөр нийтэлсэн гэрэл зураг. Дотор талын хавтсанд: Гилад Массын гэрэл зураг

- 24** Бид ямархуу маягийн багш нар байвал зохих билээ?
Ням гаргийн ангийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл
Аврагч Өөрийн сайн мэдээг бидэнд хамгийн сайн зааж чадна.

- 28** Бошиглогчийн зөвлөгөө ба ариун сүмийн адислалууд
Ахлагч Койчи Аояаги
Бид бошиглогчийг дагаж, ариун сүмийн сүсэг биширэлээ эн тэргүүнд тавих үед адислалууд бидний амьдралд ирэх болно.

- 32** Флора бид хоёр- Их Эзэний ажил дахь эн тэнцүү хамтрагчид
Аарон Л.Вэст
Эзра Тафт Бэнсоны, эхнэр Флоратайгаа хамт туулсан хайраар дүүрэн, ханийн түшиг тулгуур болсон гэрлэлт нь Сүмийн 13 дахь ерөнхийлөгчид хэрхэн тусалсан талаар суралц.

АЛБАД

- 8** 2014 оны 10-р сарын чуулганы тэмдэглэл
- 10** Бид Христийн тухай ярьдаг: Түүнтэй хамт сэргэг байх ганцхан цаг
Марица Гонзалез Эспехо
- 12** Бидний гэр орон, гэр бүлүүд: Мөнхийн гэр бүлд хүргэх зам
Гарт Хамблин, Сэнди Хамблин нар
- 14** Эргэцүүлэл: Галт хорхой
Дэвид Райт
- 15** Сүмд үйлчилсэн нь: Багшдаа өгсөн төмс
Бонни Далсрад
- 16** Сүмийн мэдээ
- 38** Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой
- 80** Биднийг дахин уулзтал: Их Эзэн намайг өршөөсөн эсэхийг би хэрхэн мэдэх вэ?
Ерөнхийлөгч Харолд Б.Лий



42

42 Үргэлж хамтдаа зөвлөлд: Хосуудад зориулсан гэр бүлийн зөвлөгөө

Никол Эк

Гэр бүлийн утга учиртай, амжилттай хурлыг хэрхэн хийж эхлэх вэ.

46 Гэрлэх зориг

Крисчин Хаггланд

Гэрлэлт миний хувьд дараагийн алхам байсныг би мэдэж байсан ч Их Эзэн надад юу хийхийг хэлэх хүртэл хүлээхээр шийдсэн юм.



50

48 2015 оны Мючелийн сэдэв

Залуу эмэгтэйчүүдийн болон Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлүүд

Энэ жилийн Мючелийн уриа нь Тэнгэрлэг Эцэгтээ хэрхэн хамгийн сайнаараа үйлчлэхийг ойлгоход бидэнд тусална.

50 Нэг удаад нэг алхмаар

Хиллари Олсэн

Итали дахь өсвөр үеийнхэн бүхий л зурх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа Бурханд хэрхэн үйлчилдэг тухайгаа хуваалцаж байна.

53 Өөрсдийн бүхий л зурх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа Бурханд үйлчил

Та нар энэ жилийн Мючелийн уриаг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ? Энд хэдэн жишээ авч үзье.

55 Зурагт хуудас: Хөлөг онгоцонд суу

56 Есүс Христ яагаад миний амьдралд чухал байр суурь эзэлдэг вэ?

Аврагч та нарын амьдралд хамгийн чухал хүн байж чадах таван шалтгаан.

60 Мөнхийн зорилгууддаа хэрхэн хүрэх вэ

Ахлагч Робэрт Д.Хэйлс

61 Би хэрхэн мэдсэн бэ?: Миний амьдралын гол зүйл

Роберто Пакэсо Прэтэл
Христ Америк тивд ирсэн гэв үү? Номлогчид андуурсан байх.

62 Нүдээ олсон хариулт

63 Хамгийн сайн бэлгээ өгөх нь

Мариела Родригез



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Санамж: Автобусны суудлыг ол.



64 Бидэнд гараа сунгаач!

Та эдгээр хүүхдийн адил бусдад туслах арга замуудыг олсноор анхаарал халамжаа үзүүлж болно.

66 Шинэ Гэрээний судруудыг унших даалгавар

Энэхүү үйл ажиллагаа нь танд энэ жилийн турш долоо хоног бүр Шинэ Гэрээнээс хэдэн эшлэл уншихад тань туслах болно.

69 Цагаа ашиглан ямар нэгэн сайн зүйл хийх нь

Клэйтон В.

70 Бидний хуудас

71 Онцгой гэрч: Судрууд бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

Ерөнхийлөгч Бойд К.Пакэр

72 Нууц зэвсэг

Жэссика Ларсэн
Айви манай ангийн хамгийн давжсаа биетэй нь байсан ч биднийг хожиход хэрхэн тусалсан бэ?

74 Судрын цаг: Есүс Христийн талаар суралцах аялал

76 Аббигийн хамгийн чухал 10 зорилгын жагсаалт

Рөүзмэри М.Виксом
Чиний амьдралын хамгийн чухал 10 зорилго юу вэ?

77 Шинэ Гэрээний судрын баатрууд: Есүс ариун сүмд заасан нь

78 Автобусан дотор хэлсэн залбирал

Мици Жимэнээ Рамирээ



Ерөнхийлөгч
Томас С.Монсон

Бошиглогчдыг ДАГА

Би Дэлхийн II дайны сүүлчийн жилүүдэд Нэгдсэн Улсын тэнгисийн цэрэгт алба хааж байлаа. Би тэнгисийн цэрэгт хамгийн бага цолтой усан цэрэг байв. Дараа нь би нэгдүгээр зэргийн усан цэргийн болзлыг хангасан. Үүний дараа тэнгисийн цэргийн гуравдугаар зэргийн түрүүч болсон билээ.

Дэлхийн II дайн дуусахад би цэргийн албанаас халагдсан ч цэргийн албандаа эргэн очих эсэх талаар бодож үзээд, офицероор алба хаах хүсэлтээ гаргав. “Би өөрөө л зайлсхийж чадах юм бол дахин заваан гал тоого болон шал цэвэрлэхгүй байж чадна” гэж бодсон юм.

Би тэнгисийн цэргээс халагдсаныхаа дараа Нэгдсэн Улсын Тэнгисийн цэргийн бэлтгэл хүчинд оров. Тэгээд даваа гаргийн орой бүр сургуулилахаар явдаг байв. Мэдлэгийн түвшин тогтоох шалгалтад тэнцэхийн тулд шаргуу суралцдаг байсан. Би сэтгэхүй, бие бялдрын болон сэтгэл зүйн шалгалт бүрийг төсөөлж байснаараа дажгүй өглөө. Эцэст нь: “Таныг Нэгдсэн Улсын Тэнгисийн цэргийн бэлтгэл хүчинд бага дэслэгчээр ажиллуулахаар боллоо” гэсэн баяртай мэдээ ирэв.

Би уг мэдээг эхнэр Францистаа тун баяртайяа үзүүлж, “Би зорилгодоо хүрлээ! Зорилгодоо хүрлээ!” гэж дуу алдаж байж билээ. Эхнэр минь намайг тэврээд, “Чи зорилгодоо хүрэхээр хангалттай шаргуу ажилласан шүү дээ” гэж надад хэлсэн юм.

Гэтэл дараа нь нэг явдал тохиолдов. Би тойргийнхоо бишопын зөвлөлд дуудагдаа. Бишопын зөвлөлийн хурал тэнгисийн цэргийн сургуулилын цугларалттай давхцах болов. Би үүнийг ноцтой зүйл гэдгийг мэдэж байсан юм. Би тэнгисийн цэргийн бэлтгэл хүчний *болон* бишопын зөвлөлийн ажил үүргээ нэгэн зэрэг биелүүлэх нь цагийн хувьд боломжгүйг мэдэж байлаа. Би юу хийх ёстой вэ? Шийдвэрээ гаргах хэрэгтэй болов.

Би энэ талаар залбирсан юм. Тэгээд би намайг бага байхад манай гадасны ерөнхийлөгч байсан, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч (1899–1973)

Харолд Б. Лийтэй уулзахаар очив. Би түүний өөдөөс хараад, ширээнийх нь ард сууж байлаа. Тэнгисийн цэргийн офицерын алба миний хувьд ямар их үнэ цэнэтэй болохыг би түүнд хэлсэн. Түүгээр ч барахгүй албан тушаалд томилогдсон захидлынхаа нэг хувийг ч түүнд үзүүлэв.

Тэр уг асуудлын талаар хэсэг зуур тунгаан бодсоны эцэст “Монсон ах аа, таны хийх ажил бишопын зөвлөлд байгаа. Та Тэнгисийн цэргийн албаны холбогдох хэлтэст захиа бичиж, бишопын зөвлөлийн гишүүний дуудлагаа хийхийн тулд Нэгдсэн Улсын Тэнгисийн цэргийн бэлтгэл хүчинд энэхүү цолыг хүлээн авах боломжгүй гэдгээ тэдэнд хэл” хэмээн надад хэллээ.

Би гүн уйтгар гунигт автав. Тэр цааш нь, “Тэгээд Сан Франциско дахь Тэнгисийн цэргийн арванхоёрдугаар нэгтгэлийн захирагчид бичиж, тэдэнд бэлтгэл хүчнээс халагдах хүсэлтэй байгаагаа хэл” гэх нь тэр.

“Ахлагч Лий, та цэргийн албыг ойлгохгүй байна. Мэдээж хэрэг, хэрэв би энэ цолыг хүлээн авахаас татгалзвал тэд миний цолыг бууруулах болно. Бас Тэнгисийн цэргийн арванхоёрдугаар нэгтгэл намайг цэргийн албанаас халахгүй. Солонгост болж байгаа дайнд мэдээж бага дарга л цэргийн жинхэнэ албанд дуудагдана. Хэрэв би буцаад очвол эргээд офицер болж болно, харин би энэ цолыг хүлээн авахгүй бол ингэж чадахгүй шүү дээ. Энэ бол намайг хүлээн авахыг хүсэж байгаа таны зөвлөгөө гэдэгт та итгэлтэй байна уу?” гэж би асуусан юм.

Ахлагч Лий мөрөн дээр минь гараа тавин, “Монсон ах аа, илүү их итгэлтэй бай. Цэргийн алба таны хийх ажил биш” хэмээн эцэг хүний ёсоор хэлсэн билээ.

Би гэртээ хариад, нулимсны ор үлдсэн, цол олгосон захидлаа, уг цолыг хүлээн авахаас татгалзсан захианы хамт дугтуйнд буцаан хийв. Тэгээд би Тэнгисийн цэргийн арванхоёрдугаар нэгтгэлд захидал бичиж, Тэнгисийн цэргийн бэлтгэл хүчнээс халагдах хүсэлтээ илгээж билээ.

Би тийнхүү Солонгосын дайн эхлэхийн өмнө эмхлэн байгуулагдсан Тэнгисийн цэргийн бэлтгэл хүчний



Хэрэв би ахлагч Харолд Б.Лийгийн зөвлөгөөг дагаагүй бол өнөөдөр хашиж байгаа Сүмийн энэ албан тушаалдаа үйлчлэхгүй байх байсан.

сүүлчийн бүлгээс халагдсан юм. Бүрэлдэхүүнд миний ажиллах ёстой байсан цэргийн бүлгийн төв штаб байгуулах ажил эрчимтэй явагдаж байлаа. Би бишопын зөвлөлд дуудагдсанаасаа хойш 6 долоо хоногийн дараа тойргийн бишопоор дуудагдав.

Хэрэв би бошиглогчийн тэр зөвлөгөөг дагаагүй бөгөөд шийдвэрийнхээ талаар залбирч асуугаагүй бол, зарим үед Бурханы мэргэн ухаан хүмүүст тэнэглэл мэт харагдаг гэсэн маш чухал үнэнийг ухаарч хүлээн аваагүй бол өнөөдөр хашиж байгаа Сүмийн энэ албан тушаалдаа үйлчлэхгүй байх байсан.¹ Гэвч мөнх бус амьдралдаа бидний суралцаж чадах хамгийн том сургамж бол Бурхан ярьж, хүүхдүүд нь дуулгавартай дагах үед үргэлж тэдний зөв байдаг явдал юм.

Түүх жижиг шийдвэрүүдээс хамааралтай байдаг гэж ярьдаг.

Бидний амьдрал ч бас ийм байдаг. Шийдвэрүүд нь бидний хувь заяаг тодорхойлдог. Гэвч бид ямар нэгэн тусламж дэмжлэггүйгээр шийдвэр гаргадаггүй.

Хэрэв та тэнгэрийн гэрлийг харахыг хүсдэг бол, хэрэв та бүхнээс Хүчит Агуу Бурханы сүнслэг

илчлэлтийг мэдрэхийг хүсдэг бол, мөн Бурхан өөрийг тань удирдаж байгааг зүрх сэтгэлдээ мэдрэхийг хүсдэг бол та Бурханы бошиглогчдыг дага. Та бошиглогчдыг дагаснаараа аюулгүй байх болно. ■

ЭШЛЭЛ

1. 1 Коринт 2:14-ийг үзнэ үү.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Сүмийн цөөхөн гишүүн л ерөнхийлөгч Монсон шиг төлөөлөгчтэй нүүр тулан уулзаж, зөвлөгөө авах боломжтой юм. Харин бид бошиглогч, төлөөлөгчдийн сургаалуудыг дагаснаар адислагдсаар байх болно. Өнгөрсөн Ерөнхий чуулган дээр ерөнхийлөгч Монсоны хэлсэн үгийг (чуулганы нээлт болон хаалт дээр хэлсэн түүний үгийг мөн сана) унших талаар бодож үзнэ үү. Үйлдэл хийхэд урьсан тодорхой удирдамж эсвэл уриалгуудыг хайж ол. Та сурсан зүйлүүдээ айлчилж очдог хүмүүстэйгээ ярилцаж, ерөнхийлөгч Монсоны зөвлөгөөг хэрэгжүүлэх арга замуудын талаар бодож үзэж болно.

Энэ захиас бичгийг өсвөр үеийнхэнд болон хүүхдүүдэд заах санаануудыг үзэхийн тулд 6-р хуудсыг үзнэ үү.

Хэцүү сонголт хийхэд өгөх зөвлөгөө

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг бошиглогчийн зөвлөгөөг дагасан нэг тохиолдлынхоо талаар ярьсан юм. Нэг Ерөнхий чуулганаар ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон (1899–1994) гишүүдэд өрөө, ялангуяа үл хөдлөх хөрөнгө барьцаалсан урт хугацааны зээлээ төлж барагдуулахад уриалжээ.

“Хурлын дараа би эхнэртээ хандан ‘Бидэнд энэ уриалгыг хэрэгжүүлэх ямар нэгэн арга зам байгаа гэж чи бодож байна уу?’ гэж асуусан. Эхэндээ бид тийм арга замыг олж чадаагүй”

гэж ерөнхийлөгч Айринг хэлжээ. Гэвч тэд худалдах гэж олон жил хичээгээд зарж чадаагүй байгаа үл хөдлөх хөрөнгийнхөө тухай санасан ажээ. Тэр хэлэхдээ “Бид Бурханд болон . . . Түүний үйлчлэгчийн захиаст итгэдэг байлаа, [тэгээд] бид утасны дуудлага хүлээн авлаа. . . . Би тэр өдөр Бурханд болон Түүний үйлчлэгчдэд итгэх итгэлийг минь хүчирхэгжүүлсэн хариултыг сонссон юм” гэжээ. Яг тэр өдөр нэг хүн утасдаж, Айрингийн үл хөдлөх хөрөнгийг худалдан авахын тулд урт хугацааны зээлээс нь өндөр үнэ санал

болгожээ. Удалгүй Айрингийн гэр бүлийнхэн өрөө төлж дууссан байна. (“Бурханд итгэ, тэгээд явж, үйлд,” *Лиахона*, 2010 оны 11-р сар, 72–73).

Танд төлөх шаардлагатай урт хугацааны зээл байхгүй байж болно, гэвч бошиглогчийн зөвлөгөө нь ажил, боловсрол, номлол болон болзооны талаар хэцүү шийдвэр гаргахад тань таныг удирдаж чадна. Шийдвэр гаргах шаардлагатай үедээ бошиглогчийг хэрхэн дагаж болох талаар гэр бүлийнхэнтэйгээ эсвэл үе тэнгийнхэнтэйгээ ярилц.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Замаа ол

Бид Тэнгэрлэг Эцэгтээ эргэн бочихын тулд олон сонголт хийх ёстой. Бид бошиглогчийг дагаснаар хамгийн сайн сонголтыг хийж чадна.

Төөрдөг байшин дотор сүлжин, замаа ол. Шийдвэр гаргах үедээ бошиглогчийн зөвлөгөөнд найд!



Судруудыг унш
Баруун тийшээ яв



Залбир
Доошоо яваад, дараа нь баруун тийшээ эргэ




Гэрчлэлээ хуваалц
Баруун тийшээ яв



Бусдад тусал
Доошоо яваад, дараа нь зүүн тийшээ эргэ



Сүмд яв
Дээшээ яв



Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэж авахаар эрэлхийл. Аврагчийн амьдрал болон зорилгыг ойлгох нь Түүнд итгэх итгэлийг тань хэрхэн нэмэгдүүлж мөн айлчлагч багшлалтаар дамжуулан харж хандаг хүмүүсийн тань амьдралыг хэрхэн адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээллийг reliefsociety.lds.org-аас үзнэ үү.

Есүс Христийн зан чанарууд: Дуулгавартай Хүү

Энэ бол Аврагчийн зан чанаруудыг агуулсан Айлчлагч багшийн цуврал захиас бичгийн нэг хэсэг юм.

Бид Есүс Христийн дуулгавартай байдлын үлгэр жишээг дагаснаар Түүнд итгэх бидний итгэл өсөн нэмэгддэг. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд “Христ юуны өмнө Эцэгтэйгээ харилцах харилцаандаа өөрийгөө тодорхойлохдоо түүнийг хайрлах, дуулгавартай дагах, цорын ганц үнэнч хүү нь байж түүнд захирагдахаар сонгосон нь гайхамшигтай биш гэж үү.” Дуулгавартай байдал бол тэнгэр дэх анхны хууль юм¹ гэж хэлжээ.

Судрууд “Мөн бид ямар ч адислалыг Бурханаас авлаа гэхэд, энэ нь тулгуурлагдсан тэрхүү хуульд дуулгавартай байснаар буюу” (С ба Г 130:21) хэмээн заадаг. Дуулгавартай байдлаар дамжуулан Бурханд ойртож, Аврагчийн Цагаатгалын хүчийг амьдралдаа урьснаар бидний сүнслэг байдал өсөж хөгждөг.

“Бид Есүс Христийн сайн мэдээний зарчимд болон зарлигуудад



дуулгавартай байснаар Бурханаас бидэнтэй хийсэн гэрээндээ амласан адислалуудын тасралтгүй урсгалыг хүлээн авах болно.” Эдгээр адислал нь зүгээр л үйлдүүлэх бус, харин үйлдэхэд бидэнд хэрэгтэй эх сурвалжуудаар биднийг амьдралын туршид хангадаг юм. . . . Дуулгавартай байдал нь амьдралаа хянах илүү агуу чадварыг болон ирээд хийж бүтээх илүү агуу чадавхыг бидэнд өгдөг² хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон хэлжээ.

Нэмэлт судрууд

Лук 22:41–46;

Сургаал ба Гэрээ 82:10; 93:28

ЭШЛЭЛҮҮД

1. Жэффри Р.Холланд, “The Will of the Father in All Things” (Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт, 1989 оны 1-р сарын 17), 4, speeches.byu.edu.
2. Д. Тодд Кристоффэрсон, “Гэрээнүүдийн хүч,” *Лиахона*, 2009 оны 5-р сар, 21.
3. Дэвид А.Бэднар, “Их Эзэнд хөрвүүлэгдэв,” *Лиахона*, 2012 оны 11-р сар, 109.



Итгэл, гэр бүл, халамж

Судруудаас

“Зарлигуудад үргэлж дуулгавартай байснаар ирдэг сүнслэг хүч чадлыг өөр хүнд өгч болох уу? гэж Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А. Бэднар асуужээ. “Тодорхой хариулт нь . . . үгүй.”³

Энэ зарчмын нэгэн жишээ бол арван охины тухай сургаалт зүйрлэл билээ. Охид бүгдээрээ “Хүргэнийг угтахаар” дэнлүүгээ авсан ч зөвхөн ухаалаг тав нь дэнлүүгээ тос хийсэн савны хамт авсан байна. Мунхаг тав нь дэнлүүгээ авсан ч “тосыг нь авсангүй.”

Гэтэл шөнө дөлөөр хашгирах дуун гарч, “Хараач хүргэн байна. Түүнийг тосож авцгаа” гэлээ. Нөгөө охид бүгдээрээ босож, дэнлүүгээ бэлдэв. Гэтэл мунхгуудад тос байсангүй. Тэд ухаалгуудад “Бидэнд тосноосоо өгөөч; бидний дэнлүү бөхөх нь” гэжээ.

Ухаалгууд нь “Бидэнд ч, та нарт ч огт хүрэлцэхгүй. Оронд нь худалдаачин руу очиж, тос худалдаж ав” гэжээ. Тэднийг худалдаа хийхээр явсан хооронд хүргэн ирээд, бэлэн болсон хүмүүс хүргэний хамт хуримын найранд оров. “Тэгээд хаалгаа хаажээ” (Матай 25:1–13).

Үүнийг эргэцүүлэн бод

Судруудад дуулгавартай байдлын ямар ямар жишээ өгөгдсөн байдаг вэ?

2014 ОНЫ 10-Р САРЫН ЧУУЛГАНЫ ТЭМДЭГЛЭЛ

“Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, . . . харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил” (С ба Г 1:38).

Амьд бошиглогч, төлөөлөгчид болон сүмийн бусад удирдагчдын саяхан заасан зүйлсээс суралцаж, тэдгээрийг амьдралдаа хэрэгжүүлэхэд тань туслах 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулганы хэлсэн үгсийг судлахдаа эдгээр хуудсыг (мөн дараагийн дугаарууд дахь чуулганы тэмдэглэлүүдийг) ашиглаж болно.

СУРГААЛЫН ЧУХАЛ ХЭСЭГ



Биднийг амьд бошиглогчид удирддаг.

“Өнгөрсөн жил ерөнхийлөгч Монсоны Сүмийн ерөнхийлөгчөөр дуудагдсаны 5 жилийн ой болсон бөгөөд тэрээр энэ үеэр төлөөлөгчийн хувьд үйлчилсэн 50 жилийн үйлчлэлээ дүгнэхдээ: ‘Сүм найдвартай гарт байгаа гэдгийг би та нарт баттайяа хэлье. Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Чуулгад зориулан энэхүү тогтолцоог бий болгосон тул, мөн Сүм үргэлж найдвартай гарт байдаг учир ямар ч зүйл тохиолдоо гэхэд та бүхэн санаа зовж, айх шаардлагагүй. Бидний дагаж, шүтэн биширч, үйлчилдэг Аврагч, Есүс

Христ үргэлж Сүмийг удирдаж байдаг юм”¹ гэж хэлсэн байдаг.

“Бидэнд өгсөн эдгээр үнэний тань төлөө ерөнхийлөгч Монсон танд бид талархаж байна! Мөн амьдралынхаа турш үзүүлсэн үлгэр жишээ, чин сэтгэлийн үйлчлэлд тань бид талархаж байна. . . . Бид таныг зөвхөн гараа өргөн дэмжин батлаад зогсохгүй, бүх сэтгэл зүрх, хичээл зүтгэлээрээ дэмжиж байдаг билээ.”

Ахлагч Рассэлл М.Нэлсон, “Бошиглогчдыг дэмжин батлах нь,” *Лиахона*, 2014 оны 11-р сар, 76.

ЭШЛЭЛ

1. “Ерөнхийлөгч Томас С.Монсоны сүнсэлэг захиасууд,” *Church News*, 2013 оны 12 сарын 3

БОШИГЛОГДСОН АМЛАЛТ



Христийн зам

“Бид Түүний үгсээс суралцаж, сургаалуудыг нь дагаж, Түүний замаар алхсанаар Христийг амьдралынхаа төвд байрлуулахыг хичээх юм бол Тэрээр олж авахын тулд амиа өгсөн мөнхийн амьдралаа бидэнтэй хуваалцах болно гэж амласан юм. Бид Түүний сахилга батыг хүлээн авч, Түүний шавь нар болж, амьдралынхаа туршид Түүний ажлыг хийхээс илүү дээр төгсгөл гэж байхгүй. Өөр юу ч, бидний хийх өөр ямар ч сонголт Түүний хийж чадах зүйлийг хийж чадахгүй.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Хөлийнхөө доорх замыг хар,” *Лиахона*, 2014 оны 11-р сар, 88.



МАЦАГ БАРЬС- НААР БҮГД АДИСЛАГДДАГ

“Мацгийн хуулийг дагадаг хүмүүст ирдэг материаллаг болон сүнслэг гайхамшгуудын талаар би гэрчилмээр байна. . . . Та энэхүү ариун нандин боломжийг хамгийн багадаа сард нэг удаа эрхэмлэн дагаж, нөхцөл

байдал, боломжийнхоо хэрээр мацгийн болон бусад өргөлөө хүмүүнлэгийн болон боловсролын санд, мөн номлолын санд хандивлаж байгаарай. Бурхан таныг өгөөмрөөр адислах болно гэдгийг, мөн танаас тусламж авсан хүмүүс таныг адислагдсан нэгэн хэмээн дурсах болно гэдгийг би амлаж байна.”

Ахлагч Жэффри Р.Холланд “Бид бүгд гуйлгачид бус уу?” *Лиахона*, 2014 оны 11-р сар, 42.



ТАНД ЗОРИУЛСАН ХАРИУЛТУУД

Чуулган бүрээр бошиглогч болон удирдагчид Сүмийн гишүүдэд тулгарч болох асуултуудад сүнслэгээр нөлөөлөгдсөн хариултуудыг өгдөг. Эдгээр асуултад хариулт авахын тулд 2014 оны 11-р сард хэвлэгдэн гарах сэтгүүлийг ашиглах эсвэл conference.lds.org сайтад зочилно уу.

- Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ хэрхэн нэг байх билээ? Роберт Д.Хэйлс, “Бидний Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёрыг мэдэх нь мөнхийн амь мөн,” 80-р хуудсыг үзнэ үү.
- Гэрчлэл гэж юу вэ? Би үүнийг хэрхэн олж авах вэ? Крэг

К.Кристэнсэн, “Би өөрөө эдгээр зүйлийг олж мэднэ” 50-р хуудсыг үзнэ үү.

- Асуултынхаа хариултыг хайж байхдаа би юу хийдэг вэ? М.Рассэлл Баллард, “Завиндаа үлдэж, чанга зууран барь!” 89-р хуудсыг үзнэ үү.

АДИЛ ТӨСТЭЙ ЗҮЙЛҮҮДИЙГ ХАРЬЦУУЛАХ НЬ

АРИУН СҮМ

Заримдаа сайн мэдээний нэг сэдвээр олон хүн бидэнд хандан үг хэлдэг. Ариун сүмийн талаар 3 өөр хүн үг хэлснийг дор дурдав:

- “Бид ариун сүмээс сүнслэг удирдамж ба илчлэлтийг, бас амьдралын сорилт бэрхшээлүүдийг даван туулах хүчийг олж авч чадна.”—Линда К.Бертон эгч, “Хэзээ ч мэдэгдээгүй тийм маягаар бэлтгэсэн байв,” 111.
- “Бид ариун сүмийн сүнсээ хөгжүүлснээр Аврагчийн Цагаатгалын үнэн мөн чанар, хүч чадал, итгэл найдвар нь бидний хувийн амьдралд хэчнээн их ач холбогдолтой болох талаар суралцдаг.”—Нийлл Ф.Марриотт, “Өөрийн гэрлээс хуваалцах нь,” 117.
- “Хэрэв бид Бурханы бидэнд өгөөмрөөр өгдөг бүх адислалыг хүлээн авъя гэвэл биднийг дэлхийн зам ариун сүм рүү хөтлөх ёстой. Ариун сүмүүд бол Бурханы хайрын илрэл юм.”—Жийн А.Стивэнс, “Бурханы гэрээт охид,” 114.



Ерөнхий чуулганы үгсийг conference.lds.org-оос уншиж, үзэх эсвэл сонсох боломжтой.

ТҮҮНТЭЙ ХАМТ СЭРГЭГ БАЙХ ГАНЦХАН ЦАГ

Марица Гонзалез Эспехо

Би нэг өдөр ариун ёслолын цуглаан дээр үг хэлэхээр бэлтгэж байлаа. Би 2008 оны 3-р сарын *Лиакхона* дээр нийтлэгдсэн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холландын бичсэн “Есүс Христийн Цагаатгал” хэмээх өгүүлийг судалж байв. Ахлагч Холланд энэ өгүүлэлдээ Гетсеманий цэцэрлэгт Орсон Ф.Витнийн (1855–1931) Аврагчийг харсан нэгэн зүүдний талаар дурджээ. Ахлагч Витни Аврагчийн үүрсэн зовлон, шаналлыг харснаа дүрсэлсэн байна. Тэгээд тэрээр бичихдээ:

“Тэрээр удалгүй босож, төлөөлөгчдийн сөхөрч суугаад, гүн гэгч нь унтаж байсан газар руу очив! Тэрээр тэднийг зөөлнөөр утгарч, сэрээгээд аядуу зөөлөн хэрнээ зэмлэнгүй дуугаар та нар надтай хамт ганцхан цаг сэргэг байж чадсангүй гэж үү хэмээн асуужээ. . . .”

“Тэрээр нөгөө газартаа эргэн очиж дахин залбираад, буцаж төлөөлөгчид дээрээ очиход тэд мөн унтаж байлаа. Тэрээр дахин тэднийг сэрээгээд, тэднийг зэмлэж, урьдын газраа эргэн ирж залбирав. Тэрээр үүнийг гурван удаа давтсан юм.”¹

Намайг үүнийг унших үед илчлэлтийн сүнс миний оюунд орж

ирэв. Тэрхэн агшинд би ням гараг бүр ариун ёслолын цуглаанд ирэх нь “Түүнтэй хамт ганцхан цаг сэргэг байж” чадах арга зам болохыг ойлгосон юм. Түүнээс хойш энэ бол Тэнгэрлэг Эцэгтэй илүү утга учиртай залбирч болох цаг юм байна гэдгийг би мэдэж авсан. Залбирал нь бүх цаг үед чухал хэдий ч ариун ёслолын цаг дээр байдаг тэрхүү Сүнс нь Тэнгэрлэг Эцэгтэй болон Аврагч, Есүс Христтэй биднийг ойртуулдаг нэгэн боломж билээ. Бид санаа бодлоо

Их Эзэнд төвлөрүүлснээр бидний гэм нүглийг Өөр дээрээ авч, зовон шаналсан тэрхүү мөчид Түүнийг дагаж буй хэрэг юм. Энэ бол бидний төлөө зовж шаналсан Түүний шаналлыг хүлээн зөвшөөрөх цаг юм.

Ариун ёслолын цуглаан нь миний хувьд хамгийн чухал зүйл билээ. Энэ нь миний хувьд хязгааргүй авралын цаг юм. Энэ нь залбирал болон сүнсээр гэрээнүүдээ хүндэлж, Аврагчийн төгс жишээг дагахаа санаж, амлалт өгдөг ариун



ЭРГЭЦҮҮЛЭН БОДОХ, ХҮНДЭТГЭЛ БИШРЭЛТЭЙ БАЙХ МӨЧ

[Ариун ёслол] нь хүндэтгэл бишрэлтэй хийгээд хүчтэй эргэцүүлэн бодох цаг юм. Энэ нь сүнслэг мэдрэмж, өдөөлтүүдийг урамшуулан дэмждэг. Иймээс ариун ёслолыг яаруу тэвдүү гүйцэтгэж болохгүй. Ариун ёслолын цуглаан нь үүний жинхэнэ зорилгыг гүйцэлдүүлэхийн тулд “аль болох хурдан дуусгах” ямар нэгэн зүйл биш. Энэ нь ариун ёслолын цуглааны жинхэнэ зорилго биш юм. Эдгээр цуглааны турш хэлдэг үгс, дуулдаг дуу, эсвэл хийдэг залбирлууд нь бүгд энэхүү ариун ёслолын гүн хүндэтгэлтэй байдалд нийцсэн байх ёстой.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд, “This Do in Remembrance of Me,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 67.



нандин цаг болсон. Тэр амьд бөгөөд намайг хайрладгийг би мэднэ. Зөвхөн Түүний золиослолоор болон Түүний урсгасан үнэт цусаар дамжуулан бид бүгд аврагдаж чадна гэдгийг би мэднэ. Би “Түүнтэй хамт сэргэг байж” ажилласнаар миний ойлголт гэгээрч, амьдрал минь адислагдаж, Түүний оршихуй дахь мөнх амьдралын талаарх миний алсын хараа гүнзгийрсэн учраас энэ нь үнэн гэдгийг би мэднэ. ■

Зохиогч нь Перугийн Айсад амьдардаг.

ЭШЛЭЛ

1. Орсон Ф.Витни, Жэффри Р.Холланд, “The Atonement of Jesus Christ,”-ээс эш татав. *Liahona*, 2008 оны 3-р сар, 33.

АРИУН ЁСЛОЛ МИНИЙ АМЬДРАЛЫГ ХЭРХЭН ӨӨРЧИЛЖ ЧАДАЖ БАЙГАА ВЭ?

2012 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр Далын ахлагч Дон Р.Кларк “Хэрэв бид ариун ёслолд зөв бэлдэж чадвал ариун ёслол бидний амьдралыг өөрчилж чадна” гэж заасан юм. Тэрээр дараа нь “ариун ёслолоос зохистой хүртсэнээр бидний амьдралыг адисалж чадах 5 зарчмыг санал болгожээ.” Үүнд:

1. Есүс Христийн Цагаатгалд талархалтай бай.
2. Баптисмын гэрээгээ шинэчилж байгаа гэдгээ сана.
3. Нүглүүдээ өршөөгдсөнийг мэдрэхийг хичээ.
4. Тулгарсан бэрхшээлүүддээ шийдэл олохдоо сүнслэг удирдамж эрэлхийл.
5. Ариун Сүнсээр дүүргэгдэхийн тулд ариун ёслолоос зохистой хүрт.

Ахлагч Кларк: “Хэрэв ариун ёслолын турш сүсэг бишрэлтэй байж чадвал энэ нь үргэлж хамгийн агуу ариун ёслолын цуглаан байх болно”¹ гэж амлажээ.

ЭШЛЭЛ

1. Дон Р.Кларк, “Ариун ёслолын адислалууд,” *Лиахона*, 2012 оны 11-р сар, 104–06.

МӨНХИЙН ГЭР БҮЛД ХҮРГЭХ ЗАМ

Гарт Хамблин, Сэнди Хамблин нар

Акауолагийн гэр бүлийнхэн хөрвөгдсөн учраас тэднийг ариун сүмд явуулахаар тодорхойлсон юм.

Тонгагийн Сайпи Акауола шөнийн ихэнх цагийг найзуудтайгаа согтууруулах ундаа болон кава ууж өнгөрүүлсний дараа нэгэн ням гаргийн өглөө, гэр рүүгээ харих замдаа ням гаргийн хамгийн сайхан хувцсаа өмссөн нэгэн гэр бүлийг олж харжээ. Тэд хамт алхангаа инээлдэн, ярилцаж байлаа. Сайпи тэднийг юу ийм аз жаргалтай болгосныг гайхаж байлаа. Тиймээс тэр тэдний хаашаа явж байгааг мэдэхээр тэднийг даган явав.

Сайпи тэр гэр бүлийг хожмын үеийн гэгээнтнүүдийн Сүмийн байр руу орохыг харжээ. Тэр бусад хүний ирэхийг цонхоор харж байв. Гэр бүлүүд хамтдаа сууж, сүсэг бишрэлийн дуугаа дуулах үед тэдний нүүрнээс баяр баясгалан гэрэлтэж байлаа.

Сайпи эхнэр Люгийнхээ тухай бодож эхлэв. Тэднийг анх гэрлэж байх үеийн тэрхүү хайр бүдгэрэн сарниж байлаа. Сайпи тэрхүү хайраа эргүүлэн олж авахыг хүсэж байв. Тэр гэртээ яаран очиж, гэр бүлийг нь амжилтад хүрэхэд туслах арга замыг олсноо эхнэртээ хэлжээ. Тэд Сүмд орох хэрэгтэй байлаа.

Тэр өдөр Сайпи тосгоныхоо бишопынд очив. Бишоп Сайпиг гудамжинд согтуу байхыг харж байсан учир түүнийг таньжээ. Сайпи бишоптой ярилцаж байхдаа бишопын царайнд эргэлзээ төрөхийг олж харсан ч шийдвэртээ баттай итгэж байлаа. Тэр баптисм хүртэхийг хүсэж байгаагаа бишопт зоригтой хэлсэн


байна. Бишоп түр бодолхийлснээ Сайпиг орохыг урьж, түүнд Есүс Христийн сайн мэдээг зааж эхэлжээ.

Лю эхэндээ дурамжхан байсан ч нөхөр нь аажмаар сайжран өөрчлөгдөж байгааг ажиглажээ. Сайпи хүүхдүүдтэйгээ илүү их цагийг өнгөрөөж, үйлдлээрээ дамжуулан эхнэртээ болон гэр бүлдээ хайраа илүү ихээр харуулж байв. Тиймээс Лю ч бас номлогчдын хичээлийг авч эхлэн, удалгүй тэд хоёулаа баптисм хүртсэн байна.

Тэдний баптисмын нэг жилийн ой ойртоход Акауолагийн гэр бүлийнхэн ариун сүмийн гайхалтай адислалуудын талаар боддог болсон ажээ. Сайпо “Ариун сүмийн адислалууд нь баптисм хүртсэнээр бидний хүлээн авдаг тэдгээр адислалаас илүү агуу юм бол, ариун сүмийн адислалууд ямар байхыг төсөөл дөө” хэмээн хэлжээ. Тэдэнд лацдан холбогдох хүсэл байсан ч, Тонга дахь ариун сүмд засварын ажил хийгдэж байв. Тиймээс тэд ариун сүмд орохын тулд жил гаран хүлээх, эсвэл Шинэ Зеланд юм уу Фижи рүү өндөр өртөгтэй аялал хийх хэрэгтэй болжээ.

Тэд гэр бүлээрээ сайтар тунгаан бодож, юу хийх талаараа залбирав. Эцэст нь тэд багахан зээл авахаар шийджээ. Зээл нь батлагдахыг хүлээж байх үед тэдэнд зээл олгох гэж байсан банк нь галд шатсан байна. Бүх зээл нь дараа жил хүртэл хойшлогдов.


Сайпи, Лю хоёрын урам хутарав. Тэд зочны жижигхэн өрөөндөө



хамтдаа суугаад, гайхамшгийн төлөө залбирав. Тэднийг залбирч, хамтдаа зөвлөлдөх үед хариулт нь ирсэн байна. “Би оюун ухаандаа гэр бүлийн ачааны машинаа бидэн рүү инээмсэглэж байгааг харсан бөгөөд энэ бол бидний залбирлын хариулт гэдгийг мэдсэн юм” гэж Сайпи хэлжээ. Тэд маргааш нь тэр машинаа зарж, гэр бүлийнхээ таван хүнд Фижи рүү нисэх онгоцны тасалбар худалдан авах боломжтой болсон байна.

Тэд ядарсан гурван хүүхдийнхээ хамт Сува дахь ариун сүм рүү очих урт замыг туулж, Фижигийн Надид оройтож буув. Лю: “Биднийг Их Эзэний өргөөнд ойртон очихоор хичээх тусам Сатан адислал авахаас маань өмнө зогсоохоор хичээдгийг би мэдэж авсан” гэжээ.

Дараагийн алхмаа тодорхойлохоор онгоцны буудал дээр сууж байхад нь нэгэн эмэгтэй байрлах газраа болон маргааш нь илүү бага зардлаар Сувад хүрэх унаа олоход



нь тэдэнд тусалсан байна. Бурхан тэдэнд туслах тэнгэр элчийг илгээсэн гэж тэд боджээ.

Маргааш нь тэд ариун сүмд ирвэ. Лю: “Биднийг ариун сүмд орох үед би зүрх сэтгэлдээ амар амгаланг мэдэрсэн. ‘Би амьдралдаа хэзээ ч ариун сүмд байсан шиг цэвэр ариун, цагаан зүйлүүдийг харж байгаагүй. Хэрэв ариун сүм нь хүний гараар баригдсан өргөө бөгөөд энэ нь ийм үзэсгэлэнтэй сайхан юм бол, тэгвэл Тэнгэрлэг Эцэгийн бидэнд амладаг тэрхүү гэр орон нь хэчнээн гайхамшигтай байх бол!’ гэсэн бо-дол надад төрсөн” гэж ярьжээ.

Ариун сүмд олж авсан туршлага нь тэдний амьдралыг өөрчилсөн

байна. “Фижд өнгөрүүлсэн бүх цаг мөч нь биднийг гэсэн Тэнгэрлэг Эцэгийн хайрыг надад мэдрүүлсэн юм. Түүнийг дагахаар сонгох үед Тэр биднийг үнэхээр анхааран халамжилдаг” гэж Лю хэлэв.

Акауолагийн гэр бүлийнхнийг гэртээ эргэн ирсний дараа гайхамшигт адислалууд үргэлжилжээ. Сайпи, Лю хоёр хоёулаа коллежийн тэтгэлэг хүлээн авч, заах аргын зэргээ хамгаалан, Лиахона ахлах сургуульд ажиллахаар болжээ.

Тэд багшилж байх хугацаандаа амьдрах газар хэрэгтэй байсан хүүхдүүдийн талаар мэдэж авчээ. Хүүхдүүд заримдаа нэг нэгээрээ, заримдаа хоёр гурваараа

Сайпигийн гэр бүлийн хаалгыг тогшдог болсон байна. Сайпи, Лю хоёр тэднийг гэртээ оруулдаг байв. Тэдний жижигхэн гэр одоо 20 хүнтэй болсон. Тэдэнд коллежээ суралцахаар эсвэл номлолд үйлчлэхээр явсан өөр 5 “өргөмөл” хүүхэд бий.

Сайпи, Лю хоёр эдгээр хүүхдийг хайрлаж, тэдэнд урам зориг өгвөл тэд өсөж том болоод, амжилтад хүрэх болно гэдгийг мэддэг. Сүмийн гишүүн биш байсан хүүхдүүд сайн мэдээг хүлээн авсан бөгөөд одоо номлолд үйлчлэх хүсэл эрмэлзэлтэй болоод байна. Сайпи, Лю хоёр бүх хүүхдээ *өөрсдийнхөө* хүүхдүүдийг гэж боддог бөгөөд бүх хүүхэд нь Лю, Сайпи хоёрыг аав, ээж гэж дууддаг байна. Акауолагийн гэр бүлийнхэн маш их адислагдсанаа мэддэг бөгөөд эдгээр адислалаа бусадтай хуваалцахдаа баяртай байдаг ажээ. ■

Зохиогчид нь АНУ-ын Аляскийнх бөгөөд тэд Тонгад номлолд үйлчилж байна.



ГАЛТ ХОРХОЙ

Дэвид Райт

Бид мөнхийн шагналуудад анхаарлаа хандуулж байна уу, аль эсвэл өөр зүйлд үү?

Би хэдэн жилийн өмнө Гватемалын үзэсгэлэнтэй, алслагдсан хэсэг дэх мушгиран тахиралдсан Петексбатун голоор урт завиар л очих боломжтой, Агуатека гэх археологийн талбайд ажиллаж байв.

Би нэг орой хэдэн археологичтой хамт ойролцоох талбай дээр очин, бүтэн өдрийг өнгөрүүлсний дараа Агуатека руу буцаж явлаа. Би моторын намуухан хүнгэнэх дуу, завины ар талд шавжны цар цар хийх чимээн дунд голыг өгсөн, завиар сэлж явах үедээ саргүй атлаа ер бусын гэрэлтэй тэр шөнө амар тайван аялж яваадаа сэтгэл сэргэн, завиа налан сууж явав. Завь голын тахиралдсан нугачаан дундуур өнгөрөх үед, би Алтан гадас одоор баримжаалан зүг чигээ олохыг хичээж байлаа. Алтан гадас од заримдаа голын эрэг дагуух моддын харанхуй сүүдэрт орж, харагдахгүй болсноо хэсэг хугацааны дараа дахиад л үзэгдэнэ.

Голын нэг тохой дээр гараад, би модны орой дээгүүр харагдаж байсан Алтан гадас одыг дахиад л алдчихлаа. Завь өмнө зүг рүү эргэхэд би сайхь одыг тэр дор нь олж хараад, зүг чигийг баримжаагаар олдог туршлагатай далайчных шиг чадвартаа их л маадгар байв. Гэтэл би нөгөөх одыг минут хэртэй ажиглаад, андуурснаа сая л ойлгож билээ. Би Алтан гадас одыг, тэр ч байтугай өөр ямар ч одыг хараагүй, харин галт хорхойг од гэж андуурсан байв.

Миний дээгүүр харагдаж байсан “оддоос” олон нь хэрэг дээрээ шөнийн дулаахан тэнгэрт чимээгүйхэн

эргэлдэн нисэгч галт хорхойнууд байсныг би мэдсэн юм. Гайхалтай нь, дээгүүр нисэж байсан хэдэн арван галт хорхойн сүүмийсэн гэрэл нь алс холын ододтой болон оддын бөөгнөрлийн сүүмийсэн гэрэлтэй тун адилхан харагдаж байв. Голын тохойнууд дээр завь эргэх үед энэхүү галт хорхойнуудын гэрлийг од гэж андуурах нь амархан ажээ.

“Би өчүүхэн жижиг галт хорхойнуудыг хэрхэн бараг төгсгөлгүй үргэлжлэх хурц тод гэрэлтэй од гэж андуурав аа” хэмээн гайхан бодов. Хариулт нь тодорхой байлаа. Ердөө алс холын зайнаас л болсон ажээ. Галт хорхойнууд миний дээгүүр хэдхэн метрийн өндөрт байсан бол одод маш хол зайтай байсан учир галт хорхойнуудын харьцангуй бүдэгхэн сүүмгэр гэрэл оддын гэрэл шиг л харагдаж байв. Миний талаас оддын гэрэл, галт хорхойнуудын гэрэл хоёр бараг адилхан харагдаж байлаа.

Галт хорхойнуудын адил уруу таталт, сорилт бэрхшээлүүд бидэнд

ойрхон байдаг учир том юм шиг харагддаг. Энэ үед амлагдсан адислалууд одод шиг маш хол харагдаж болно.

Бид сүнслэг байдлын хувьд харалган байх нь олон үр дагавар авчирна. Бид шагнал хол харагдах тусам наманчлалын өдрөө хойшлуулж, Тэнгэрлэг Эцэгтээ эргэн очиж, мөнхийн өв залгамжлалаа хүртэх эрхтэй байсаар байх болно хэмээн бодож уруу татагддаг (Алма 34:33–34-ийг үзнэ үү). Бид мөнхийн шагналдаа эргэлзэх юм уу, хожим нь ирэх адислалуудыг хүлээхийн оронд эгэл хүнээ зугаацуулахаар сонгож болно. Бид нүглийн эсрэг байнга, насан туршдаа тэмцэх тэмцлээс айж, эсвэл Сатаны тамлалаас хол байхад Аврагч бидэнд туслах болно гэдэгт итгэх итгэл дутагдаж болно.

Заримдаа бид бүгд үүрд мөнхийн алсын хараагаа алддаг. Аль болох хурдан үүнийгээ эргүүлэн олж авах нь сорилт юм. Дэлхий анхаарал татахуйц, хуурамч шагналлуудыг санал болгож мэдэх ч амьдралын нугачааг болон эргүүлүүдийг гатлах үедээ Есүс Христэд найдаж, “Өөрийг нь хайгч хүмүүст Тэр шагнагч нь болдог” (Еврей 11:6) гэдэгт үнэхээр итгэх ёстой.

Би тэр голоор завиар аялнаас хойш олон жил өнгөрсөн ч, бүр өнөөдөр ч гэсэн уруу таталтууд тулгарах үед хэсэг бодож үзээд, “Энэ бол галт хорхой” гэж өөртөө сануулдаг болсон. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Флоридад амьдардаг.



БАГШДАА ӨГСӨН ТӨМС

Бонни Далсрад

Үйлчлэл хийх бүрдээ том бэлэг өгөх шаардлагагүй юм байна гэдгийг би сурч авсан юм.

Хайраар өгсөн л бол өчүүхэн бэлэг ч байсан, сайхан байдаг.

Би 25 гаруй жил бага сургуульд багшлах хугацаандаа сурагчдаасаа олон сонирхолтой зүйл авч байна. Нийтлэг бэлэгнүүд нь гэнэн цайлган үгстэй зурвас, гар зургууд болон урнаар сэтгэсэн гар урлалын бүтээлүүд байдаг. Гэвч өнгөрсөн жил би анх удаа төмс авсан юм.

Эмма миний ширээ рүү хүрч ирээд, “Надад алим байхгүй” учраас би “багшдаа төмс өгнө” гэж бахархалтай хэлэв. Энэ нь дунд зэргийн хэмжээтэй, цэвэрхэн хальсалсан, ердийн л сайхан төмс байв. Би Эммад талархал илэрхийлээд, төмсөө ширээн дээрээ тавилаа. Тэр өдрийн турш Эмма үүнийг харах бүрдээ түүний цэнхэр нүд гэрэлтэж байгааг би олж харсан юм.

Би хичээл тарсны дараа, ширээн нийхээ ард суугаад ажиллаж байхдаа зөөлхөн инээмсэглэн, төмсний талаар бодохгүй байж чадсангүй. Хүүхдүүд аливаа зүйлийг ердийн төмс мэт ийм л энгийнээр, дамжуулан хардаг. Эмма үүгээр надад нэг чухал зүйлийг заасан юм. Энэ нь надад ямар нэг зүйлийг сануулж байсан учир би тэр төмсийг долоо хоног гаруй ширээн дээрээ байлгасан билээ.

Тойргийн айлчлагч багшийн хувьд, мөн эгчийн хувьд би бусдад

үйлчлэхийг хүсдэг байсан. Гэвч би бусдад туслах цаг гаргахаасаа өмнө үйлчлэл хийх боломжийг л эрж хайдаг байлаа. Хэрэв би завгүй байгаад илүү хучмал хийж чадаагүй, эсвэл хэн нэгэнд гоё цэцэг бэлэглэхийг хүссэн ч цэцгийн дэлгүүр яваагүй бол миний тусламж хэрэгтэй хэн нэгний талаар шивнэж буй Сүнсний намуун, зөөлөн дуу хоолойг үл анзаардаг байх байсан.

“Цаг гарвал би энэ долоо хоногийн амралтын өдрүүдэд ямар нэгэн зүйл хийнэ. Гэхдээ өнөөдөр хэн нэгэнд миний тусламж хэрэггүй байх” гэж өөртөө итгүүлдэг байлаа.

Харин хэн нэгэнд миний тусламж үнэхээр хэрэгтэй байсан бол яах вэ? Хэрэв би ахмад настай хөршийндөө эсвэл саяхан нөхрөө алдсан залуухан бэлэвсэн эхнэр

дээр очих Сүнсний өдөөлтийг хайхраагүй өнгөрүүлсэн бол яах байсан бол? Би өөрт байгаа зүйлээрээ, төмсөөр ч болов тусалж, эсвэл түүнд үйлчилж чадах байсан болов уу?

Би Эммагаас үйлдэл хийхийн тулд шаргуу хичээх хэрэгтэй гэсэн нэгэн агуу сургамж авсан юм. Хэрэв алим байхгүй бол оронд нь төмс өг, тэгэхдээ яг одоо өг. Би хучмал эсвэл нимбэгний цэцгийтэй боов тусгайлан хийхээр хүлээдэггүй, харин оронд нь нэг хайрцаг жигнэмэг худалдан авдаг. Би ихэнхдээ цэцгийн дэлгүүр явдаггүй, харин цэцэггүй ч гэсэн түр ярилцахаар зочилж очдог. Гараар бичсэн ил захидал чухал хэдий ч утсаар ярих нь илүү хурдан. Үйлчлэл хийх бүрдээ том бэлэг өгөх шаардлагагүй. Хайраар өгсөн л бол өчүүхэн бэлэг ч гэсэн сайхан байдаг.

Нөгөөх төмсийг би гэртээ авчирсан ч үүнийг хэзээ нэгэн цагт иднэ гэж бодохгүй байна. Энэ нь үйлчлэх хэрэгтэй гэж Сүнсээр өдөөгдсөн үед надад байнгын сануулагч болдог. Би дараа гэж хүлээхийн оронд яг одоо чадах зүйлээ өгдөг. Багшдаа өгсөн тэр төмс хамгийн сайхан бэлэг байсан. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.



СҮМИЙН МЭДЭЭ

Сүмийн мэдээ болон үйл ажиллагаануудын тухай news.lds.org-оос үзнэ үү.

Семинарын суралцагчдыг илүү сайн суралцахад дэмжих шаардлагууд

Семинарыг төгсөхөд шаардагдах шинэ шаардлагууд Сүм даяар хэрэгжиж эхэлж байгаа бөгөөд энэ нь суралцагчдын “суралцахуйг өндөрт гаргах”-д нь туслах юм. Сургаал ба Гэрээг болон Сүмийн түүхийг судлах энэ жилийн хичээлийн эхнээс хэрэгжиж эхэлсэн энэхүү шаардлага нь үндсэн хоёр хэсэгтэй:

1. Семинарын суралцагчид тухайн жилд судлах судраа уншихаас гадна хичээлд хамрагдсан ирцээ хангах болон өөрсдийн

Өмнөд Америкийн Гайана дахь семинарын суралцагчид хамтдаа судраас суралцаж байна.



бишопын юм уу салбарын ерөнхийлөгчийн гарын үсгийг авах шаардлагатай болсон. Өмнө нь судар уншихыг чухалчлан үздэг байсан бол одоо энэ нь төгсөлтийн нэг шаардлага болж байгаа юм.

2. Суралцагчид жилийн турш суралцахуйн үнэлгээний 2 шалгалтыг 75 хувиас дээш дүнтэй өгсөн байх шаардлагатай. Нэг дэх үнэлгээг жилийн эхний хагаст, хоёр дахийг жилийн сүүлийн хагаст авсан байх хэрэгтэй. Үнэлгээг гол нь сургаалын талаарх ойлголтоор болон өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний зарчмуудыг хэр хэрэгжүүлж байгаагаар нь дүгнэж өгнө.

Семинарын шинэ шаардлага нь *Миний сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлд зориулсан удирдамж* болон Ням гаргийн хичээл дээр хэрэглэх *Ирээд, Намайг дага* өсвөр үеийнхэнд зориулсан гарын авлагуудтай хамт өсвөр үеийнхэнд өөрсдийн гэрчлэлд илүү итгэлтэй болж, сайн мэдээний тухай ойлголтоо гүнзгийрүүлэхэд, мөн мэдлэгээ бусадтай хуваалцах чадвар нь сайжирснаар үйлчлэлд болон дагалдагчийн амьдралд бэлтгэх явцад нь туслах болно.

Жил бүрийн эцэст суралцагчид зайлшгүй шаардлагуудыг (судар унших ба үнэлгээнүүдийг оролцуулан) хангасан эсэхийг нотлох гэрчилгээ эсвэл хамрагдсан болохыг нотлох гэрчилгээ авах болно. ■

Индексжүүлэх уриан дор дээд амжилт тогтоов

Олон улсын индексжүүлэх уриан дор оролцогсад нэг өдөрт онлайн оролцсон индексжүүлэлтэд оролцсон хүмүүсийн тоогоор шинэ дээд амжилт тогтоов. 2014 оны 7-р сарын 22-нд түүхэн бичээсийн дүрсүүдийг үзэж, мэдээллүүдийг нь FamilySearch.org дээрх хайлт хийж болдог мэдээллийн санд шивэн оруулахаар нийт 66511 сайн дурынхан интернэтэд оржээ. Өмнө нь 2012 оны 7-р сард Америкийн Нэгдсэн Улсын 1940 оны хүн амын тооллогыг индексжүүлэх нэг өдрийн ажилд 49025 хүн оролцсоноор дээд амжилт тогтоогоод байсан юм.

Мөн уг уриан дор нийтдээ (индексжүүлсэн эсвэл зөв бурууг тогтоосон) 5.7 саяас илүү бүртгэлийг оруулсан нь хоёр дахь дээд амжилтыг үзүүлсэн байна. (Бүртгэл бүрийг хоёр сайн дурын хүн индексжүүлж, дараа нь ажлын чанар, мэдээллийн үнэн зөвийг шалгах арбитр хэмээн нэрлэгдсэн гурав дахь сайн дурын хүн хянадаг.)

“Манай гишүүд хөгшин, залуугүй бүгдээрээ баяр баясгалантай оролцсон” хэмээн Францын Тулуз дахь бишоп Кроует хэллээ. “Ямар сайхан зүйл байв аа.”

“Манай эцэг эх, таваас 18 насны долоон хүүхэд бид бүгд хамтдаа индексжүүлэх ажил хийж болохын тулд гэр бүлийн үдэш зохион байгуулсан. Гэр бүлээрээ бид нийт 900 гаруй бүртгэлийг индексжүүллээ” хэмээн Уэйлсийн Кристофер Жонс ярилаа.

Тайландын Бангкок хотын Натали Терри 13 настай охинтойгоо дэлхий дахины нэг өдрийн индексжүүлэх ажилд оролцсондоо баяртай байгаагаа хэлэв. Мөн Английн Чорлей хотын Крис Шийд “баптисм хүртсэнийхээ дараахан нас барж, хүн амын тооллогуудын хооронд бүртгэгдэлгүй орхигдсон бяцхан охиныг” болон гэр бүлийнхээ 30 орчим шинэ нэрийг олох боломжтой байснаа хэлсэн юм. ■



Ахлагч Дэвид А.Бэднар олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь сайн мэдээг хуваалцах өвөрмөц боломжийг олгодог хэмээн хэлсэн юм.

Төлөөлөгч олон нийтийн мэдээллийн хэрэгслийн талаар зөвлөж байна

“Би та нарыг яг энэ өдөр, энэ газраас эхлэн зөв шударга, үнэнээр дүүрэн, бодит, сургамжтай бөгөөд магтууштай захиасаар дэлхийг дүүргэхэд, чухамдаа үер мэт дэлхийг бүрхэхэд уриалан дуудаж байна” хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар 2014 оны 8 сарын 19-нд Бригам Янгийн Их Сургуулийн Боловсролын долоо хоног дээр үг хэлэхдээ хэлсэн юм.

Тэрээр мөн олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан үнэнийг түгээх талаар онцлон хэлсэн үгэндээ “Бид түргэн өсөж, дараа нь гялс урсан алга болох зурвасхан үерт оролцогсад бүү байгаасай хэмээн би залбирч байна” гэлээ. Ахлагч Бэднар бидний цаг үеийг “авралын ажлыг хөнгөвчлөн, хурдасгасан шинэ нээлт ба бүтээлүүдийн гайхалтай хөгжил дэвшлээр” адислагдсан “дэлхийн түүхийн онцгой улирал” хэмээн нэрлэсэн юм.

“Дэлхий дахинаа үйлчилж буй номлогчдын ойролцоогоор 40 хувь нь удахгүй электрон төхөөрөмжүүдийг хөрвөгдөх, идэвхтэй үлдээх мөн эргэн идэвхжүүлэх ажлын багаж хэрэгсэл болгон ашиглах болно” гэлээ. “Бид бүхэн мөн техник технологи хэрхэн гэр бүлийн

түүхийн болон ариун сүмийн ажлыг, мөн хувиараа болон гэр бүлээрээ сэргээгдсэн сайн мэдээг судлах явцыг хурдасгаж, гайхалтай арга замаар дэлхий ертөнцийн талаар суралцах, судлах, танин мэдэх боломжийг бидэнд олгож байгааг харж байгаа гэдэгт итгэлтэй байна.”

Тэрээр мөн саяхан олон нийтийн мэдээллийн хэрэгслийг хичээл зүтгэл гарган ашигласнаар Христийн амилсны баярт зориулан Сүмийн бүтээсэн *Түүний учир* видео бичлэгийг 191 улс орон, газарт таван сая гаруй удаа үзсэн мөн #didyouthinktopray (#чизалбирахыгбодовуу) гэсэн шошго залбирах хэрэгцээний талаар 40000 сэтгэгдэл цуглуулсан тухай онцлон тэмдэглэв.

Эдгээр болоод бусад хүчин чармайлт нь “ердөө л жижигхэн урсгал” хэмээн тэрээр хэлсэн бөгөөд “урсгалыг үер болгон өөрчлөхөд туслахыг” хожмын үеийн гэгээнтнүүдээс хүслээ. Тэрээр мөн олон нийтийн мэдээг ашиглах талаар хэлэхдээ:

- “Бид өөрсдийгөө дөвийлгөж, хэтрүүлэн, худлаа чимэглэж, байгаагаасаа өөр нэгний дүрд орж тоглох ёсгүй. Бидний хуваалцаж буй зүйлс үнэнийг илэрхийлсэн, мөн бүтээлч байх ёстой.”

- “Бидний захиас маргаан, мэтгэлцээн, зэмлэл юм уу доромжлолын оронд сургамжтай, урам зориг өгсөн байхыг эрэлхийлэх ёстой.”
- “Зоригтой, тууштай бай. Гэхдээ өөрсдийн итгэлийг хамгаалахдаа бусдад дарамт болохгүй байж, маргаанаас зайлсхий. Дагалдагчийн хувьд бидний зорилго бол олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний гэрэл ба үнэнийг харуулахад ашиглах ёстой.”
- “Техник технологийг зохисгүй ашигласнаар дэндүү их цагийг дэмий үрж, асар олон нөхөрлөлийг эвдэж эсвэл сүйтгэж, мөн зөв шударгын үнэт замналуудыг тасдан хаяж магадгүй юм. Хэдийгээр олон нийтийн мэдээллийн хэрэгслийг зөв ашигладаг байсан ч гэсэн бидний цаг зав, хүч чадал, нөөц боломжуудыг илүү сайн бөгөөд хамгийн сайнаар ашиглах байдлыг маань орлон, ноёрхох боломжийг бид олгох ёсгүй.”
- “Бид олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэргэжилтэн, эсвэл хэт шүтэгчид болох хэрэггүй. Мөн бид сайтар боловсруулсан захиасуудыг оруулан, нийтлэхэд замбараагүй их цаг хугацааг зарцуулах хэрэггүй” гэлээ. ■

*Та нар дэлхийд гэрэл байж, Бурханы
хүүхдүүдийг аврахад туслан, баяр
баясгалантай байхаар, мөн хамгийн
чухал нь мөнх амьдралын адислалуудыг
олж авахаар сонгох болтугай.*





Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын
ахлагч
Рассэлл М.Нэлсон

ТА НАР ЮУГ СОНГОХ ВЭ?

*Та нар энэ цаг үед газар дэлхий дээр Бурханы
хаант улсыг байгуулан, Аврагчийг хүлээн авахад
хүмүүсийг бэлтгэх үүргийг Тэнгэрлэг Эцэгээс
хүлээсэн билээ.*

“Язгууртан гаралтай өсвөр үеийнхэн”¹ та нар бол үнэндээ дэлхийн түүхэн дэх хамгийн ариун нандин зорилгын төлөө энэ цаг үед төрсөн Бурханы охид, хөвгүүд юм. Дэлхийд хаа сайгүй нийгмийн ёс суртахууны болон шашны үнэт зүйлс доройтож буй мэт санагдавч энэ сүмийн өсвөр үеийнхэн та нар бусад хүнийг Их Эзэнд ойртуулах Түүний төлөөлөгчид ба гэрэлт цамхаг нь билээ. Та нарын зорилго болон хэн гэдэг тань үнэхээр онцгой юм.

Та нар хэн бэ? Та нар бол “Чиний үр удмаар газар дэлхийн бүх үндэстэн адислагдах болно” (Үйлс 3:25; 1 Нифай 15:18-ыг мөн үзнэ үү; 3 Нифай 20:25) хэмээн эцэг Абрахамд амлах үед Бурханаас Түүнтэй хийсэн тэрхүү гэрээний хүүхдүүд юм. Та нар түүнчлэн бүх гараг ертөнцөөр сайн мэдээ түгэн дэлгэрэх дэлхийн түүхийн энэ үед “амлагдсан өдрийн хүүхдүүд”² билээ.

Та нарын зорилго юу вэ? Ах нар та бүхэн санваарыг атгахаар мөнх бус байдлын өмнөх дэлхийд урьдчилан томилогдсон билээ (Алма 13:2–3-ыг үзнэ үү). Харин хайрт эгч нар, та нар Бурханы хүүхдүүдийг төрүүлж, асран халамжлахаар дэлхийн сууринаас өмнө сонгогдсон бөгөөд үүнийг хийснээр та нар Бурханыг алдаршуулдаг (С ба Г 132:63-ыг үзнэ үү). Эгч нар аа, та нар Бурхантай хамтран бүтээгчид байх гэдэг нь үнэхээр юу гэсэн үг болох талаар өмнө нь бодож байсан уу?

Залуу эрэгтэй, эмэгтэйчүүд та нарын хүн нэг бүр энэ цаг үед газар дэлхий дээр Бурханы хаант улсыг барьж байгуулан, мянган жилд Мессиа захирч, засаглах үед Аврагчийг хүлээн авахад хүмүүсийг бэлтгэх үүргийг Тэнгэрлэг Эцэгээс хүлээсэн билээ. Та нарын язгууртан гарал, хэн болох, зорилго болон тэнгэрлэг үүрэг нь та нарыг бусад бүх хүнээс өөр болгодог.

Гэхдээ та нарын язгууртан гарал эсвэл өмнөх дэлхийн томилолтууд ба үүрэг даалгавруудын аль нь ч таныг аварч, өргөмжилж чадахгүй юм. Та нар хувь хувьдаа гаргах шийдвэрүүдээрээ болон амьдралдаа Их Эзэний Цагаатгалын хүчийг хүлээн авахаар сонгосноор аврагдаж мөн өргөмжлөгдөх боломжтой болдог. Сонгох эрхийн агуу мөнхийн зарчим нь Эцэгийн төлөвлөгөөнд амин чухал юм. Тиймээс, язгууртан гаралтай өсвөр үеийнхэн та нар юу сонгох вэ?

Та суралцан өсөж хөгжихийг сонгох уу?

Боловсрол бол таны л олж эзэмших зүйл юм. Хэн ч таны өмнөөс үүнийг эзэмшиж чадахгүй. Та нар хаана ч байлаа гэсэн суралцах маш их хүсэлтэй бай. Хожмын үеийн гэгээнтэн бидний хувьд боловсрол олж авах нь зөвхөн эрх мэдэл биш юм, энэ бол шашны үүрэг хариуцлага билээ. “Бурханы алдар суу бол оюун билэг юм” (С ба Г 93:36). Үнэндээ, бидний боловсрол бол үүрд мөнхөд үргэлжлэх зүйл билээ.

“Бид энэ амьдралд оюун билгийн ямар ч түвшинд хүрлээ гэсэн, энэ нь амилуулалтад бидэнтэй хамт сэргэн босох болно.

Мөн хэрэв хүн . . . мэдлэг мөн оюун билгийг энэ амьдралд хуримтлуулах аваас, тэрээр ирэх дэлхийд маш их давуу талтай байх болно” (С ба Г 130:18–19).

Иймэрхүү алсын хараатай ойлголт нь суралцах талаар сайн сонголт хийхэд тань туслах болно.

Ах, эгч нар аа, зорилгодоо—тэр бүү хэл мөрөөдөлдөө хүрэхээр хичээхээсээ бүү ай! Аливаа зүйлийг хамгийн сайн, бүрэн гүйцэд хийж сурахад амар дөт зам гэж байдаггүй. Боловсролтой болох нь бусад хүнд туслахыг хүсэх болон тэдэнд туслах боломжтой *байх* хоёрыг ялгаатай болгодог юм.

Та ямархуу маягаар амьдрахыг сонгох вэ?

Та нар бусдаас өөрөөр амьдрах хэрэгтэй. Та нар Паул залуу Тимотод: “Чи итгэгч хүмүүст үг, зан байдал, хайр, итгэл хийгээд цэвэр ариун байдлаараа үлгэр дууриал бол” (1 Тимот 4:12)³ гэж хэлснийг мэднэ. Дэлхийн хүмүүсээс өөрөөр бодож мөн өөрөөр үйлдэхийг сонго. Өөрөөр харагдаж, өөрийнхөө бий болгох сайн нөлөөг харахыг сонго. Ардэт Г.Карр эгч нэг удаа “Хэрэв та далайн эрэг дээр байгаа бусад усанд сэлэгч шиг харагдаж байвал аврагч болж чадахгүй!”⁴ гэж хэлжээ.

Язгууртан гаралтай өсвөр үеийнхэн учраас та нарын амьдралд агуу эхлэл байна. Гэхдээ та нарт бас нэмэлт

үүрэг хариуцлага бий. “Учир нь их нь өгөгдсөн түүнээс их нь шаардагдах буюу” (С ба Г 82:3; мөн Лук 12:48-ыг үзнэ үү). Тэрхүү шаардлагын нэг хэсэг нь элсэгч болох явдал юм. Та нар өөрсдийгөө армийн элсэгч гэж бодож байсан уу? Та нар баптисм хүртсэнээр үнэн хэрэгтээ Их Эзэний армид элсэн орсон.⁵ Өмнөх дэлхийд байхдаа та нар Тэнгэрт Дайн болоход Есүс Христийн талд зогсож байсан билээ. Одоо ч гэсэн сайн ба муу хүчний хоорондох зөрчил энэ дэлхий дээр үргэлжилсээр байна. Энэ нь бодит юм! (Илчлэлт 12:7–9; С ба Г 29:40–41-ийг үзнэ үү). Есүс Христ Бурханы талд бөгөөд дэлхийн Аврагч байхаар урьдчилан томилогдсон билээ (1 Нифай 10:4-ийг үзнэ үү.) Харин Сатан нөгөө талд байгаа бөгөөд эсэргүүцэгч, сонгох эрхийг устгагч юм (Моце 4:3).⁶

Та нар энэ мөнх бус дэлхийд байхдаа муугаас илүүгээр сайныг сонгож, наманчилж, Есүс Христэд ирж мөн Түүний сургаалд итгэн, Түүний үлгэр жишээг дагахдаа сонгох эрхээ ашиглаж болохын тулд Бурханы төлөвлөгөө нь дайсанд та нарыг уруу татахыг зөвшөөрдөг билээ. Ямар агуу үүрэг хийгээд итгэл найдвар билээ!

Өөрсдийнхөө төлөө үйлдэх та нарын эрх чөлөө нь та бүхний мөнхийн өсөлт хөгжил болон аз жаргалын гол хэсэг бөгөөд дайсан үүнийг тань сулруулахаар бүхий л хүч чадлаа дайчлан ажилладаг (2 Нифай 2:27; 10:23-ыг үзнэ үү).

Та нар амьдралдаа сонголт хийхэд туслах эн тэргүүнд тавих зүйлүүдээ тодорхойлсон уу?

Та нарын сонголтууд бүгд сайн, муугийн хооронд байхгүй байж болно. Олон сонголт нь хоёр сайн зүйлийн аль нэгийг сонгох байж болно. Бүх үнэн адилхан ач холбогдолтой байдаггүй. Тиймээс, та нар эн тэргүүнд эрхэмлэх зүйлүүдээ тодорхойлох хэрэгтэй. Та мэдэлтэй болохоор эрэлхийлэх үедээ сурч чадах хамгийн чухал үнэн нь Их Эзэнээс ирдэг болохыг мэд. Бусдын төлөө Эцэгтээ хандсан залбирлаараа Аврагч үүнийг баталсан. Тэрээр хэлэхдээ “Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн” (Иохан 17:3) гэжээ. Та нар суралцахаар хичээж байгаа бүх зүйлээсээ илүүтэйгээр Тэнгэрлэг Эцэг, Бурхан болон Түүний Хүү Есүс Христийг мэдэхийг эрэлхийл. Тэднийг таньж мэдэн, миний адилаар Тэднийг хайрла.

Амьдралын минь турш надад тусалсан эн тэргүүнд тавих зүйлсийн талаарх бас нэгэн судрын нэг бол энэ юм: “Эхлээд та нар Бурханы хаант улсыг байгуулж, Түүний зөв шударгыг тогтоохоор эрэлхийл дараа нь эдгээр зүйлүүд та нарт нэмэгдэн өгөгдөх болно” (Матай 6:33).

Энэ дэлхий дээрх өөр юунаас ч илүүтээр мөнх амьдралын хамгийн дээд мөн алдар суут хувь тавиланд таныг удирдах сонголтууд хийхийг та хүсэх болно. Энэ бол танд зориулсан Бурханы агуу алдар суу юм (С ба Г 14:7; Моце 1:39-ыг үзнэ үү). Мөнх амьдралыг хамгийн чухал хийгээд эн тэргүүний зүйлээ болгон сонго! Мөнх



*Олон хүн тэнгэр-
лэг үнэнийг хараа-
хан олоогүй байдаг
бөгөөд үүнийг хаа-
наас хайхаа ч
мэддэггүй. Гэх-
дээ язгууртан
гаралтай өсвөр
үеийнхэн та нар
тэднийг аврахаар
ирж байгаа билээ.*

амьдралыг сонгодог болон сонгодоггүй тэдгээрийн хүлээж авах адислалуудын ялгааг илүү сайн ойлгохын тулд Сургаал ба Гэрээний 76-88-р хэсгүүд дэх судрыг судал. Мөнх амьдралыг хамгийн чухал хийгээд эн тэргүүний зүйлээ болгон сонго, тэгээд бусад сонголтыг хийхэд хэрхэн амархан болж байгааг ажиглаарай.

Та нар хэнтэй харилцаатай байхаар сонгох вэ?

Та нар Бурханд итгэдэг олон сайн хүнтэй харилцах болно. Еврей, католик, протестант эсвэл лалын шашинтай байхаас үл хамааран тэр итгэгчид цорын ганц үнэн байдгийг мэддэг. Бурханд итгэгчид нь эмээх сэтгэлтэй байдаг. Итгэгчид сайн дураараа иргэний болон тэнгэрлэг хуулиудыг тэр байтугай дагахыг хүчилдэггүй хуулиудыг ч гэсэн дагадаг.

Иргэний болон тэнгэрлэг хуулиудыг дагах амалтынхаа дагуу та нар эргэн тойронд тань ямар ч машин байхгүй байсан ч улаан гэрэл асахад зогсдог. Бурханы хүүхдүүдийн хувьд та нар цагдаа таныг баривчлахгүй ч гэсэн хулгай хийх, хүн алах эсвэл завхайрах зэрэг үйлдэл нь буруу бөгөөд Бурхан эцэст нь тантай хариуцлага

тооцох болно гэдгийг мэддэг билээ. Дүрмийн дагуу тоглоогүйн үр дагаврууд нь зөвхөн мөнх бус амьдралд төдийгүй, мөнх амьдралд хамаатай гэдгийг та нар мэддэг билээ.

Та нар амьдралын аялаа үргэлжлүүлэх явцдаа Бурханд итгэдэггүй хүмүүстэй танилцах болно. Тэдний ихэнх нь тэнгэрлэг үнэнийг хараахан олоогүй байдаг бөгөөд үүнийг хаанаас хайхаа ч мэддэггүй. Гэхдээ язгууртан гаралтай өсвөр үеийнхэн та нар тэднийг аврахаар ирж байгаа билээ. Бурханы бошиглогчийн илүү олон номлогчийг дуудсан дуудлагад та нар маш олноороо хариулж байна. Үүнийх нь төлөө номлогчдоод бид маш их талархаж байна.

Үл итгэгч хүмүүстэй харилцах үед, магадгүй тэдний цөөн хэд нь таныг үл тоомсорлоно гэдгийг ойлгоорой (С ба Г 1:16; 89:4-ийг үзнэ үү). Та нар үүнийг таньж мэдэнгүүтээ тэднээс хурдан, бүрмөсөн зугт (1 Тимот 6:5–6, 11-ийг үзнэ үү).

Эдүгээ харамсалтай нь, аз жаргал мэт санагддаг ямар нэгэн зүйлийг хайх тэдний цөхөрсөн эрэл хайгуул нь нүгэл рүү хальтруудаг тийм хүмүүстэй ч та нар таарах

болно. Ийм нүгэл рүү хальтирахаас сэрэмжил! Нүглийн зугаа цэнгэл нь богино хугацаанд үргэлжилдэг бөгөөд оюун санаанд үлдсэн дурсамжуудыг үргэлжийн зовиур болоод гэм буруутайн гэмшил дагаж байдаг. Хууль бусаар дэр нэгтгэж, хамтран амьдрах нь нөхөр, эхнэр хоёрын бурханлаг нэгдлийг мушгин гуйвуулсан хуурмаг зүйл юм. Хууль бус зүйлүүд гүн гүнзгий мэдрэмж, дотно сайхан дурсамжийг арчдаг билээ.

Та эрх чөлөөг сонгох уу эсвэл боолчлолыг сонгох уу?

Бурханлаг бус хүчнүүд бидний эргэн тойронд байна. Та нар үнэндээ “дайснаар бүслэгдсэн бүсэд” амьдарч байгаа билээ.”⁷ Порнографын хорт тахал энд тэндгүй байгаа бөгөөд аюулт атганд нь орох хэнийг боловч барин авдаг.

Их Эзэн үүнийг урьдчилан харсан бөгөөд энэ талаар “Мөн эдүгээ би та нарт нэг нууцыг, улирах цагийн явцад бүр та нарын устгалыг тохиолгон авчрах нууц өрөөнд байгаа нэг зүйлийг үзүүлье, мөн та нар үүнийг мэдсэн нь үгүй” (С ба Г 38:13; мөн 28-р шүлгийг үзнэ үү) гэжээ.

Хэчнээн ч олон нууц хуйвалдаанд хэдэн ч хүн та нарын амьдрал, аз жаргалыг устгахаар эрэлхийлж байгаа юм билээ гэдгийг бодоод үз дээ! Бэлгийн харьцааны уруу таталт нь шинэ зүйл биш юм. Төлөөлөгч Петр бичихдээ үүнтэй адил урхины талаар:

“арай ядан зугтдаг хүмүүсийг . . . тэд махан биеийн хүсэл тачаалаар уруу татдаг бөгөөд . . .

“хүмүүст эрх чөлөөг амладаг атлаа өөрсдөө ялзралын боол билээ. Учир нь тэд юунд дийлдэнэ, түүгээрээ боолчлогддог ажээ” (2 Петр 2:18–19) хэмээн сэрэмжлүүлсэн билээ.

Хайрт ах, эгч нар минь ээ, тэрхүү боолчлолоос зугтагтун. Хэрэв та яг одоо порнограф үзэж байгаа бол үүнийгээ зогсоо! Яг одоо зогсоо! Бишопоосоо тусламж хүс. Нэгэнт порнографт хордсон бол хэн ч тэрхүү дайсныг өөрөө ялан дийлэх ухаантай биш юм. Энэ нь уяман өвчин шиг сүйтгэгч, мефамфетамин шиг донтуулагч, натрийн хлорид шиг идэмхий билээ.

Та нар Их Эзэнийг дагах уу эсвэл хүмүүний мэргэн ухааныг дагах уу?

“Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийг анхааралтай судал.⁸ Бүх дэлхий даяар гэр бүлүүд дарамт хавчлаган дор байсан ч гэр бүлийн тунхгийн үнэнүүд та нарыг хамгаалах болно.

Та нар гэрлэлтийн талаарх тодорхойлолтуудтай зөрчилдөх нийгмийн хор уршиг бүхий үр дагавруудыг ойлгох хэрэгтэй. Өнөөгийн нэг маргаан нь ижил хүйстэн хоёр хүн гэрлэж болох эсэх тухай асуудал дээр байдаг. Хэрэв та нар энэ талаар эсвэл бусад чухал асуудлаар сүмийн байр суурийг мэдэхийг хүсвэл залбирч мөн тунгаан бод. Тэдгээр сүнслэг захиасууд болон Ариун Сүнснээс ирэх өдөөлгүүд нь та нарын оюун ухаанд бүрэн

дүүрэн хийгээд илүү үнэн ойлголтыг авчрах болно.⁹

Гэрлэлтийн талаарх маргаан нь ирээдүйд та нарт тулгарах маргаантай асуудлуудын зөвхөн нэг нь байх болно. Дайсны чанга дуу хоолойн эсрэг язгууртан гаралтай өсвөр үеийнхэн та нар Их Эзэн болон Түүний үнэний талд зогсохоор сонгох болно.

Төлөөлөгч Паул өнөө үеийн хэцүү нөхцөл байдлын талаар бошиглосон (2 Тимот 3:1–5-ыг үзнэ үү). Харин өнөө үеийн сүнсний устгалын талаарх Паулын үнэн зөв үзэгдэл нь бидэнд хэрхэн аюулгүй байх талаар “Христ Есүст итгэх итгэлээр дамжуулан авралд хүргэх мэргэн ухааныг чамд өгөх чадалтай ариун бичээсүүдийг чи бага наснаасаа мэдэх болсон” (2 Тимот 3:15) гэж дүрслэн хэлжээ.

Түүний энэхүү зөвлөгөөн дээр би нэмж зөвлөмөөр байна. Судраа үргэлжлүүлэн судлагтун. Есүс Христэд итгэх итгэлийг тань хөгжүүлэх зүйлсийг үргэлжлүүлэн хийгтүн. Тэгээд аяндаа хийхээр өдөөгдөх мэргэн сонголтуудаа ажиглаарай.

Есүс Христ болон Түүний сайн мэдээнд итгэх итгэл тань залуу мөн боломжтой байхдаа гэрлэж, гэр бүлдээ хүүхдүүд авчрахад таныг урамшуулах болно. Та нар миний насан дээр ирэх үедээ та нарт ирж болох ямар ч нэр хүнд, эд баялгаас илүү өөрийнхөө хүүхдүүд, ач зээ болон тэдний үр хүүхдүүдийг эрхэмлэн хайрлах болно.

Та нар Аврагчтай ярилцах хувийн ярилцлагадаа хэрхэн бэлтгэх вэ?

Язгууртан гаралтай өсвөр үеийнхэн та нар хараахан төгс болоогүй байгаа. Бидний хэн нь ч төгс биш. Тиймээс, чин сэтгэлээсээ наманчилсан үед бүрэн дүүрэн өршөөлийг өгдөг Аврагчийн Цагаатгалд та бид бүгдээрээ маш их талархалтай байдаг. Түүнчлэн та нар мөнх бус дэлхийд амьдрах бидний амьдрал харьцангуй богинохон гэдгийг мэднэ. Цаг нь болохоор та нарын хүн нэг бүр зуурдын энэхүү оршихуйг орхин, дараагийн амьдралдаа очих болно.

Шүүлтийн өдөр бидний хүн нэг бүрийг хүлээж байдаг. Би “Израилын Ариун Нэгэн бол их хаалганы сахиул мөн тэрээр нэгээхэн зарцыг тэнд үл ажиллуулдаг” (2 Нифай 9:41) гэдгийг мэддэг. Тийм ээ, бидний хүн нэг бүр Есүс Христтэй биечлэн ярилцах болно.

Дэлхий дээрх бүхий л өдрүүд та нарт тэрхүү ярилцлаганд бэлтгэх цаг хугацаа болон боломжуудыг олгодог. Дараах зүйлийг ухаарч мэднэ үү: Та нар Их Эзэний талд амьдрахаар сонгосноороо хэзээ ч ганцаардахгүй. Та нар мөнх бус амьдралын аюултай замаар урагшлахдаа Бурханаас тусламж авах боломжийг Тэр бидэнд өгсөн. Та нар өдөр тутмын залбиралдаа хичээнгүйлэн, чин сэтгэлээсээ зүрх сэтгэлээ Түүнд юүлснээр Тэрээр та нарт туслах тэнгэр элчүүдээ илгээх болно (С ба Г 84:88 -ыг үзнэ үү). Та нар зохистой амьдарвал та нарын хажууд байх Ариун Сүнсийг Тэрбээр өгсөн билээ. Христийн үгэн дээр бүрэн дүүрэн найрлаж болохын тулд Тэр та нарт



Дэлхийн хүмүүсээс
өөрөөр бодож, мөн
өөрөөр үйлдэхээр
сонго. Өөрөөр ха-
рагдаж, өөрийнхөө
бий болгох сайн
нөлөөг харахаар
сонго.

судруудыг өгсөн (2 Нифай 9:51; 32:3-ыг үзнэ үү). Тэрээр амьд бошиглогчдын үгсийг та нарт өгсөн. Тэдний үгсэд анхаарлаа хандуулагтун.

Та нар хэнд итгэл найдвараа тавих вэ?

Та нар Бурхан бол та бүхний Эцэг гэдгийг мэднэ. Тэр та нарт хайртай бөгөөд та нарыг аз жаргалтай байгаасай гэж хүсдэг. Итгэл найдвараа Түүнд тавигтун (2 Нифай 4:34; 28:31-ийг үзнэ үү). Түүний ариун сүмд анхаарлаа хандуул. Хишиг хүртэх болон лацдан холболтын ёслолуудыг хүлээн авахад зохистой бай. Эдгээр гэрээндээ итгэлтэй үлдэж, ариун сүмд ойр ойрхон орж бай. Та нарын хамгийн эрхэм зорилго бол Бурханы бүх адислалаас хамгийн агуу нь болох мөнх амьдралыг олж авах билээ (С ба Г 14:7-г үзнэ үү). Ариун сүмийн ёслолууд нь тэрхүү адислалд амин чухал юм (С ба Г 131:1–3-ыг үзнэ үү).

Би та нарыг өөрсдийнхөө хэн болох, өөрсдийн зорилго болон адислалын талаарх судрын тодорхойлолтыг залбирч, судлахад урьж байна (С ба Г 86:8–11-ийг үзнэ үү). Тийм ээ, язгууртан гаралтай та нар үнэхээр Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн. Та нар энд соригдож мөн шалгагдахаар ирсэн, Түүний хууль ёсны

өв залгамжлагчид билээ. Та нар дэлхийд гэрэл байж, Бурханы хүүхдүүдийг аврахад туслан, баяр баясгалантай байхаар, мөн хамгийн чухал нь мөнх амьдралын адислалуудыг олж авахаар сонгох болтугай. ■

2013 оны 9-р сарын 6-нд Хавай-Бригам Янгийн Их сургууль дээрх СЕБ-ийн залуучуудад зориулсан онцгой цугларалт дээр хэлсэн “Язгууртан гаралтай өсвөр үеийнхэн: Та нар юу сонгох вэ?” сэдэвт үгээс авав. Бүрэн эхээр нь үзэх бол cesdevotionals.lds.org хаягаар орно уу.

ЭШЛЭЛҮҮД

1. “Carry On,” *Hymns*, дугаар 255-ыг үзнэ үү.
2. “Hope of Israel,” *Hymns*, дугаар 259-ийг үзнэ үү.
3. *Харилцан ярианаас* орчуулагдсан, *anastrophe* хэмээх грек үг нь амьдралын дээшээ чиглэсэн зам гэсэн утгатай.
4. Ардэт Грийн Карр, *I Walk by Faith* (1987), 97.
5. “We Are All Enlisted,” *Hymns*, дугаар 250-ийг үзнэ үү.
6. Зарим хүн сонгох эрхийг *чөлөөт сонголт* хэмээн дүрсэддэг. Гэхдээ энэ хэллэг нь сударт байдаггүй. Судар нь зөвхөн *ёс сурталуудыг сонгох эрхийн* талаар өгүүлдэг (С ба Г 101:78-ыг үзнэ үү).
7. Бойд К.Пакэр, “Өсвөр үеийнхэнд зөвлөх нь,” *Лиакхона*, 2011 оны 11-р сар, 16, 18-ыг үзнэ үү.
8. “Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 129-ийг үзнэ үү.
9. Сүмийн сүнслэг удирдамж бүхий тунхаг нь гэр бүлийн талаар тунхаглахдаа: “Тэр бүл Бурханаас томилогддог.” Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлшгүй нэг хэсэг юм. Хүүхдүүд нь гэр бүлийн дотор төрж, гэрлэлтийн тангаргаа үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй юм” (“Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 129) гэжээ.

БИД ЯМАРХУУ МАЯГИЙН багш нар БАЙВАЛ ЗОХИХ БИЛЭЭ?

*Хэрэв бид үнэхээр
Аврагчтай адил болохыг
хүсвэл Түүний заадаг
байсан арга замаар
заахад суралцах ёстой.*

**Ням гаргийн ангийн ерөнхий
ерөнхийлөгчийн зөвлөл**



**Ерөнхийлөгч Тэд Р.Каллистэр (голд);
нэгдүгээр зөвлөх Жонн С.Таннэр
(зүүн талд); хоёрдугаар зөвлөх
Дэвин Г.Дуррант (баруун талд)**

Амилсан Их Эзэн Америк дахь тохинуулаараа бүх зорилгоо гүйцэлдүүлэв. Үүний өмнөхөн Тэрээр нас барсныхаа дараа нифайчууд болон леменчүүдийн газар нутгийг бүрхсэн тэрхүү харанхуйг сарниулах гэрлийн хамт тэнгэрээс бууж ирсэн. Тэрээр зааж, гэрчилж мөн залбирсан. Тэр адисалж, асуултуудад хариулж мөн Өөрийн Сүмийг зохион байгуулсан. Тэгээд Тэр шавь нараа орхиж явахаар бэлтгэж байх үедээ итгэл үнэмшлийнхээ дагуу үүрэх ёстой хариуцлагыг нь тэдэнд ийн танилцуулжээ:

“Миний сүмд хийх ёстой зүйлүүдээ та нар мэднэ; учир нь миний хийхийг та нарын харсан тэр ажлуудыг та нар түүнчлэн хийх болно . . .

“ . . . Тиймийн тул, та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ? Үнэнээр би та нарт хэлье, бүр миний адил буюу” (3 Нифай 27:21, 27).

Есүс биднийг Өөртэйгөө адил болоход урьдаг бөгөөд Түүний агуу зан чанаруудын нэг нь заах чадвар юм. Тэр үнэхээр Гарамгай Багш юм. Түүнтэй адил болохын тулд бид зөвхөн сүм дээр биш, харин гэр орондоо ч гэсэн хайраар дүүрэн, амьдралыг өөрчилдөг багш нар

байх хэрэгтэй. Бид Түүнтэй адил болохын тулд, Түүний заасан шиг заахын тулд зүрх сэтгэлдээ шатаж буй мэт гал халуун хүсэл эрмэлзэлтэй байх ёстой.

Асуултууд болон урилгууд

Есүс заримдаа асуултуудаар болон урилгуудаар дамжуулан заадаг байв. Түүний Америк тивд шавь нартайгаа хамт байсан тэр үеийн нэгэн жишээг бодож үз. Нэг удаа тэднийг залбирч байтал Аврагч тэдэн дээр ирж, “Та нарт намайг юу өгөөсэй хэмээн та нар хүснэв?” (3 Нифай 27:2) гэж урьсан нээлттэй асуулт асуужээ. Хэрэв Аврагч та нараас энэ асуултыг асуусан бол та нар юу гэж хариулах вэ?

Мөн тэд түүнд: “Их Эзэн, энэ сүмийг ямар нэрээр нэрлэхийг бидэнд хэлээсэй хэмээн бид танаас хүсч байна; учир нь энэ хэргийн талаар хүмүүсийн дунд арцалдаан байна” (3 Нифай 27:3) гэж хэлэв.

Христ Өөрийн үгээр тэдний асуултуудад хариулдаг байв. “Миний нэр болох, Христийн нэрийг та нар өөрсдийн дээр авах ёстой хэмээсэн, судруудыг тэд уншаагүй гэж үү?” (3 Нифай 27:5). Энэ асуулт нь түүний суралцагчдад өөрсдийнхөө



асуултуудад хариулахаар хичээл зүтгэл гаргах хэрэгтэйг болон олон асуултын хариулт нь судрууд дээр байдгийг сануулсан юм.

Дараа нь Тэрээр нэрнийхээ чухал ач холбогдлыг шавь нартаа сануулан төгсгөсөн билээ. Түүний үгс тэднийг үйлдэхэд урьсан бөгөөд “Мөн өөрийн дээр миний нэрийг авсан, мөн эцсээ хүртэл тэвчих хэн боловч, чухамхүү тэр нь эцсийн өдөр аврагдах болно” (3 Нифай 27:6) хэмээн нэгэн адислалыг амласан юм.

Заах загвар

Есүс Христ эдгээр хэдхэн шүлгээрээ дамжуулан заах тэнгэрлэг удирдамжийг бидэнд өгсөн юм. Тэрээр суралцагчдынхаа хэрэгцээг олж мэдэхэд чиглэсэн тунгаан бодох асуулт асууж эхэлсэн билээ. Тэгээд Тэр хүлээж, тэдний хариултыг сонсдог байсан.

Суралцагчид нь хариулж дууссаны дараа Тэрээр тэднийг судрууд руу хандуулж, хайж байгаа зүйлээ олоход нь тусалдаг байв.

Эцэст нь Тэрээр хоёр урилга өгч, урилгынх нь дагуу үйлдэх хүсэлтэй тэдэнд нэгэн гайхамшигтай амлалтыг өгсөн билээ. Энэ тохиолдолд Христийн заах арга барилыг доорх таван зарчмаар дүгнэж болох юм:

1. Үр дүнтэй асуулт асуу

Аврагч “Та нарт намайг юу өгөөсэй хэмээн та нар хүснэв?” хэмээн асуусан. Энэ асуултад олон янзаар хариулж болно. Ийм асуултууд асууснаар бид суралцагчдадаа сурахыг хүсэж байгаа зүйлээ тодорхойлоход нь, мөн хамгийн агуу эдгээр зүйлдээ анхаарлаа хандуулахад нь тусалдаг. Бид тэднийг идэвхтэй суралцахад татан оролцуулдаг.

2. Суралцагчдаа сонс

Тэднийг “Их Эзэн, энэ сүмийг ямар нэрээр нэрлэхийг бидэнд

хэлээсэй хэмээн бид танаас хүсч байна” гэж хэлэхэд Есүс Христ сонсон юм. Бид чин сэтгэлээсээ сонсоноор суралцагчдынхаа хэрэгцээ шаардлагуудад анхаарлаа хандуулахад илүү сайн бэлтгэгдэх болно.

3. Судруудыг ашигла

Христ шавь нартаа “Миний нэр болох, Христийн нэрийг та нар өөрсдийн дээр авах ёстой хэмээсэн, судруудыг тэд уншаагүй гэж үү?” хэмээн сануулан хэлжээ. Багш, суралцагчийн аль аль нь хичээлдээ бэлтгэн судраа унших цаг гаргах хэрэгтэй. Судраас суддах нь багш, суралцагчдын аль алиных нь хувьд сүнслэг бэлтгэлийн гол хэсэг нь боддог.

4. Суралцагчдыг үйлдэхэд урь

Их Эзэн шавь нараа (1) Түүний нэрийг өөрсөд дээрээ авч, мөн (2) эцсээ хүртэл тэвчихэд урьдаг. *Миний сайн мэдээг номло* удирдамж дээр хэлэхдээ: “Цөөн тохиолдолд л Христэд итгэх итгэлээ хүчирхэгжүүлэхийн тулд ямар нэгэн зүйл хийхэд хүмүүсийг урилгүйгээр тэдэнтэй ярилцаж эсвэл заах хэрэгтэй” гэжээ¹. Энэ нь зөвхөн номлогчдод төдийгүй сайн мэдээний бүх багшид өгсөн сайн зөвлөгөө юм.

5. Дуулгавартай байдлын амлагдсан адислалуудын талаар суралцагчдаа сануул

Эцэст нь, Есүс Христ суралцагчдаа хандан урилгуудынх дагуу үйлддэг хүмүүс “эцсийн өдөр аврагдах болно” хэмээн амласан билээ. Биднийг дуулгавартай байснаар ирэх хамгийн агуу адислалуудыг Христ бидэнд үргэлж амладаг (С ба Г 14:7-г үзнэ үү). Бид сайн мэдээний багш нарын хувьд мөн ийм амлалт өгч болно.

Дээрх жишээ нь Христийн ашигладаг байсан хэдэн чухал заах аргыг харуулж байна. Үүнээс гадна, Тэр заримдаа сургаалт зүйрлэлээр, эсвэл адилтгалаар заадаг байсан.

Заримдаа Тэр Өөрийг нь гүжирдэгчдийг эсэргүүцэн, зэмлэдэг байв. Гэвч Тэрээр зэмлэдэг хүмүүстээ хүртэл үргэлж хайраар заадаг байсан юм (Илчлэлт 3:19-ийг үзнэ үү).

Суралцагчдаа хайрла

Хэрвээ Аврагчийн арга барилаар заах гэвэл бид мөн үргэлж хайр, энэрлээр заах ёстой. Хайр нь “Хоёул сэнхэрч мөн хамтдаа баясаж [болохын тулд]” (С ба Г 50:22) багш, суралцагчийн зүрх сэтгэлийг адилхан нээж өгдөг.

Хүмүүсийн төлөө залбирч, тэдэнтэй хамт уйлж, тэднийг адисалдаг Аврагчийн суралцагчдаа гэсэн хайрын хүчирхэг жишээг бид 3 Нифайгаас олж харж болно. Түүнийг өөрсдийнх нь төлөө Эцэгтээ хандан залбирах үед нифайчууд Түүний хайрыг мэдэрсэн юм: “Мөн бидний төлөө Эцэгт хандан түүний залбирсныг бид сонссон тэр цагт бодгалийг маань дүүргэсэн тэрхүү баяслыг хэн ч төсөөлж чадахгүй буйза” (3 Нифай 17:17).

Түүний хайр агуу байсан учраас, мөн тэдний төлөөх Түүний баясал дүүрэн байсан учир Тэрээр

уйлж, итгэлийнх нь учир тэднийг адислав:

“Итгэлийнхээ учир адислагдсан болой та нар. Мөн эдүгээ болгоогтун, миний баясал дүүрэн байна.

“Мөн тэрээр эдгээр үгсийг хэлээд, уйлав” (3 Нифай 17:20–21).

Агуу хайр агуу суралцах боломжийг бий болгодог. Судар дээр “түүний дүр тэдний дээр инээмсэглэж,” мөн “тэдний зүрх сэтгэл нээлтэй байж мөн тэд зүрх сэтгэлдээ ойлгосон болой” (3 Нифай 19:25, 33) хэмээн тэмдэглэжээ.

Суралцагчдаа гэрчлэлээ хуваалцахад нь урамшуулан дэмж

Аврагч ч мөн гэрчлэлээ хуваалцах боломжийг суралцагчдаа олгодог байв. Жишээ нь, “Есүс Цезарь Филиппийн нутагт очих үедээ шавь нараасаа, Хүмүүс Хүний Хүүг хэн гэж ярьж байна? гэж асуув. . . .

“Тэгэхэд нь тэд, Зарим нь баптисм хүртээгч Иохан, зарим нь Елиа, харин зарим нь Иеремиа эсвэл эш үзүүлэгчдийн нэг гэж ярьдаг гэхэд

Тэр, Харин та нар Намайг хэн гэж хэлэх вэ гэсэнд,



Симон Петр, Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн” (Матай 16:13–16) гэв.

Петрийг гэрчлэлээ хуваалцсаны дараа Христ түүнд гайхамшигтай адислалуудыг хэлсэн юм:

“Барiona Симон оо, чи ерөөлтэй еэ! Учир нь үүнийг чамд мах цус нь биш, харин тэнгэр дэх Миний Эцэг илчилсэн юм.

Би мөн чамд хэлье, Чи бол Петр. Энэ хадан дээр би өөрийн чуулганыг босгох бөгөөд түүнийг Үхэгсдийн орны хаалга дийлэхгүй.

Би чамд тэнгэрийн хаанчлалын түлхүүрүүдийг өгнө. Чи газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдоно. Газар дээр юуг тайлна, тэр нь тэнгэрт тайлагдах болно” (Матай 16:17–19).

Бид гарамгай багш болохыг хичээх үедээ заримдаа амаар болон зүрх сэтгэлдээ гэрчлэлээ хуваалцахад суралцагчдыг өдөөдөг асуулуудыг асуух болно. Өдөр тутмын амьдралд нь туршлага бий болгодог хувийн гэрчлэлтэй болохыг эрэлхийлэхэд нь бид суралцагчдыг урих болно. Тэгээд ангийн эсвэл гэр орны уур амьсгал нь Сүнснийг мэдрүүлэхүйц байвал суралцагчид маань сүнслэг туршлага болон гэрчлэлээ бие биетэйгээ хуваалцахдаа ая тухтай мэдрэмжтэй байх болно.

Заадаг зүйлийнхээ дагуу амьдар

Есүс Христ Өөрийнх нь хийсэн зүйлүүдийг хийхэд (3 Нифай 27:21-ийг үзнэ үү) мөн Түүнийг дагахад (Матай 4:19-ийг үзнэ үү) бусдыг уриалсан юм. Тэрээр заадаг зүйлийнхээ дагуу амьдардаг байсан. Ингэснээрээ Тэр үлгэр жишээгээрээ заадаг байв.

Тэрээр үйлчлэлийн тухай үйлчлэл хийж заадаг байв. Түүнийг шавь нарынхаа хөлийг угаах үед энэ нь шавь нарт нь ямар сургамж болсон бол? “Тэгвэл Би Эзэн, Багш байтлаа

та нарын хөлийг угаасан бол та нар мөн нэг нэгнийхээ хөлийг угаах ёстой.

Учир нь Миний та нарт юу хийснийг та нар бас хийх хэрэгтэй гэж Би ийм жишээ үзүүлсэн юм” (Иохан 13:14–15).

Тэрээр хайрын тухай бусдыг хайрлаж заадаг байв. “Би та нарт бие биенээ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун гэсэн шинэ тушаал өгч байна” (Иохан 13:34).

Тэр залбирлын талаар залбирч заадаг байв. Залбирлууд нь ер бусын элэгсэг дотно, биширмээр, бурханлаг байсан учир тэдгээрийг тэмдэглэх боломжгүй байв. Тэрээр “би та нарын дунд залбирсан шиг, та нар түүнчлэн миний сүмд залбирах болно. . . . Болгоогтун би бол гэрэл; би та нарт үлгэр жишээ үзүүлсэн билээ” (3 Нифай 18:16) хэмээн хэлжээ.

Есүс Христ Түүний арга замаар заахыг хүсдэг сайн мэдээний бүх багшид зориулан нэгэн загвар өгсөн билээ. Бид Түүнтэй адил төгс биш ч гэсэн заадаг зүйлийнхээ дагуу амьдрахын тулд шаргуу хичээж болно. Нэгэн хүүхдийн дуун дээр багш нар “Миний хийснийг хий; намайг дага, намайг дага!”² гэж хэлэх хэрэгтэй гэсэн байдаг.

Аврагчийн арга барилаар заах нь

Сайн мэдээний бүх багшийг Аврагчийн заасан арга замыг харуулдаг дараах 6 үндсэн зарчмыг хэрэгжүүлэхэд урьдаг.

1. Заадаг хүмүүсээ хайрла

- Суралцагчидтайгаа нэг бүрчлэн ажилла.
- Суралцагчдынхаа хэрэгцээнд тулгуурла.

2. Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлд

- Заадаг зүйлийнхээ дагуу амьдар.
- Боломжтой эх сурвалжуудыг олж мэд.

3. Ариун Сүнсээр заа

- Сүнснийг танихад суралцагчдаа тусал.
- Суралцагчдынхаа санал бодлыг сонсож, хүлээн авдаг багш бай.
- Суралцах орчныг бий болго.

4. Сургаалын тухай хамтдаа

олж мэд

- Өндөр жишгүүд тогтоо.
- Гэрчлэлээ хуваалцахад суралцагчдаа урамшуулан дэмж.
- Үр дүнтэй асуулт асуу.
- Суралцагчдаа сонс.

5. Сургаалыг заа

- Судруудыг ашигла.
- Түүх, жишээнүүд ашигла.
- Адислалуудыг амлаж, гэрчлэлээ хуваалц.

6. Суралцагчдыг үйлдэл

хийхэд урь

- Сурсан зүйлээ амьдралд хэрэгжүүлэхэд нь суралцагчдаа тусал.
- Урилгынхаа эцсийн үр дүнг үзтэл хамт яв.

Бид эдгээр зарчмыг хэрэгжүүлснээр илүү сайн багш, илүү сайн суралцагч, илүү сайн эцэг эх болон Есүс Христийн илүү сайн шавь нар болно. Учир нь Тэрээр “бүгдээрээ бүхнээс сэнхэрсэн байж болохын тулд” (С ба Г 88:77, 78, 122) бие биендээ хичээнгүйлэн заахыг бидэнд зарлигласан билээ. Бидний заадаг хүмүүс Гарамгай Багшийн ямар нэгэн зан чанарыг биднээс олж харж, тэдэнд зөвхөн өчүүхэн мэдээллийг өгдөг биш, харин тэднийг өөрчилдөг туршлагыг олж авах болтугай. ■

ЭШЛЭЛҮҮД

1. *Миний сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлийн удирдамж* (2004), 196.
2. “Do As I’m Doing,” *Children’s Songbook*, 276.



Ахлагч
Койчи Аояаги
Далын



БОШИГЛОГЧИЙН ЗӨВЛӨГӨӨ БА ариун сүмийн адислалууд

Намайг залуу эрэгтэй байхад хожим нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүнээр үйлчилсэн ахлагч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) Японд айлчлан ирж, миний оролцсон нэгэн чуулган дээр үг хэлсэн юм. Би одоо хүртэл “Залуучууд номлолд явж, ариун сүмд гэрлэх хэрэгтэй” гэсэн түүний зөвлөгөөг санадаг.

Би Ариун Сүнсний өдөөлтийг мэдэрч, тэр үед Японд ариун сүм байгаагүй ч, номлолд үйлчилж, ариун сүмд гэрлэх болно гэж шийдсэн юм.

Тэр үед би 19 настай байсан бөгөөд их сургуулийн 2-р курст суралцаж байлаа. Хожмын үеийн гэгээнтэн биш аав, ээж хоёр маань номлолд үйлчлэх миний шийдвэрийг эрс эсэргүүцэж байв. Би аав, ээж хоёрынхоо зөвшөөрөл, адислалыг авахын тулд өдөр бүр залбирдаг байв. 6 сарын дараа Их Эзэн миний залбиралд хариулсан юм.

Аав, ээж хоёр маань надад “Бид санхүүгийн хүнд байдалд орсон учир чиний сургуулийн болон амжиргааны зардлыг цаашид төлж чадахгүй боллоо. Чи одооноос эхлэн бие даан амьдрах ёстой. Номлолд явах эсэхээ өөрөө шийд” гэж хэлэв.

Би эцэг, эхийнхээ адислалыг авч, сургуулиасаа гараад, сүмийн барилгын ажилд үйлчилж, дараа нь номлолд үйлчлэх мөнгө хуримтлуулахаар ажил хайж эхэлсэн юм. Их Эзэний тусламжтайгаар би 3 ажил олсон. Дараагийн жил нь ням гаргаас бусад бүх өдөр би өглөөний 3:00-7:00 цаг хүртэл сонин зарж, 9:00-16:00 цаг хүртэл байрууд цэвэрлэж, 17:00-19.00 цаг хүртэл тогоочоор ажилладаг байв. Дараа нь хувцсаа сольж, шөнийн цагаар дүүргийн номлогчоор үйлчилдэг байж билээ.

Биднийг удирдамжсийн төлөө залбирч, амьд бошиглогчдыг даган, ариун сүмийг амьдралдаа эн тэргүүнд тавих үед Тэнгэрлэг Эцэг биднийг удирдаж, адислах болно гэдгийг би гэрчилж байна.

Би 22 настай байхдаа Алс Дорнодын Хойд номлолд дуудагдав. Номлолын үйлчлэлийн турш би хэзээ ч мэдэрч байгаагүй агуу баяр баясгаланг мэдэрч, Бурханы хайрыг мэдэх олон боломж надад тохиосон бөгөөд мөн олон ч адислал хүлээн авсан юм. Намайг номлолд үйлчлэх үеэр аав, ээж хоёр маань санхүүгийн бэрхшээлээ шийдвэрлэснээр манай гэр бүл ч бас адислагдсан билээ.

Бошиглогчийг дагах нь

Номлолоо дуусгах үед Сүнс надад ерөнхийлөгч Кимбаллын зөвлөгөөний хоёр дахь хэсгийг дагаж, ариун сүмийн гэрлэлтээ хойшлуулахгүй байхыг сануулсан юм. Жилийн өмнөөс Японы сүмийн гишүүд Солт Лэйкийн ариун сүм рүү явах аялал төлөвлөж эхлэв. Тэд 3 сарын дараа явах гэж байсан учир би ариун сүм рүү авч орох зохистой эмэгтэйг олохын тулд залбирч, мацаг барьж байв.

Үүний дараахан би төрсөн нутаг Мацумото хотод Сүмийн үйл ажиллагаанд оролцож байлаа. Тэнд

байхдаа, намайг Сүмд орох үед надтай нэг ахлах сургуульд сурдаг байсан Широко Момосэтэй би тааралдсан юм. Сүнс тэр даруй тэр эмэгтэйг надтай гэрлэхээр бэлтгэгдсэн эмэгтэй мөн болохыг надад баталж билээ.

Би Широкотой болзож эхлээд удалгүй түүнд гэрлэх санал тавив. Миний саналыг хүлээж авахад нь би баярласан ч түүний хэлсэн үгс намайг тун их гайхшируулсан юм.

“Чиний Их Эзэн бол миний Их Эзэн гэдгийг мэдсэндээ би баяртай байна. Солт Лэйкийн ариун сүм рүү явах аялал зарлагдахад би явахыг хүссэн. Тэнд очоод гэрлэж болох хэн нэгнийг олоход туслаач хэмээн би Их Эзэнд олон удаа залбирсан. Чамайг хүлээх хэрэгтэй гэдгээ, мөн чамайг номлолоосоо буугаад надад гэрлэх санал тавих болно гэдгийг би бараг жилийн өмнөөс залбирч байхдаа Сүнсээр мэдсэн” гэж Широко хэлж билээ.

Энэ нь бидний хувьд агуу сүнслэг туршлага болсон бөгөөд Солт Лэйкийн ариун сүмд гэрлэх бидний шийдвэрийг улам бататгасан юм. Бидэнд аялалд явах багахан мөнгө байсан ч бид сэтгэлээр унаагүй. Тухайн үед Их Эзэнд найдан, зарлигуудыг нь дагах үед Тэр бидний өөрсдөө хийж чадахгүй байсан зүйлүүдийг хийхэд бидэнд тусалдгийг бид мэдэж авсан.

Бид залбирч, Тэнгэрлэг Эцэгээс тусламж гуйж, мөн шаардлагатай мөнгөө хуримтлуулахын тулд чадах бүхнээ хийхийг хичээсэн юм. Эдгээр хүчин чармайлтаас гадна Широкогийн найзуудаас ирсэн санхүүгийн тусламж нь биднийг Солт Лэйкийн ариун сүм рүү явсан Японы гэгээнтнүүдтэй нэгдэх боломжтой болгосон билээ.

Тэнд очоод, мөнхийн хос болон лацдан холбогдож байхдаа мэдэрсэн баяр баясгаланг үгээр илэрхийлэхийн



ДУУЛГАВАРТАЙ БАЙДАЛ— ХУВИРШГҮЙ УДИРДАМЖ

“Хайрт Тэнгэрлэг Эцэг бидний явах замыг тодорхойлж, хувиршгүй удирдамж—дуулгавартай байдлын зарчмыг өгсөн билээ. Үнэний тухай мэдлэг болон амьдралын хамгийн

чухал асуудлын хариулт нь Бурханы тушаалуудад дуулгавартай байснаар л бидэнд ирдэг.

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Дуулгавартай байдал адислалууд авчирдаг,” *Лиакхона*, 2013 оны 5-р сар, 89

аргагүй юм. Бид энэ мэдрэмжийг хэзээ ч мартахгүй. Бид өвөг дээдсийнхээ 5 үеийг хайж олон, тэдний нэрсийг ариун сүмийн ажилд зориулан бэлтгэсэн нь бидний баяр дээр бас нэгэн баярыг нэмж билээ. Солт Лэйк хотод байхдаа бид эдгээр өвөг дээдсийнхээ төлөө төлөөлөн гүйцэтгэх ёслолуудыг хийлгэсэн бөгөөд эдгээр ёслолыг хийлгэсэн нь тэдний талаар элэгсэг дотно мэдрэмж төрөхөд бидэнд тусалсан юм. Бидний хичээл зүтгэлийн ачаар тэд баяр баясгалангаар дүүргэгдсэнийг бид мэдсэн.

Бид шинэхэн гэрлэсэн, санхүүгийн хувьд ядуу хос байсан ч ариун сүмд орохыг чухалчилдаг байсан. Түүнээс хойш ч гэсэн бид санхүүгийн боломжтой үедээ Хавайн Лайе ариун сүмд очдог байв.

Ариун сүмээр адислагдсан нь

“Бидэнд юу юунаас ч илүү ариун сүм хэрэгтэй” гэж бошиглогч Иосеф Смит хэлсэн байдаг.¹

Бид ариун сүмд авралын ариун нандин зан үйл ба ёслолуудыг гүйцэтгэдэг учир Бурханы авралын төлөвлөгөөнд энэ нь бидний мөнхийн аз жаргалын чухал зүйл юм. Библийн толь бичиг нь бидэнд ариун сүм бол дэлхийн дээрх шүтээний хамгийн ариун газар бөгөөд “Их Эзэний ирж болох газар”² гэдгийг хэлдэг билээ.

Хэрэв бид ариун сүмийн гэрээнүүдээ хүндэтгэж, “даруу зүрх сэтгэлтэй, цэвэр ариун, хүндэтгэлтэй, шударга байдалтай” ирэх юм бол бид Ариун Сүнсийг мэдэрч, цаашдын гэрэл болон мэдлэгийг хүлээн авах болно”³. Бид ариун сүмээс гарахдаа Их Эзэний сүр хүчээр зэвсэглэн, Түүний нэрийг өөрсөд дээрээ аван, Түүний алдар сууг эргэн тойрондоо байлган, Түүний тэнгэр элчүүдийг өөрсөд дээр захируулахаар урагш оддог (С ба Г 109:13, 22-ыг үзнэ үү).

Бид гэрлэснийхээ дараа Японд эргэн ирээд, бүрэн цагийн ажил хайж байх үед Их Эзэний амлалтууд амьдралд минь ирсэн юм.

Их Эзэн амлалтуудаа биелүүлдэг

Би анхны хүүхдээ төрөх үед зөвхөн хагас цагийн ажил хийж байлаа. Бид баяртай байсан ч би бүрэн цагийн ажилгүйгээр өсөн томорч буй гэр бүлээ авч явах боломжгүй гэдгээ мэдэж байсан юм. Бид тэнгэрлэг тусламжийн төлөө чин сэтгэлээсээ залбирч эхлэв.

Би номлолд үйлчлэхээсээ өмнө гадаад худалдааны чиглэлээр ажиллахыг хүсдэг байсан ч худалдааны компанид ажилд орохын тулд ажил хайгч нь ерөнхийдөө



тухайн салбарын гэрчилгээтэй, их сургууль төгссөн хүн байх ёстой байв. Би коллежээ төгсөөгүй байсан болохоор надад ямар ч гэрчилгээ байсангүй. Гэвч бид залбирч байхдаа Их Эзэн биднийг адисалж, надад ажил өгөх болно гэдгийг мэдэрсэн юм.

Миний боловсрол хангалтгүй байсан ч би худалдааны хэд хэдэн компанид ажилд орох шалгалт өгөхөөр шийдэв. Эхний хоёр нь татгалзсан ч би гурав дахь компанид өргөдөл гаргахдаа сонирхол татахуйц туршлагатай болсон байлаа.

Тэр үед Япон дахь гишүүдийн тоо цөөхөн байснаас гадна олон хүн Сүмээс болж гадуурхагддаг байв. Гурав дахь худалдааны компанийн 3 төлөөлөгч надтай ярилцлага хийж байхдаа миний намтрыг хараад, намайг хожмын үеийн гэгээнтэн болохыг мэдэв. Тэд надаас тодорхой хариулт шаардсан Сүмийн тухай асуултууд асууж эхэлсэн юм. Номлолоосоо буугаад удаагүй байсан учир Есүс Христийн сэргээгдсэн Сүмийн талаар ярихад надад хэцүү биш байлаа.

Би сайн мэдээний талаар хамгийн багадаа 40 минут ярьж, Есүс Христийн амьдрал, урвалт, Иосеф Смитийн анхны үзэгдэл, Мормоны Ном, Есүс Христийн үнэн Сүмийн сэргээлт ба Сүмийн сургаалуудын талаар гэрчлэлээ хуваалцаж билээ.

Намайг ярьж байхад ярилцлага хийж байсан хүмүүсийн хэн нь ч намайг зогсоосонгүй. Хэдхэн өдрийн дараа тэр худалдааны компани надад гайхалтай өндөр цалинтай ажил санал болгосон юм. Дараа нь намайг яагаад сонгосныг менежерээсээ асуухад тэрээр “Би чамтай ярилцлага хийж байх үеэр чамайг мэрийлтэй, чин сэтгэлээсээ ханддаг, үнэнч хүн болохыг, мөн энэ маягаар манай компанид ажиллах хүн байна гэдгийг олж харсан” гэв.

Их Эзэн амлалтуудаа биелүүлдгийг би гэрчилж байна. Би ярилцлагад орж байхдаа ариун сүмд ордог, мөн ариун сүмийн гэрээнүүдээ хүндэлдэг хүмүүст Түүний амласан шиг, над дээр ирж буй Их Эзэний хүч, Сүнсийг мэдэрсэн юм. Би үнэтэй, олон хувь нэмрээ оруулсан тэр компанид ажиллаж байхдаа ч Сүнсийг мэдэрдэг байсан.

Японд ариун сүм баригдав

1975 оны Японд болсон шашны нэгэн чуулган дээр ерөнхийлөгч Кимбалл Японы Токиод ариун сүм баригдах талаар зарлав. Японы гэгээнтнүүд баяр, талархлаа илэрхийлж, чин сэтгэлийн халуун алга ташилтаар сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлж байлаа.

Японы Токиогийн ариун сүм 1980 онд баригдаж дууссан юм. Нээлттэй өдөрлөг ба онцгойлон адислах ёслолын үеэр гэгээнтнүүд гайхалтай сүнсэлэг туршлагаар болон агуу их баяр баясгалангаар адислагдсан билээ. Ариун сүмийг онцгойлон адислагдсаны дараа эдгээр туршлага нь гэгээнтнүүд ариун сүмийн ёслолуудаа хүлээн авч, нас барагсдынхаа өмнөөс төлөөлөн гүйцэтгэх ёслолуудыг хийлгэж эхэлснээр цааш үргэлжилсэн юм.

Өнөөдөр Широко бид хоёр гэрлээд бараг 45 жил болсны дараа ч гэсэн, бошиглогчийн зөвлөгөөг дагах миний шийдвэр бидний болон хүүхдүүдийн маань амьдралыг адисалсаар байна. Бид Их Эзэний арга замаар ариун сүмийн гэрээнүүдийн хамт Есүс Христийн сайн мэдээнд үндэслэсэн гайхамшигтай гэр оронг үүсгэн бий болгосон юм.

Биднийг удирдамжийн төлөө залбирч, амьд бошиглогчдыг даган, ариун сүмийг амьдралдаа эн тэргүүнд тавих үед Тэнгэрлэг Эцэг биднийг удирдаж, адислах болно гэдгийг би гэрчилж байна. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит (2007), 416.
2. Библийн толь бичиг, “Ариун сүм”
3. Спэнсэр В.Кимбалл, Японы Токиогийн ариун сүмийг онцгойлон адисалсан залбирлын хэсгээс 2013 Church Almanac (2013), 297

Флора бид хоёр-

Их Эзэний ажил дахь эн тэнцүү хамтрагчид



*Зүүн талд: Флора Эмүссэн,
Эзра Тафт Бэнсон хоёрын
залуу байх үеийн зураг.
Баруун талд: Флора, Эзра
хоёр 6 хүүхэдтэйгээ өдрийг
өнгөрүүлж байгаа нь.*





*Бид ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоныг эхнэр
Флора нь хэрхэн дэмжиж, тэд хайраар
хэрхэн хамтран ажилладаг байсныг
мэдсэнээр түүний үйлчлэлийн талаар илүү
гүнзгий ойлголттой болж чадна.*

Аарон Л.Вест

Сүмийн хэвлэлийн алба


Хэрэв бид анхааралтай сонсох юм бол богинохон нийлэмж үг хүртэл зарим үед номлол шиг хүчтэй байж болно. Ийм тохиолдол 1985 оны 11-р сарын 11-нд болсон юм. Тэрхүү нийлэмж үг нь “Флора бид хоёр” гэсэн гуравхан үг байв.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон (1899–1994) энэ гурван үгийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ерөнхийлөгчөөр томилогдсоныхоо маргааш нь сонинны сурвалжлагчдад зориулан бэлдсэн мэдэгдлийнхээ нэг хэсэг болгон уншсан юм. Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) нас барахаасаа 6 хоногийн өмнө ерөнхийлөгч Бэнсоныг ахлах төлөөлөгчөөр томилсон ажээ.

Ерөнхийлөгч Кимбаллын нас барсан тухай мэдээг сонсох үедээ ерөнхийлөгч Бэнсон эхнэр Флорагийнхаа хамт байсан бөгөөд тэд “тэр даруй өвдөг сөгдөн залбирав.”¹ Энэ удаад ч гэсэн дэлхий даяар нийтлэгдэх мэдэгдлийнхээ эхний догол мөрөнд тэрээр эхнэр Флорагийнхаа дэмжлэгийг дахин дурдсан байдаг. Тэрээр хэлэхдээ: “Энэ өдөр бол миний төсөөлж байгаагүй өдөр байв. Миний эхнэр Флора бид хоёр ерөнхийлөгч Кимбаллын өдрүүдийг энэ дэлхий дээр уртасгаж болохын тулд, мөн өөр нэгэн гайхамшгийг түүний өмнөөс гүйцэтгэж болохын тулд үргэлжлүүлэн залбирч байсан юм. Нэгэнт Их Эзэн ярьсан учир бид дэлхий дээрх энэ ажлыг урагшлуулахын тулд түүний удирдлаган дор чадах бүхнээ хийх болно” гэжээ.²

Гэрлээд 59 жил болсныхоо дараа ч ерөнхийлөгч Бэнсон “Флора бид хоёр” гэж хэлдэг хэвээр байв. Тэрээр “Бид дэлхий дээрх энэ ажлыг урагшлуулахын тулд түүний удирдлаган дор чадах бүхнээ хийх болно” гэж хэлэхдээ хэдийгээр тэрээр бусад ерөнхий эрх мэдэлтэнтэй эв нэгдэлтэй ажиллах нь тодорхой байсан ч тэр өөрийгөө болон тэднийг төлөөлөхөд *бид* гэдэг үгийг ашиглаагүй юм. Энэхүү мэдэгдэлдээ Сүмийн бошиглогч, үзмэрч, илчлэгч нь Их Эзэний ажилд

Эзра Тафт Бэнсоны зан чанаруудыг бий болгосон фермийн амьдралын талаар унших бол Teachings of Presidents of the Church: Ezra Taft Benson, 2–5-р хуудсыг үзнэ үү.



Дээрээсээ цагийн зүүний дагуу: Эзра Тафт бусад фермчинтэй хамт; Ээж ба ах дүү нарын хамт, Эзра зүүн талаас хоёр дахь нь; Эзрагийн эцэг Жорж Т.Бэнсон, эх Данкли Бэнсон нар.



эхнэртэйгээ нэгдмэл байх талаар хэлсэн билээ.

Яагаад тэр ингэж мэдэгдэхгүй байх билээ? Флора тэр хоёр Их Эзний ажилд бараг 60 жилийн турш нэгдмэл байсан ажээ. Жил ирэх тусам тэдний амьдралын олон хүчин зүйл өөрчлөгдсөөр байсан ч тэдний хамтын ажиллагаа хоёулангийнх нь хувьд хүч чадлын байнгын эх ундарга хэвээр байлаа.

Энэ жил Халамжийн Нийгэмлэгийн эгч нарын болон Мелкизедик санваартан ах нарын суралцах материалд ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны тухай судлах боломж оруулсан байгаа. Та нар сургаалуудыг нь судалснаар түүний зан чанарын талаар суралцахаар сүнслэгээр өдөөгдөж болох юм. Энэхүү өгүүлэлд эхнэр Флора Эмүссэн Бэнсонтой нь холбоотой түүний амьдрал, үйлчлэлийн талаар цухас дурдах болно. Энэ өгүүлэл дэх бүх бүлэг ба хуудасны тоо нь *Teachings of Presidents of the Church: Ezra Taft Benson* номыг төлөөлнө.

“Би фермчинтэй гэрлэмээр байна”

1920 оны намар 21 настай Эзра Тафт Бэнсон өөрийн төрсөн нутаг АНУ-ын Айдахо мужийн Витни дэх фермийн аж ахуйгаасаа явж, Ютагийн Логан хотод ирэв. Тэрээр тэнд Ютагийн Хөдөө Аж Ахуйн

Коллежид (одоо Юта мужийн их сургууль) элсэн оржээ. Нэгэн өдөр түүнийг сургуулийнхаа байранд хэдэн найзтайгаа хамт байх үед нэг залуухан эмэгтэй анхаарлыг нь татсан байна. Тэрээр хожим нь дурсан ярихдаа:

“Дур булаам, гоо үзэсгэлэнтэй нэгэн залуу эмэгтэй сүү худалдан авахаар жижигхэн машинаа жолоодон хажуугаар өнгөрөх үед бид сүүний мухлагийн гадаа зогсож байв. Хөвгүүдийг түүн рүү гараараа даллахад тэр эмэгтэй мөн хариу даллалаа. “Тэр охин хэн бэ?” гэж намайг асуухад тэд “Тэр бол Флора Эмүссэн” гэж хариулав.

“Аан гээч. Түүнтэй гэрлэх хэрэгтэй гэсэн бодол надад сая төрлөө” гэж би тэдэнд хэлэв.”

Эзрагийн найзууд түүний хэлсэн үгэнд гайхаж байлаа. Найзууд нь “Тэр бол фермийн хөвгүүдийн дунд цуутай охин шүү дээ” гэхэд Эзра “Тэгэх тусмаа бүр сонирхолтой байна”³ гэжээ.

Флора Эмүссэний талаарх Эзрагийн найзуудын бодол буруу байсан ажээ. Тэр өсвөр байхаасаа л газартай ажилладаг эрчүүдээс ямар нэг онцгой зүйл олж хардаг байв. Нэг өдөр ээж Барбара нь түүнд “Чи селестиел гэрлэлтгүйгээр хамгийн дээд алдар суугийн зэргийг хүлээн авч чадахгүй шүү дээ” гэжээ. Флора гэнэн цайлган ч өөрийн гэсэн үзэл бодлоо илэрхийлэн, “Би материаллаг аж байдлын хувьд ядуу ч, сүнслэг байдлаараа баян хүнтэй гэрлэмээр байна. Тэгвэл бид хамтдаа эд баялагтай болж чадна” гээд, түр бодолхийлснээ “Би фермчинтэй гэрлэмээр байна” гэж хэлсэн гэдэг.”⁴

Флора, Эзра хоёр 1920 оны сүүлээр танилцжээ. Тэдний нөхөрлөл удалгүй дотно үерхэл болон хувирав. Флора өөрийнхөө маш их үнэлж хүндэлдэг тэрхүү сүнслэг баялгуудыг хуримтлуулж эхэлсэн нэгэн залуу эрийг Эзра Тафт Бэнсоны дотроос олж харсан байна. Флорагийн хүлээлт ёсоор Эзрагийн сүнслэг хүч чадлын үндэс суурь нь түүний гэр бүлийн фермчин гарлаас үлбаатай байв.

Бурханыг нэгдүгээрт тавихын тулд хамтран ажилласан нь

Эзра, Флора хоёр бие биендээ дотносож эхлэхдээ 2 жилийн турш тусдаа байна

гэдгээ мэдэж байлаа. Эзра Английн номлод үйлчлэх дуудлага хүлээн авав. Флора тэр хоёр үйлчлэх боломжиндоо талархалтай байсан юм. Бас тэд “өөрсдийнхөө харилцааны талаар ярилцав.” Тэд харилцаагаа үргэлжлүүлэхийг хүсэж байсан ч Эзраг чин үнэнч номлогч байх хэрэгтэйг хүлээн зөвшөөрч байв. ‘Намайг явахаас өмнө, Флора бид хоёр бие биендээ сард зөвхөн нэг л удаа захиа бичиж байхаар шийдэцгээсэн.’ ‘Бид бас бие биенээ мөн өөртөө итгэх итгэлийг урамшуулан дэмжсэн, шинэ сонин дуулгасан захиа бичиж байна гэж шийдэцгээсэн. Бид зөвхөн үүнийгээ л хийсэн’ гэж тэр хэлжээ.”⁵

Тэд номлолын дуудлагаа ийм байдлаар хүлээн авснаар хожим нь Эзрагийн олон жилийн турш гэгээнтнүүдэд заах үнэнийг үлгэр жишээгээрээ харуулсан юм. “Бид Их Эзэнийг нэгдүгээрт тавьснаар бусад бүх зүйл зохих байрандаа ордог, эсвэл бидний амьдралаас алга болдог. Их Эзэнээ хайрлах бидний хайр нь бусдыг энэрэх болон шаардагдах цаг хугацаа, өөрсдийн сонирхдог зүйлсийг оролдох, эн тэргүүнд анхаарах ёстой зүйлсийн дэс дарааг тогтоох зэргийг зохицуулах болно.”⁶

Эзраг номлолоо дуусгах үеэр Флора тэр хоёр бие биетэйгээ уулзахыг тэсч ядан хүлээж байв. Гэхдээ Флора “түүнтэй хамт цагаа өнгөрүүлэх ойрын төлөвлөгөөнөөс илүү чухал зүйлийг хийсэн юм. Тэр үнэндээ түүний ирээдүйг болон чадавхыг харж байв. . . . Эзра Айдахогийн Витни дэх гэр бүлийнхээ ферм дээр суурьших хүсэлтэй байгаад нь Флора баяртай байлаа. Гэсэн хэдий ч Эзра эхлээд сургуулиа төгсөх хэрэгтэй гэсэн мэдрэмж Флорад төржээ.”⁷ Сургуулиа төгсөхөд нь түүнд чармайж тусалснаараа тэрээр Бурханыг нэгдүгээрт тавихад Эзратай нэгдсэн юм. Эзраг номлолоосоо буугаад жил хүрэхгүй хугацаа өнгөрсний дараа Флора өөрөө номлод үйлчлэх гэж байгаагаа түүнд хэлж, түүнийг гайхшируулсан байна. Түүний шийдвэрийн талаар илүү тодорхой мэдэхийг хүсвэл 10–11-р хуудсыг үзнэ үү.

Гаднаа эгэл боргилхон ч дотроо өөлөх юмгүй өв тэгш хүн

Флора, Эзра хоёр 1926 оны 9-р сарын 10-нд Солт Лэйкийн ариун сүмд лацдан



Эзра Тафт Бэнсоны бүрэн цагийн номлолын үйлчлэлийн талаарх түүхүүдийн бүрэн эхийг уншъя гэвэл 9–10-р хуудсыг үзнэ үү. –Дэлхийн II дайны дараахан төлөөлөгч байхдаа хийсэн үйлчлэлийнх нь талаар унших бол 17–21, 54–55, 69–70, 264, 268-р хуудсуудыг үзнэ үү.



Дээд тал: Номлолын дуудлага хүлээн авахаас өмнөх буюу Эзра Тафт Бэнсоны залуугийн зураг. Баруун дээд талд: Дэлхийн II дайны дараа–төлөөлөгчөөр үйлчилж байхдаа тэр Европ дахь хүмүүст үйлчлэхэд тусалдаг байв.

холбогджээ. Эзра төрөлхийн сайн сайхан зан чанартай бас сургуульд амжилттай сурдаг байсан ч “зарим хүн Флорагийн шийдвэрт гайхан эргэлздэг байв.” Ийм боловсролтой, чадварлаг, бэл хөрөнгөтэй, олны танил хүн яагаад энгийн нэгэн фермчинг сонгосныг тэд ойлгодоггүй байлаа. Гэвч “Флора фермчинтэй гэрлэхийг үргэлж хүсдэг байснаа байнга ярьдаг байв. Эзраг ‘туршлагатай, хэрсүү, хүчтэй байсан’ гэж тэр хэлдэг байв. Мөн Флора ‘түүнийг эцэг эхийнхээ сайхан хүү нь байсныг ажигласан бөгөөд тэр эцэг эхээ хүндэлдэг бол өөрийг нь ч гэсэн хүндэлнэ гэдгийг мэдэж байлаа.’ Флора түүнийг ‘Гаднаа эгэл боргилхон ч дотроо өөлөх юмгүй өв тэгш хүн гэдгийг нь хүлээн зөвшөөрдөг байсан ба зөвхөн цөөхөн хүнтэй энэ хамт олонд төдийгүй бүх дэлхийд танигдаж, сайн үйлсийн төлөө зүтгэхэд нь түүнд туслахын тулд бүх хүч чадлаараа хичээх болно’”⁸ гэж хэлсэн юм.

Флора нөхрийнхөө чадавхыг ийнхүү олж харснаар тэд хүүхдүүдийнхээ хэрэгцээг хангах болон Сүм, хамт олон, улс үндэстэндээ



Ахлагч Эзра Тафт Бэнсон төлөөлөгчөөр үйлчлэхийн зэрэгцээ Нэгдсэн Улсын Хөдөө Аж Ахуйн төрийн нарийн бичгийн даргаар найман жил үйлчилжээ. Тэрээр эдгээр үүрэгт ажлаа хэрхэн гүйцэтгэдэг байсан тухай уншъя гэвэл 21–25, 47–48-р хуудсуудыг үзнэ үү.



Дээд тал: Ерөнхийлөгч Бэнсон гэгээнтнүүдийн дунд. Зүүн талд: Нэгдсэн Улсын Хөдөө Аж Ахуйн төрийн нарийн бичгийн даргаар үйлчилж байхдаа.

үйлчлэх хэрэгтэй болсон үед тэр хаашаа ч гэсэн баяртай явдаг байв. Энэ нь дасан амьдралаасаа илүү энгийн амьдрахыг түүнээс шаарддаг байсан ч тэрээр энэхүү боломжийг бүрэн дүүрэн хүлээн авсан юм.

Жишээ нь, тэдний хуримын өдөр “ердөө ганцхан ёслол . . . болсон нь гэр бүлийнхэн болон найз нөхдөдөө зориулсан өглөөний хоол байв. Өглөөний хоолны дараа шинэхэн хос Т Форд загварын пикап машиндаа суугаад Эзрагийн хөдөө аж ахуйн эдийн засгаар магистрийн зэрэг хамгаалахаар суралцаж байсан Айовагийн Эймс рүү тэр даруй хөдөлжээ. Тэд замдаа 8 шөнийг дусаал гоождог майханд өнгөрүүлсэн байна. Тэд Эймсд ирээд, коллежийн оюутны хотхонд нэг сууц түрээслэв. Байр нь маш жижигхэнээс гадна Бэнсоных тэр байраа жоомны нэгэн том гэр бүлтэй хуваалцдаг байлаа. Гэвч Эзра ‘энэ нь удалгүй хэний ч төсөөлж чадахгүй хамгийн тохь тухтай тийм л жижигхэн байшин шиг харагддаг болсон юм’ гэжээ.”⁹

Эзра гаднаа эгэл боргилхон ч дотроо өөлөх юмгүй өв тэгш болсон үедээ гэрээсээ

гадуурх үйлчлэлд оролцох нь улам ихсэж байлаа. Энэ нь бас Флораг төгөлдөржүүлэх үйл явц руу хөтөлсөн юм. Тэр нөхрөө эзгүй үед заримдаа ганцаардал, цөхрөлтэй тэмцдэг байлаа. Гэвч тэр эхнэр, эх хүн болсондоо дуртай байж, нөхрийнхөө сайхан сэтгэлд болон гэр бүлийнхээ төлөө бүхнээ зориулдагт нь талархал илэрхийлдэг байв. Флора, Эзра хоёрын гэрлэлтийн эхэн үе болон эцэг эх болсон талаар дэлгэрэнгүй мэдэхийг хүсвэл 12–15-р хуудсыг үзнэ үү.

Амьдралыг нь өөрчилсөн хоёр утасны дуудлага

1943 оны 7-р сарын 27-нд Флора руу нөхөр нь утасджээ. Тэрээр Ютагийн Солт Лэйк хот руу ажлаар хүү Рийдтэйгээ хамт аялаад, буцаж ирэхээр бэлтгэж байлаа. Флора 3200 км-ийн зайтай Колумб дүүргийн Вашингтоны ойролцоох гэртээ байв. Түүнийг шөнөжингөө залбирч, уйлж, нойргүй өнгөрүүлсэн тэр шөнийн маргааш нь Эзра Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүнээр үйлчлэхээр өмнөх өдөр нь дуудагдсанаа эхнэртээ мэдэгдэхээр утасдсан байна.

Энэ мэдээ түүнийг гайхшируулсангүй. Нөхрийнх нь аяллын үеэр маш чухал нэг зүйл түүнд тохиолдох болно гэсэн маш хүчтэй мэдрэмж Флорад төрсөн байжээ.¹⁰ Тэрээр Эзрад итгэдгээ илэрхийлсэн бөгөөд эхнэрийнх нь үгс түүнийг тайвшруулсан байна. Тэрээр дараа нь энэ тухайгаа дурсан ярихдаа: “Эхнэртэйгээ ярьсан нь намайг тайвшруулсан юм. Тэр надад өөртөө итгэдгээс минь ч илүү их итгэл найдвар төрүүлдэг”¹¹ гэжээ.

Флора нөхөртөө итгэдэг байсан ч, нөхрөө ганцаараа дуудлагаа биелүүлж чадахгүйг, түүнд гэр бүлийнх нь дэмжлэг, тэнгэрийн хүч хэрэгтэйг мэддэг байв. Нэгэн Ерөнхий чуулган дээр Сүнсний шивнээгээр ирсэн захиас нь нөхрөө гэсэн Флорагийн хайрыг болон нөхрийнхөө Их Эзэнд найдаг найдварыг ойлгодгийг нь харуулсан байна (48–49-р хуудсыг үзнэ үү).

Флора 1952 оны 11-р сарын 24-нд амьдралыг нь өөрчилсөн өөр нэг утасны дуудлагыг нөхрөөсөө хүлээн авсан байна. Энэ үед Эзра Колумб дүүргийн Вашингтоны бүсэд айлчилж байсан аж. Харин Флора Солт Лэйк хот дахь гэртээ байв. Удахгүй Нэгдсэн



Улсын ерөнхийлөгчийн албаа хашиж эхлэх гэж байсан Уайт Д.Эйзенхауэр ахлагч Бэнсонд агуу золиослол, чин үнэнч чанарыг шаардах өндөр албан тушаал—түүний Хөдөө Аж Ахуйн төрийн нарийн бичгийн даргаар ажиллах ажлыг дөнгөж санал болгоод байжээ. Ахлагч Бэнсон Сүмийн ерөнхийлөгч Дэвид О.Маккэйн (1873–1970) зөвлөснөөр уг албан тушаалыг хүлээн авсан байв.

Ахлагч Бэнсон ерөнхийлөгч Уайт Д.Эйзенхауэрын түүнд албан тушаал санал болгосныг, мөн үүнийг нь хүлээн авснаа Флорад хэлэхэд тэрээр “Би түүнийг санал болгоно гэдгийг мэдэж байсан. Бас чамайг хүлээн авах болно гэдгийг ч бас мэдэж байсан гэж хариулсан байна.” Тэр гэр бүлд нь хэцүү байх болно гэдгийг хүлээн зөвшөөрсөн ч “Энэ нь Бурханы хүсэл мэт санагдаж байна” гэж нэмж хэлжээ.¹²

Ахлагч Бэнсон Хөдөө Аж Ахуйн төрийн нарийн бичгийн даргаар найман жил үйлчилжээ. Энэ хугацаанд гэр бүл нь тусдаа байх ёстой болж, ахлагч Бэнсон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үе үе гардаг шүүмжлэл, зусардалттай тэмцэх хэрэгтэй болдог байв. Мөн Бэнсоны гэр бүлийнхэнд олон агуу боломж нээгддэг байлаа. Жишээ нь, ахлагч Бэнсон нэг удаа 12 өөр улс оронтой худалдааны харилцаа тогтоохоор ажиллаж байсан газраа Флораг, Бэвэрли, Бонни гэдэг охидоо 4 долоо хоногийн аяллаар авч явж байв (181–82-р хуудсыг үзнэ үү). Мөн сонины нэгэн сурвалжлагчаас ирсэн урилга гэр бүлийнхэнд нь зориулсан онцгой нэгэн номлолын туршлага руу хөтөлсөн байна (24-р хуудсыг үзнэ үү).

Их Эзэний мутар дахь эн тэнцүү хамтрагчид

Сүмийн бүх ерөнхийлөгчтэй адил Эзра Тафт Бэнсон дуудлагадаа урьдчилан томилогдсон билээ. Гэвч тэр

ганцаараа тэрхүү урьдчилсан томилолыг гүйцэтгэж чадахгүй байх байсан буюу ийм хүч чадлаар үйлчилж чадахгүй байх байсан юм. Мэдээж, өөр хэн ч Флора шиг түүнд нөлөөлж чадахгүй байв. Тэд Сүм дээр болон гэр бүлдээ Их Эзэний хүчирхэг хамтрагчид болж мөр зэрэгцэн ажилласан юм.

Ерөнхийлөгч Бэнсон, Бэнсон эгч хоёр түүнийг Сүмийг тэргүүлэх болсныг нь мэдээд хамтдаа өвдөг сөгдсөнөөр тэд “дэлхий дээрх ажлыг урагшуулахын

тулд” хамтран ажилласан юм.¹³

Бэнсон эгч өсвөр насандаа найдан хүлээж байсны дагуу тэд хүссэн зүйлээ хамтдаа олж авсан билээ.¹⁴

Ерөнхийлөгч Бэнсон хожмын үеийн гэгээнтнүүдийг дэлхийг болон өөрсдийнхөө амьдралыг Мормоны Номоор дүүргэхийг индэр дээрээс ухуулдаг байв (9–10-р бүлгийг үзнэ үү). Флора өдөр бүр гэртээ түүнд Мормоны Номыг уншиж өгч, тэд уншсан зүйлийнхээ талаар хамтран ярилцдаг байлаа.¹⁵ Ерөнхийлөгч Бэнсон ариун сүмд тогтмол үйлчилж, мөн шүтэн бишрэхийг

гэгээнтнүүдэд индэр дээрээс уриалдаг байв (13-р бүлгийг үзнэ үү). Флора Бэнсон, Эзра Бэнсон хоёр боломжтой үедээ баасан гаргийн өглөө бүр ариун сүмд ордог байсан юм.¹⁶ Ерөнхийлөгч Бэнсон бардамналын нүгэл ба “дэлхийн магтаалын” талаар индэр дээрээс сэрэмжлүүлдэг байв.¹⁷ Флора “Бүх л дэлхий түүнийг мэдэхэд амжилттай тусалсан ч”¹⁸ тэд “тэнгэрийн чимээгүй магтаалд” хамтдаа сэтгэл хангалуун байдаг байв.¹⁹

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон Сүмийн төлөөлөгч болон ерөнхийлөгч байхдаа олон зуун номлол сургаалыг хүмүүст хүргэсэн. 1985 оны 11-р сарын 11-нд түүний хэлсэн: “Флора бид хоёр” гэсэн гуравхан үгтэй номлолын нөлөөгүйгээр эдгээр номлолын алийг нь ч төсөөлөхөд хэцүү юм. ■



ЭШЛЭЛҮҮД

1. Шэри Л.Дью, *Ezra Taft Benson: A Biography* (1987), 479.
2. Дон Л.Сөөрлийн бичсэн “President Ezra Taft Benson Ordained Thirteenth President of the Church,” *Ensign*, 1985 оны 12-р сар, 5.
3. *Teachings of Presidents of the Church: Ezra Taft Benson* (2014), 7–8.
4. Дью, *Ezra Taft Benson*, 74–75.
5. *Teachings: Ezra Taft Benson*, 8.
6. *Teachings: Ezra Taft Benson*, 40.
7. *Teachings: Ezra Taft Benson*, 10.
8. *Teachings: Ezra Taft Benson*, 11–12.
9. *Teachings: Ezra Taft Benson*, 12.
10. Дью, *Ezra Taft Benson*, 176.
11. Эзра Тафт Бэнсон, in *Teachings: Ezra Taft Benson*, 16.
12. Флора Эмүссэн Бэнсон, in *Teachings: Ezra Taft Benson*, 23.
13. Эзра Тафт Бэнсон, in Searle, “President Ezra Taft Benson Ordained Thirteenth President of the Church,” 5.
14. Флора Эмүссэн Бэнсон, in Dew, *Ezra Taft Benson*, 74–75-ыг үзнэ үү.
15. Derin Head Rodriguez, “Flora Amussen Benson: Handmaiden of the Lord, Helpmeet of a Prophet, Mother in Zion,” *Ensign*, 1987 оны 3-р сар, 20-ийг үзнэ үү.
16. Дью, *Ezra Taft Benson*, 511-ийг үзнэ үү.
17. *Teachings: Ezra Taft Benson*, 229.
18. *Teachings: Ezra Taft Benson*, 11–12.
19. *Teachings: Ezra Taft Benson*, 229.

ХАРИУ ҮЙЛЧЛЭЛ

Би коллежийн нэгдүгээр курсийн Бюутан байхдаа өрөөний найзтайгаа хамт элэнц өвөөгийнх нь 98 настай дүү дээр нь зочилж очдог байв. Бид түүнийг элэгсэг дотноор авга ах Жое хэмээн дууддаг байв. Тэр ганцаараа амьдардаг бас ганцаарддаг байлаа. Тиймээс бид түүн дээр аль болох ойр ойрхон очихыг хичээдэг байв. Биднийг түүн дээр айлчилж очих үед тэр Мексикт амьдарч байсан тухайн үеийн болон Ногалес гэх мэт Аризонагийн ойролцоох тосгонуудын тухай түүхүүдийг

бидэнтэй хуваалцдаг байв.

Найз маань хэсэг хугацаагаар гэр рүүгээ буцах үед авга ах Жое дээр үргэлжлүүлэн очих Сүнсний өдөөлт надад мэдрэгдэв. Тэр дотны найз маань болсон учир би түүнийг жил хагасын дараа өөд болох хүртэл нь түүн дээр айлчилж очдог байлаа. Би найзаа алдсандаа гунигтай байсан ч түүнтэй хамт өнгөрүүлсэн үнэтэй цаг хугацаандаа талархалтай байсан юм.

Авга ах Жоег өнгөрснөөс хойш арван жилийн дараа би элэнц эмээгийнхээ тэмдэглэлийг уншиж байлаа. Тэр

тэмдэглэлд нөхөр нь түүнийг ямар ч мөнгөгүй, түрээсийн 30 долларын өртэй, тэжээх 9 ам бүлээ үлдээн хорвоог орхисон тухай өгүүлсэн байв.

Дараа нь тэр бичихдээ: “Бисби [Аризона] дэх хүмүүс бидэнд сайн ханддаг байв. Хэдийгээр бид Бисбийн өмнөд хэсэгт амьдарч байсан ч тэд биднийг [Сүмээс] гэртээ аваачдаг байв. Мексикт амьдардаг байсан Жосеф Клайнмэн ах биднийг олон удаа гэртээ аваачсан төдийгүй тэднийхэн бид бүгдийг оройн хоолоор дайлдаг байв. Тэд бидний маш

Авга ах Жое ганцаараа амьдардаг бас ганцаарддаг байлаа. Тиймээс би найзтайгаа хамт түүн дээр аль болох ойр ойрхон зочилж очихыг хичээдэг байв.



их дуртай туулайн шарсан мах, бүх төрлийн хачруудаар бидэнд үйлчилдэг байсан юм. Тэд Ногалес руу нүүхдээ бидэнд туулайнуудаа, мөн хөөрхөн цагаан туулайнуудаа хүртэл өгсөн. Иймээс бид идэж болох бүх юмтай үлдсэн” гэжээ.

Би үүнийг бүхэлд нь уншаад, миний элэнц эмэг эхэд тусалдаг байсан тэр Жозеф Клайнмэн бол авга ах Жое байсныг ойлгож билээ. Би элэнц эмэг эхэд минь болон түүний гэр бүлийнхэнд үзүүлдэг байсан сайхан сэтгэлийнх нь

хариуд өчүүхэн талархлаа илэрхийлээд, авга ах Жое дээр үргэлжлүүлэн айлчилж очих хэрэгтэй гэж Сүнсний шивнээгээр мэдэрсэн юм.

Би хайрын болон хариу үйлчлэлийн тухай түүхийн нэг хэсэг болсондоо сэтгэл догдолж байлаа. Их Эзэн хүүхдүүдээ мэддэг гэдгийг би мэднэ. Хэрэв бид Ариун Сүнсний өдөөлтүүдэд анхааралтай байх юм бол бид бусдын амьдралыг адислахын хамт эргээд өөрсдөө адислах болно. ■

Криси Чөрч Саммерс, АНУ, Юта

Намайг бишоптойгоо уулзахаар очиход тэр даруйхан намайг өрөөндөө угтан авав. Би яах учраа ололгүй, яагаад энд ирснээ тайлбарлахаар хичээж байлаа. Нүглээ ийм удаан нуусны дараа хаанаас нь эхлэхээ би бараг мэдэхгүй байв. Бүх зүйлээ ярихад бишоп намайг хайраар урамшуудан дэмжсэн юм. Би нүглээ ерөнхийд нь тайлбарлаад, гэм нүглийнхээ бүрэн жагсаалтыг гаргахад зориулж цаг өгөхийг түүнээс хүссэн юм. Тэр шууд хүлээн зөвшөөрөв.

Би нүглээ бүрэн хүлээгээгүй байсан ч мөрөн дээрээс дэлхийн хүнд ачаа дарамт авагдаж байгааг мэдэрсэн. Мөн би эрх чөлөөг болон эцэстээ энэ ачаанаас салж буй шинэхэн итгэл найдварыг мэдэрсэн юм.

Би дараагийн долоо хоногуудыг залбирч, судруудаас уншин, бишоптойгоо болон Тэнгэрлэг Эцэгтээ аль алинд нь үзүүлэх жагсаалтаа хийж өнгөрүүлсэн юм. Би гэмшиж байгаагаа, мөн өөрчлөгдөхийг чин сэтгэлээсээ хүсэж байгаагаа эхлээд Тэнгэрлэг Эцэгтээ мэдэгдэхийн тулд Түүнд харууссан зүрх, гэмшсэн сэтгэлээр жагсаалтаа үзүүлээ. Би бишоптойгоо өөр өдөр цаг тохирон, жагсаалтаа бүтнээр нь хуваалцав. Тэр ширүүн харж, хашгирч эсвэл намайг зэмлэсэнгүй; харин тэр намайг тэвэрсэн юм. Тэр намайг одоо л жинхэнэ наманчлалын зам дээр гарсныг хэлээд, өөрийнхөө болон Тэнгэрлэг Эцэгийн хайрыг надад илэрхийлсэн билээ. Би үүнийг үнэн гэдгийг мэдэж байсан.

Өмнө нь миний хамгийн том айдас байсан нүглээ хүлээх нь миний амьдралын хамгийн гайхалтай туршлагуудын нэг болсон юм. Энэ нь миний хувьд Есүс Христийн Цагаатгалын бэлэг ба эдгээгч хүчийг жинхэнэ утгаар нь ойлгох анхны алхам болсон билээ. ■
Нэрийг нууцлав

БИ НҮГЛЭЭ ХҮЛЭЭЖ БОЛОХ УУ?

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүний өмнө суух үед зүрхний цохилт түргэсэж эхлэв. Гадасны бичиг хэргийн ажилтан цаг тохирохоор над руу залгаснаас хойш надад тайван бус мэдрэмж төрсөн юм. *Тэр намайг үйлчлэхээр зохисгүй гэдгийг мэдэж байгаа болов уу?*

Эхнэртээ зовлон шаналал эсвэл ичгүүр авчрах зүйлүүдийг илчлэх нь амиа хичээсэн хэрэг болох байх гэж би бодоод, зарим нүглийг энэ дэлхий дээр илчилснээс Бурханы шүүлтийн суудлын өмнө илчлэх нь илүү амар гэж шийдээд байв. Эдгээр нүглийг өөрөө даван туулж, ачаа дарамттай амьдрах нь надад илүү дээр байсан юм. Ганцхан асуудал нь би өөрийнхөө хүчээр нүглээ ялан дийлж чадахгүй байв.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн дуудлага санал болгох

үед би тэнд сууж байлаа. Тэр “Та энэ дуудлагыг хүлээн авах уу?” Би “тийм ээ” гэж хашгирахыг ямар их хүссэн гээч. Гэвч үүний оронд бараг л албан шахалтаар “Би чадахгүй нь. Би зарим нүглээсээ цэвэрших хэрэгтэй байна” гэж өөрийнхөө хэлэхийг би сонсов.

Нүглийнхээ ерөнхий мөн чанарыг хүлээх үед айдас ба тайвшрал надад нэг зэрэг ирсэн юм. Тэр намайг бишоптой ярилцсан эсэхийг асуув. “Үгүй.” Эхнэртэйгээ? “Үгүй.” Тэр миний гарыг бариад, инээмсэглэн, нүглээ хүлээж байгаад минь надаар бахархаж байгаагаа хэлээд, бишоптойгоо болон эхнэртэйгээ ярилцах заавар өгч билээ.

Би түүний хэлснийг дуулгавартай дагаж, эхлээд эхнэртээ хэлж, хамгийн том айдсаасаа салав. Эхнэр минь намайг хайрласан хэвээр байв! Тийм ээ, тэр сэтгэл дундуур байсан. Бид хоёр зарим асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байсан ч эхнэр минь намайг хайрлаж, бишоп дээрээ очиход намайг дэмжсэн юм.

БИД ЗАМАА ДАГАСАН

Хамтрагч бид хоёр номлолын-хоо сүүлчийн бүс Бразилийн Сан Пауло мужийн хоёр тосгонд үйлчилж байлаа. Хоёр тосгоны хооронд ой дундуур нэгэн дөт зам байдаг байлаа. Бид тэр замыг аюултай, бас тэнд хэн нэгэнтэй тааралдах нь юу л бол гэж боддог тул тэр замаар огт явж үзээгүй байв.

Нэг өдөр биднийг тэр дөт замд ойртон ирэх үед Ариун Сүнс бидэнд ой руу орох хэрэгтэй хэмээн зүрх сэтгэлд минь шивнэхэд би ахлагч Андрэйд рүү харж, дөнгөж сая мэдэрсэн мэдрэмжийнхээ тухай хэлэв. Тэр бас адилхан зүйл мэдэрснээ надад хэлсэн юм.

Бид нөгөөх мэдэхгүй жимээр уруудсанаас хойш их удалгүй бидний өөдөөс нэгэн эмэгтэй ирж явааг харлаа. Жим нь нарийхан юм. Хажуугаар нь өнгөрөхдөө тэр эмэгтэйн уйлж байгааг бид анзаарлаа.

Тэр биднийг хараад, гэр рүүгээ дагаж очихыг урив. Бид гэрт нь очиж, нөхөртэй нь танилцсан юм. Бид сайн мэдээг хүлээн авахад бэлтгэгдсэн тэр хосод тэр даруй зааж эхлэв. Хэдэн долоо хоногийн дараа бид тэднийг баптисм хүртэхэд урилаа. Тойргийн сүүлийн баптисмаас хойш жил өнгөрөөд байсан учир тэднийг шууд хүлээн авсанд бид баяртай байв. Бид тэр өдөр ойн жим рүү орох сүнсний өдөөлтийн дагуу үйлдсэндээ талархалтай байдаг.

Гэвч тэдний баптисмын өмнөхөн эхнэр нь бидэнтэй ярилцах хэрэгтэй байгаагаа хэлэв. Тэр олон жилийн турш нэг л зүүд зүүдэлж байгаагаа бидэнд хэлсэн юм. Тэр зүүдэндээ өөрийгөө Сан Паулогийн гол хэсэгт байгаагаар хардаг байсан гэнэ. Нэгэн ахмад настай хүн түүн дээр ирж, амьдралыг чинь өөрчлөх хоёр залуу

ирж байна гэж хэлдэг байжээ. Тэр дараа нь тэр хоёр залууг ирж байгааг хардаг байсан ч зүүд нь үргэлж тэр хэсэгт хүрээд дуусдаг байсан байна.

Хэдэн долоо хоногийн өмнөх нэгэн өдөр нөгөөх хоёр залуу ойртон ирж байна, тиймээс түүнийг бидний анх харсан дөт жим рүү явах хэрэгтэй гэж нэгэн дуу хоолой түүнд хэлэх үед тэр байшингийнхаа шалыг шүүрдэж байжээ. Сүнсний өдөөлтийг ойлгоогүй ч гэсэн, зүүднийхээ хариултыг мэдэхийг хүссэн учраас тэр шүүрээ хаяад, ойн жим рүү алхсан ажээ.

Түүнийг алхаж байх үед зүүдэнд нь харагддаг хоёр хүний царай төрх эцэстээ тэр хоёр залуугийн царайтай яг адилхан, төгсөж байгаа

кино шиг түүний оюун ухаанд тод харагдсан ажээ. Тэр бас тэднийг хоёулаа хар өнгийн нэрийн тэмдэг зүүснийг харсан байна. Тэгээд хэдхэн мөчийн дараа тэр ахлагч Андрэйд бид хоёрыг жим дээр зогсож байгааг харсан гэв. Сэтгэл нь ихэд хөдөлсөн учраас тэр уйлж гарлаа.

Би өнөөдөр тэрхүү ариун туршлагыг санахдаа Сүнснийг мэрдэг бөгөөд сайн мэдээг хүлээн авсан тэр эгчийн урсаж буй нулимсыг ч бас оюун санаандаа дахин хардаг. Тэр өдөр хамтрагч бид хоёр Их Эзэний хүссэн тэр замаар явах мэдрэмжтэй мөн зоригтой байсан нь хамгийн талархууштай нь юм. ■

Бразил, Рио Гранде до Норте, Рут де Оливэриа Марколино

Бид нөгөөх мэдэхгүй жимээр уруудсанаас хойш их удалгүй бидний өөдөөс нэгэн эмэгтэй ирж явааг харлаа. Жим нь нарийхан юм. Хажуугаар нь өнгөрөхдөө тэр эмэгтэйн уйлж байгааг бид анзаарлаа.



ТА ЦЭЦЭГ АВМААР БАЙНА УУ?

Би эмнэлгийн хүүхдийн тасагт нэгэн онцгой хүндхэн ээлж хүлээлцсэний дараа ядарч, цухалдуухан байдалтай байлаа. Хамгаалалтын албаны ширээ рүү хүрч очоод, би гоёмсог цэцэг олж харлаа. Цэцэг ямар гоё харагдаж, бас ямар сайхан үнэртэж байгааг ширээний ард сууж байсан хүнд хэлэхэд тэр цэцгийг авч болно гэв.

Би маш их баяртай байлаа! Тэр өдрийг миний хувьд гэрэл гэгээтэй болгохын тулд энэ гоё цэцгийг аваг гэж Тэнгэрлэг Эцэг хүссэн нь гарцаагүй гэж би бодов.

Эмнэлгээс гарахаар явж байтал миний өмнө нэгэн тэргэнцэртэй эмэгтэй явж байлаа. Миний дотор давчдсан ч эцэст нь биднийг барилгаас гарах үед би түүний хажуугаар явж өнгөрөв. Намайг хажуугаар нь өнгөрөхөд нөгөөх эмэгтэй толгойгоо өндийлгөн, “Ямар гоё цэцэг вэ?” гэлээ. Би түүнд талархал илэрхийлээд, машиндаа хүлээж байсан нөхөр рүүгээ яаран алхав. Нөхөртөө цэцгээ харуулах гэж миний сэтгэл их догдолж байлаа.

Гэнэт би энэ цэцэг нөгөөх эмэгтэйд надаас илүү хэрэгтэй байгааг Ариун Сүнс хэлж буйг мэдэрсэн юм. Би цэцгийг түүнд өгөхдөө дурамжхан байсан ч сүнслэг өдөөлтийг дагав. Би энэ цэцгийг авмаар байна уу гэж асуухдаа түүнийг үгүй гэж хэлэх болов уу гэж бодож байлаа.

“Өө, тэгье л дээ. Би цэцгэнд дуртай. Гоё цэцэг байна” гэж тэр хариулав.

Би цэцгийг түүнд өгөөд, явахаар эргэтэл тэр мэгшин уйлж эхлэв. Та зүгээр үү гэж намайг асуухад сайхь эмэгтэй нөхөр нь олон жилийн өмнө нас барсан, хүүхдүүд нь түүн дээр ирэлгүй жил гаран болж байгааг надад ярилаа. Тэр өөрийг нь хайрладгаа харуулахыг Бурханаас гуйсан гэдгээ ч хэлэв.

“Та бол дуртай цэцгийг минь надад өгөхөөр Бурханаас илгээгдсэн тэнгэр элч. Тэр надад хайртайг би одоо мэдлээ” гэж сайхь эмэгтэй хэлж билээ.

Миний зүрх шархиран өвдөв. Би ийм л хувиа хичээсэн амьтан ажээ. Энэ эмэгтэйд хайрын үг хэрэгтэй байхад би түүнтэй ярилцахыг ч хүсээгүй. Би тэнгэр элч биш байв. Түүнээс салаад би уйлж эхэллээ.

Намайг машин руугаа очиход нөхөр маань надад юу тохиолдсоныг, бас цэцгээ яагаад өөр хүнд өгчихсөнийг асуув. Тэр эргэлзэх шиг санагдсан ч намайг болсон явдлаа ярихад тайвширсан юм.

“Би өнөөдөр чамд сарнай явуулсан. Чамд цэцэг хэрэгтэй гэж бодогдсон юм. Би чамайг тэр сарнайг хэн нэгэнд өгчихсэн юм биш биз дээ гэж санаа зовж байна. Хэрэв тэр цэцэг миний явуулсан сарнай биш юм бол цэцэг хаана байгаа юм бэ?” гэж нөхөр маань асуув.

Цэцгийн дэлгүүр сарнайг хүргэж өгөхөө мартсан болж таарав. Тиймээс бид цэцгийн дэлгүүр рүү явлаа. Нөхөр маань догтогш орж, удалгүй гоё баглаа цэцэг барин гарч ирсэн юм.

Би дахиад л уйлж эхлэв. Тэнгэрлэг Эцэг намайг илүү гайхалтай зүйл хүлээж байгааг, мөн Тэрээр Өөрийн ганцаардсан охинд хайртайгаа сануулах хэрэгтэй байгааг мэдсэн учраас гоё цэцгээ түүнд өгөхийг надаас хүссэн ажээ. ■

Синди Алмараз Антони, АНУ, Юта



Энэ цэцэг нөгөөх эмэгтэйд надаас илүү хэрэгтэй байгааг Ариун Сүнс хэлж буйг би гэнэт мэдэрсэн юм.



ҮРГЭЛЖ ХАМТДАА ЗӨВЛӨЛД

Хосуудад зориулсан гэр бүлийн зөвлөгөө

Никол Эк

Сүм дэх зөвлөлүүд нь Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгаас эхлээд гадас, тойрог, салбар, чуулга болон удирдлагын бусад зөвлөл хүртэлх түвшин бүрдээ тэнгэрлэг загварыг баримталдаг. “Гэр бүлээрээ зөвлөлдөх нь Сүмийн хамгийн чухал

Гэр бүлүүдэд олон сорилт бэрхшээл, шийдвэрлэх асуудал тулгардаг. Ханьтайгаа зөвлөлдөхөд эдгээр 6 зарчим тусалж чадна.

зөвлөл юм” гэж ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) хэлжээ.¹

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М.Рассэлл Баллард заахдаа “гэр бүлээрээ зөвлөлдөх нь үр дүнтэй харилцааг бий болгох хамгийн тохиромжтой хэлэлцэх газар юм” гэжээ.² Эдгээр нь “гэр бүл болон гэр бүлийн гишүүдийн хэрэгцээний талаар ярилцах, . . . асуудлуудаа шийдвэрлэх, гэр бүлийн шийдвэрээ гаргах, өдөр тутмын болон урт хугацааны гэр бүлийн үйл ажиллагаа, зорилгуудаа төлөвлөх цаг юм” гэж тэрээр тайлбарласан байна.³

Хэрэв та нар гэр бүлээрээ зөвлөлдөж байгаагүй бол өнөөдрөөс эхэлж болно. Хэрэв та хүүхдүүдтэй бол тэднийг оролцуулж болно. Гэсэн хэдий ч эхнэр, нөхрүүд гэр бүлийн болон хувийн асуудлуудаа хоёулхнаа ярилцах хэрэгтэй бол гэр бүлийн зөвлөгөөнөө тусдаа хийх нь бас чухал байдаг.

Эхнэр, нөхөр хоёр хоёулхнаа зөвлөлдөх үед хэрэгжүүлж болох

зарим зарчим, санал, зөвлөмжийг санал болгож байна.

Залбирлаар эхэл

“Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцах харилцаа тасрах үед, эхнэр нөхрийн хоорондын харилцаа ч бас тасардаг.”⁴

Их Эзэн та нарын гэрлэлтэд маш чухал үүрэг гүйцэтгэгч болж чадна. Та нар залбиралдаа ханийхаа төлөө болон олон адислалынхаа төлөө талархлаа илэрхийлж, ярилцах үед Сүнсээ илгээхийг Түүнээс гуйж болно. Түүний Сүнс та нарын ярилцаагыг удирдаж, сайхан мэдрэмж, сайн харилцааг дэмжин, тусалж чадна.

Хамтдаа шийд

“Их Эзэний тусламжийг авах урьдчилсан нөхцөл болох эв нэгдлийг хангахын тулд залбирч, харилцан ярилцсаны үндсэн дээр зөвлөлийн гишүүд зөвшилцөлд хүрэх ёстой.”⁵



Та болон гэр бүлийн тань хүн ажлын санал хүлээн авах, аль сургуульд элсэн орох, хэзээ хүүхдээ төрүүлэх, эсвэл гэрийн ажлаа хэрхэн хувааж хийх зэрэг чухал шийдвэр гаргах хэрэгтэй байж болно. Эхнэр, нөхрүүд асуудлыг шийдвэрлэхийн тулд аль болох боломжит шийдвэрийг санал болгож тэдгээрийн талаар ярилцаж ч болно. Эхнэрийнхээ эсвэл нөхрийнхөө санаа бодлыг даруухнаар сонс. Энэ нь санал бодлыг өөр өнцгөөс ойлгоход танд тусалж, ханийн тань санаа

бодол танд үнэ цэнэтэй болохыг сануулах болно.

Бид гэр бүлээрээ зөвлөлдөж байхдаа “харилцан буулт хийснээр биш, харин тэнгэрлэг зөвшилцлөөр”⁶ чухал шийдвэрээ гаргах ёстой. Асуудал болгон дээр тэр даруй нэгдмэл байдалд хүрэх нь та нарт боломжгүй байж болох юм. Ингэхийн тулд хэд хэдэн удаа зөвлөлдөж, тухайн асуудал дээр санал нэгдэхийн тулд ганцаараа болон ханьтайгаа хамт чин сэтгэлээсээ залбирч болно. Гэвч “та зөвлөлдөж

байхдаа танаас хүсэн хүлээдэг шиг бусдадаа боломж олгох юм бол Бурхан танд тулгарч буй асуудлын тань шийдлийг өгөх болно.”⁷

Гэр бүлээрээ зөвлөлдөх сэдвээ урьдчилан шийдэх нь тустай байж болно. Энэ нь та өөрөө болон эхнэр, нөхөр тань санал бодлоо илэрхийлэхдээ илүү бэлтгэлтэй байж болохын тулд тухайн сэдвийг тунгаан бодох цагийг танд өгнө.

Өөртөө үнэлэлт дүгнэлт өг

“Мөн чи яагаад ах дүүгийнхээ нүдэн дэх үртсийг болгоодог хэрнээ өөрийнхөө нүдэн дэх дүнзийг анзаардаггүй билээ?” (Матай 7:3).

Та ердөө ганцхан хүнийг, өөрийгөө л өөрчлөх хүч чадалтай. Та гэр бүлээрээ зөвлөлдөх цагаа эхнэр эсвэл нөхрөө шүүмжлэхэд ашиглахаар уруу татагдаж болох юм. Үүний оронд өөрийгөө сайжруулах хүслээр гэр бүлийн зөвлөгөөнд ханд. Өөрийнхөө үг ярианд юм уу, зан авирт эхнэр эсвэл нөхрийн тань санааг зовоодог ямар нэгэн асуудал бий эсэхийг, эсвэл санаа зовоосон ямар нэг зүйлийг эхнэр, нөхөр тань ажигласан эсэхийг асуу. Хувийн өсөлт хөгжлийн зорилго тавьж, өөрчлөгдөхөөр хичээх үедээ ханийнхаа тусламжийг хүсэж,



биедүүлэхийг хүсэж байгаа ямар ч зорилгыг нь урамшуулан дэмж.

Хүнд асуудлуудынхаа талаар ярилц

“Бүх гэр бүлд асуудал, бэрхшээлүүд тохиолддог. Гэвч амжилттай гэр бүлүүд нь шүүмжлэл болон хэрүүл маргаан үүсгэхийн оронд шийдлийг олохоор хамтран ажиллахыг хичээдэг.”⁸

Хүчирхэг гэр бүлүүд сорилт бэрхшээлийг үл тоомсорлосноор, эсвэл тэдгээрээс зайлсхийснээр биш, харин тэднийг даван туулснаар бий болдог. Хэлэлцэх шаардлагатай ноцтой асуудал бий болж болно. Жишээ нь, та гэм нүглийн болон нанманчлалын асуудлыг хэлэлцэх, эсвэл санхүүгийн ачаа дарамттай тэмцэх хэрэгтэй байж болох ч гэр бүлээрээ зөвлөлдөх үед иээн далангүй, чин үнэнч харилцаа нь хүчтэй мэдрэмжийг зөөллөхөд тусалж чадна. Гэр бүлээрээ зөвлөлдөх нь асуудлыг гаргаж ирэх, эсвэл тусламж хүсэх тохиромжтой бас ая тухтай хэлэлцүүлгийн үүрэг гүйцэтгэдэг.

Асуудлуудын боломжтой шийдэлд хүч, анхаарлаа төвлөрүүлж, хэрүүл маргаан, зөрчилдөөнөөс зайлсхий. Даруу бай. Ханьдаа хайраа илэрхийлж, аз жаргалтай мөнхийн гэрлэлт, гэр бүлийг байгуулахаар хамтдаа ажиллаж байгаа гэдгээ бие биедээ сануул.

Эерэг уур амьсгалаар хий

Хэрэв та гэр бүлийн зөвлөгөөнийг “сэтгэлийн дарамттай үед . . . хэзээ ч [гэр бүлийн гишүүдэд] хүлээн зөвшөөрч эсвэл магтаж урамшуулж мөн тэдэнд хайраа харуулахгүй нөхцөлд хийх юм бол гэр бүлийн гишүүд тань гэр бүлээрээ зөвлөлдөхөөс гэрэвдэг болно.”⁹

Гэр бүлийн бүх хурал нь асуудал бэрхшээлд юм уу, шийдвэр гаргахад төвлөрөх шаардлагагүй. Та ханийнхаа талаар ямар нэгэн сайн зүйлийг, эсвэл амьдралынхаа адислалуудыг хуваалцах боломж болгон үүнийг ашиглаж болно. Та нэгнийхээ гаргасан ололт амжилтыг тэмдэглэж, гэрлэлт ба гэр бүлээ сүнслэгээр

өсгөн төлөвшүүлэх арга замуудыг хэлэлцэн, зорилгоо хамтран гаргаж, ханийнхаа хүчирхэг зан чанарт болон үйлчлэл хийж байгааг нь талархал илэрхийлж болно. Гэр бүлийн зөвлөгөөнийг “ноцтой, хэцүү асуудал үүссэн үед [та болон эхнэр эсвэл нөхөр тань] найдаж болох өвөрмөц харилцаа, харилцан хүндэтгэлийг бий болгон хэвшүүлэхдээ” ашигла.¹⁰

Шаргуу тэмц

“Өдөр бүр хамгийн сайнаараа хийж, сайжрахаар хичээцгээе. Бид өөрсдөөсөө алдаа дутагдал олж харсан үедээ тэдгээрийг засахаар хичээж чадна. Бид өөрсдөдөө болон хайртай хүмүүстээ байдаг алдаа дутагдалд илүү уучламтгай хандаж чадна.”¹¹

Эцэст нь, муу харилцааны зуршлыг эерэг загвараар солиход цаг хугацаа болон дадал хэвшил шаардана гэдгийг сана. Танай гэр бүлийн анхны зөвлөгөөн эвгүй эсвэл цочирдмоор байж болно. Гэвч бие биетэйгээ даруухан





БИД ЮУНЫ ТАЛААР ЯРИЛЦДАГ ВЭ?

Хэрэв та гэр бүлээрээ зөвлөлдөхдөө юуны талаар ярилцахаа мэдэхгүй байгаа бол эдгээртэй адил асуултуудыг өөрсдөөсөө асуугаарай.

- Гишүүн бүр гэр орны ажил үүргээ хуваалцаж, хийж байгаа зүйлийнхээ талаар сэтгэл хангалуун байхын тулд бид гэрийн ажлаа хэрхэн хуваан хийж болох вэ?
- Ямар төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг бид гэр орондоо үзэж болох вэ?
- Бид гэр бүлээрээ хамтдаа ямар шинэ чадваруудад суралцаж чадах вэ?
- Бид маргалдаж, ам муруйхаа багасгахын тулд гэр бүлээрээ юу хийж чадах вэ?
- Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахихад ямар үйл ажиллагаанууд биднийг урамшуулан дэмжих вэ?
- Бид байгалийн гамшигт хэрхэн бэлтгэж болох вэ?
- Бид нийгмийн оролцоогоо хэрхэн сайжруулах вэ?
- Бид гэр бүлээрээ ямар шинэ уламжлалуудыг эхлүүлж чадах вэ?
- Бид санхүүгээ хэрхэн илүү сайн зохицуулж чадах вэ?
- Бид гэрлэлтээ сүнслэгээр хүчирхэгжүүлэхийн тулд юу хийж чадах вэ?

харилцахаар хичээж, гаргах шийдвэртээ Их Эзэнийг оролцуулснаар та гэр бүлээрээ зөвлөлдсөнөөс ирэх тэрхүү адислалуудыг илүү сайн ойлгох болно.

Их Эзэн биднийг гэр орондоо болон өөр хоорондын харилцаандаа дөлгөөн тайван байгаасай гэж хүсдэг. Тэр биднийг бүтэлгүйтэх үед бидэнд тусалж, бидний хичээл зүтгэлийг адисалдаг. Бид Түүний тусламжтайгаар ерөнхийлөгч Томас С.Монсоны амласанчлан гэр орноо “газар дэлхий дээрх тэнгэрийн нэг хэсэг”¹² болгодог “хүндэтгэл, ойлголт, эв нэгдлийн уур амьсгалыг” бүрэлдүүлж чадна.”¹³ ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. *Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* (2006), 211.

2. М. Рассэл Баллард, *Counseling with Our Councils: Learning to Minister Together in the Church and in the Family* (1997), 18–19.
3. М. Рассэл Баллард, “Family Councils: A Conversation with Elder and Sister Ballard,” *Луахона*, 2003 оны 6-р сар, 14.
4. М. Рассэл Баллард, “Family Councils,” *Луахона*, 17.
5. Роналд И.Поэмэн, “Priesthood Councils: Key to Meeting Temporal and Spiritual Needs,” *Ensign*, 1980 оны 5-р сар, 91.
6. Роналд И.Поэмэн, “Priesthood Councils,” 91.
7. Стивэн А Ричардс, Conference Report, 1953 оны 10-р сар, 86.
8. Эзра Тафт Бэнсон, “Counsel to the Saints,” *Ensign*, 1984 оны 5-р сар, 6.
9. *When Thou Art Converted, Strengthen Thy Brethren* (Melchizedek Priesthood study guide, 1974), 168.
10. “Family Councils: A Heavenly Pattern,” *Follow Me: Relief Society Personal Study Guide* (1989), 171.
11. Рассэл М.Нэлсон “Perfection Pending,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 88.
12. “Working Together in Family Councils,” *Ensign*, 1985 оны 2-р сар, 31.
13. Томас С.Монсон, “Hallmarks of a Happy Home,” *Ensign*, 1988 оны 11-р сар, 69.

Гэрлэх зориг

Крисчиан Хаггланд

Би номлолынхоо дараа Шведэд гэртээ эргэн ирсний дараа, амьдралын дараагийн алхам— ариун сүмийн гэрлэлт миний хувьд удаан хугацаанд санаа зовоосон асуудал байлаа. Сүнс надад, чи ямар хүн болох ёстой билээ, тийм л хүн болохын тулд гэр бүлтэй болох хэрэгтэй гэж дахин дахин баталж байлаа. Өөртөө тохирох мөнхийн ханиа олчихсон, Их Эзэн миний сонголтыг зөвшөөрсөн гэсэн мэдрэмж надад төрдөг байсан ч энэ нь амьдралд минь хэр зэрэг чухал шийдвэр вэ гэдэгт ихэд анхаардаг байсан учраас миний итгэл гуйвж байв. Би гэрлэх амлалтаасаа айсан учраас сүй тавихаасаа бүр өмнө найз охин Эвэлинтэйгээ ариун сүмд лацдан холбогдох цагаа сонгож, бал сараа захиалан, сүйн бөгжнүүдээ худалдаад авчихсан байв. Бидний гэрлэлт салалтаар төгссөн тохиолдолд шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээхээс айсан учраас Тэнгэрлэг Эцэг намайг Эвэлинтэй гэрлэхээр зарлиг болгоосой гэж би хүсэж байлаа. Айдас болон буруу залбирлууд намайг хүлээгдэж байгаа чухал шийдвэрээ гаргах чадваргүй болгон чөдөрлөсөн юм.



Би амьдралынхаа хамгийн чухал шийдвэрийг гаргахдаа үйлдүүлэхийн оронд үйлдэхэд сонгох эрхээ ашиглаж сурсан юм.

Сонгох эрх—Их Эзэний арга зам

Намайг Сургаал ба Гэрээ 58:26–29-р хэсгийг унших үед Ариун Сүнсний өдөөлтүүд эцэст нь өөрчлөлт гаргасан билээ: “Учрыг болгоогтун, бүх зүйлд би зарлиглах нь тохирохгүй бөлгөө; учир нь бүх зүйлд албадуулдаг тэр нь [лазан] юм. . . .

“ . . . Хүмүүс сайн зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориулж, мөн чөлөөт хүсэл зоригоороо олон зүйлийг хийж, мөн туйлын зөв шударга байдлыг тохиолгохоор авчрах ёстой;

“Учир нь хүч тэдэнд буй, үүгээр тэд өөрсдийнхөө төлөө сонгогчид юм. . . .

“Тэвч түүнд зарлиглах хүртэл юу ч хийдэггүй, мөн зарлигийг зүрх сэтгэлийн эргэлзээтэйгээр хүлээн авдаг, мөн үүнийг залхуугаар сахидаг тэр нь, мөнхүү тэр нь ялагддаг бөлгөө.”

Би эдгээр шүлгийг тунгаан бодоод бодлыг минь өөрчилж, надад урагш тэмүүлэх зориг өгсөн Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөн дэх сонгох эрхийн үүргийн талаар ойлгож авсан юм. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г. Скотт, хэрэв бид өөрсдийн хичээл зүтгэлгүйгээр сүнслэг удирдамж хүлээн авдаг байсан бол “[биднийг] Сүнсээр хэрхэн хөтлөгдөхийг сурахаар

хичээх үед” ирдэг “чухал шаардлагатай хувийн өсөлтөө”¹ алдах байсан гэж заажээ.

Урагш тэмүүлэх хүч

Би тэгээд итгэлээ хөгжүүлж, шийдвэрээ гаргахаар шийдсэн бөгөөд Их Эзэн намайг шийдвэр гаргах чадвартаа итгэх итгэлээр адисалсан юм. Би өөрийн хүслээр сүй тавих хэрэгтэй . . . бас [өөрийн] чөлөөт хүслээр сүй тавих гэх мэт олон зүйлийг хийх хэрэгтэйгээ ойлгосон. Их Эзэн биднийг өөрсдийгөө удирдахын тулд сонгох эрхийнхээ дагуу хүчээ ашиглахад урамшуулан дэмждэг. Энэхүү хүчээ ашиглах нь бидний амьдралын гол онцлог юм.

Их Эзэн биднийг үргэлж төгс шийдвэр гаргахыг харахаасаа илүү сонгох эрхээ ашиглаасай гэж хүсдэг гэдэгт би итгэдэг. Гэвч Тэр ялангуяа хэнтэй гэрлэхээ шийдэх шаардлагатай үед бидэнд сайн шийдвэр гаргахад шаардлагатай хэрэгслүүдийг өгсөн байдаг. Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) “Сэтгэлийн хөдөлгөөн шийдвэрийг бүхэлд нь тодорхойлох ёсгүй. Гэвч мацаг барьж, залбиран, нухацтай тунгаан бодсоны үр дүнд хүчирхэгжсэн оюун ухаан хийгээд зүрх сэтгэл нь гэр бүлийн аз жаргалын



хамгийн их боломжийг хүнд өгөх болно. Энэ нь золиослол, хуваалцах болон аминч бус агуу үзлийг авчирдаг” гэж заажээ.²

Бидэнд бас сүнслэг баталгааг хэрхэн хүлээн авах талаар: “Чи үүнийг оюундаа тунгаан бодох ёстой; дараа нь энэ нь зөв үү гэдгийг чи надаас асуух ёстой, мөн энэ нь зөв аваас цээжин биеийг чинь чиний дотор шатахаар болгоно би; тиймийн тул, энэ нь зөв юм байна гэдгийг чи мэдрэх болно.

Гэвч энэ нь зөв биш аваас чамд ийм мэдрэмж байхгүй байх болно, харин дүйнгэ бодол санаа чамд

байх болно” (С ба Г 9:8–9) гэсэн судрын удирдамж байдаг. Гэсэн хэдий ч бид бүгд Их Эзэний Сүнсний баталгааг хүлээн авахдаа цээжиндээ шатах мэт мэдрэмжийг мэдрэхгүй. Бидний хүн нэг бүр эдгээр баталгааг хүлээн авах өөрийн тодорхой арга замуудыг таньж сурах хэрэгтэй.³ Бид энэхүү загварыг дагаснаар сонголт хийх чадвартаа итгэдэг болно.

Тэнгэрлэг Эцэг миний зүрх сэтгэл, сүнсний болон оюун санааны хэрэгцээг мэдэж байсан. Тэр бүх зүйлийг өөрчлөгч эдгээр үнэнийг надад өгсөн билээ. Эвэлин бид хоёр гэрлэж, одоо аз жаргалтай гэр бүлийн амьдралаар амьдраад олон жил болж байна. Бас 3 сайхан хүүхэдтэй болсон. Би сонгох эрхийн талаар, мөн амьдралын хамгийн чухал шийдвэр гаргах үед сонгох эрх болон үүгээр хүлээх үүргийн талаар гэрчлэлтэй болсондоо Их Эзэнд маш их талархаж байна. ■

Уг өгүүллийг зохиогч нь Шведийн Стокгольм хотод амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. Ричард Г. Скотт, “Сүнсний удирдамж хүлээн авахын тулд,” *Лиакхона*, 2009 оны 11-р сар, 7.
2. Спэнсэр В. Кимбалл, “Oneness in Marriage,” *Лиакхона*, 2002 оны 10-р сар, 36.
3. Мөн Сургаал ба Гэрээ 8:2–3-ыг үзнэ үү.

2015 ОНЫ МЮЧЕЛИЙН СЭДЭВ

“Тиймийн тул, Ай, Бурханы үйлчлэлийг эхэлж байгаа та нар эцсийн өдөр Бурханы өмнө буруугүй зогсож болохын тулд та нар бүхий л зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа түүнд үйлчлэхээ мэдэгтүн” (С ба Г 4:2).



АЙ, БУРХАНЫ ҮЙЛЧЛЭЛИЙГ

ЭХЭЭЛЖ

БАЙГАА ТА НАР

БҮХИЙ Л БИЕ СЭТГЭЛЭЭРЭЭ ҮЙЛЧЛЭХ НЬ

Залуу эмэгтэйчүүдийн бүлгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл

Бид 2015 оны Мючелийн урианаас Бурханд үйлчлэх нь эрхэм ариун онцгой боломж гэдгийг сурсан билээ. Энэ жил бидний хүн нэг бүр илүү их үүрэг амлалттайгаар, Аврагчийн заасан арга замаар— бүхий л зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа үйлчлэхэд суралцана гэж бид найдаж байна. Бид үүнийг хэрхэн хийх вэ? Энд хэдэн санаа дурдав.

Эхлээд бид бүх зүрх сэтгэлээрээ үйлчилдэг. Бид үүнийг Бурханд үйлчлэх та нарын үйлчлэл Түүнийг болон Түүний хүүхдүүдийг хайрлах та нарын хайраар өдөөгдөх ёстой гэж ойлгодог. “Их Эзэнийг хайрлах бидний хайр нь бусдыг энэрэх, шаардагдах цаг хугацаа, өөрсдийн сонирхдог зүйлсийг хөөцөлдөх болон эн тэргүүнд анхаарах ёстой зүйлсийн дэс дараа зэргийг зохицуулах болно.”¹ Та нар Их Эзэний зарлигуудыг сахиснаар Түүнийг хайрлах хайраа харуулдаг (С ба Г 42:29-ийг үзнэ үү). Та нар гэр орондоо үйлчилснээр гэр бүлээ хүчирхэгжүүлдэг. Та нар дуудлагаа эрхэмлэн биелүүлж, найз хэрэгтэй байгаа хүмүүс дээр хүрч очдог. Та нар гэр бүлийн нэрсээ авч, ариун сүм рүү орохоор эрж хайдаг.



Ерөнхийлөгч Бонни Л.Оскарсон (голд нь); нэгдүгээр зөвлөх Кэрол Ф.Макконки (зүүн талд); хоёрдугаар зөвлөх Нийл Ф.Марриот, (баруун талд)

Хоёрдугаарт, бид бүх **хүчин чадлаараа** үйлчилдэг. Мөн бидэнд биеийн хүчний хөдөлмөр, хичээнгүй зүтгэл шаардагддаг. Номлолын ажил нь хүч чадал болон тэсвэр тэвчээр шаарддаг. Та нар “өлссөнийг хооллох, нүцгэнийг хувцаслах, өвчтэйд очиж мөн сүнсийг нь мөн биеийг нь ч аль алиныг нь асрах” (Мозая 4:26) гэх мэт бусдын хэрэгцээнд анхаарал тавьж чадлаараа үйлчилдэг.

Дараа нь, бид бүх **оюунаараа** үйлчилдэг. Та нарын бодол Аврагчид төвлөрсөн, цэвэр ариун байх ёстой. Та нар Түүнийг үргэлж санахаар гэрээнд орсон билээ. Та нар судар судалж, залбирснаар Ариун Сүнний удирдамжийг эрэлхийлж чадна. Бодол санаа, үг яриа, үйлдүүдээ та нар Их Эзэний оюун болон хүсэлтэй нийцүүлсэн үед бусдын хэрэгцээг ялган таньж, зөв зохистой байж, үйлчлэхэд бэлэн болно.

Эцэст нь, бид Бурханд бүх **хүчин чадлаараа** үйлчилдэг. Хүч чадлыг олж авах нэг арга зам нь Аврагчийн Цагаатгалд итгэх итгэлээ хөгжүүлэх явдал юм. Түүний зарлигуудад дуулгавартай байснаараа та нар наманчилж, өөрсдийгөө нүглээс цэвэрлэж чадна. Та нар Их Эзэний хүчээр үйлчилснээр Аврагчийн боломж олгогч хүчийг мэдэрч, гайхамшгуудыг гэрчлэх болно (Алма 26:12-ыг үзнэ үү).

Та нар Бурханд чин сэтгэлээсээ үйлчлэх үед Тэр та нарыг нүглээс цэвэршигдэж, Түүний өмнө зогсон Түүний алдар сууг хүлээн авахад бэлтгэгдэнэ гэж амладаг. ■

ЭШЛЭЛ

1. Эзра Тафт Бэнсон, “The Great Commandment—Love the Lord,” *Ensign*, 1988 оны 5-р сар, 4.

ЭНЭХҮҮ ГАЙХАМШИГТАЙ АЖИЛ

Залуу эрэгтэйчүүдийн бүлгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл

Та нар *хөлөг онгоцонд суух* гэдэг үгийг сонсоод юуны тухай боддог вэ? Далайд хөвж яваа хөлөг онгоцыг уу? Агуу зорилгод нэгдэх тухай юу? Эхэлж буй аяллын талаар уу?

Та нар “Бурханы үйлчлэлийг эхэлснээрээ” хамгийн агуу аялалд нэгдэж байгаа билээ. Та нар Бурханд ажлаа яаравчлахад нь тусалж байгаа бөгөөд энэ нь агуу, баяр хөөртэй, гайхамшигтай туршлага юм.

Зөвхөн бидний үгээр битгий бай. Өнгөрсөн жил Ютагийн нэгэн жижиг тосгонд багш нарын чуулгын залуу эрэгтэйчүүд үйл ажиллагааны санаанууд олохоор (lds.org/youth/activities) өсвөр үеийнхний вэб сайт руу орж үзжээ. Ялангуяа “Үйлчлэлийн долоон өдөр” гэсэн санаа тэдний анхаарлыг татсан ажээ.

Эдгээр залуу эрэгтэй том ч хамаагүй ямар нэгэн зүйл хийхээр шийджээ. Тэд тойргийнхоо хүсэлт гаргасан хэн нэгэнд бүтэн долоо хоногийн турш өдөр бүр үйлчлэл хийхээр болов. 19 гэр бүл гарын үсэг зурахад залуу эрэгтэйчүүд бага зэрэг гайхширсан ч бас санаа нь зовсон байх. Тэд ийм богинохон хугацаанд хэрхэн ийм олон үйлчлэл хийж чадах билээ дээ. Гэвч тэд амалт өгсөн учраас бүх гэр бүлд үйлчлэхээр шийдэв.



Ерөнхийлөгч Дэвид Л.Бэк (голд нь); нэгдүгээр зөвлөх Ларри М.Гибсон (зүүн талд); хоёрдугаар зөвлөх Рандалл Л.Ригг (баруун талд)

Ганцхан долоо хоногийн дотор тэд том чулуунууд зөөх, элсний сав ухах, усны шуудуу цэвэрлэх, мод хураах гэх мэт төслүүдэд нийтээрээ оролцон үйлчлэл хийхэд 250 гаруй цаг зарцуулжээ. Энэ нь залуу эрэгтэйчүүдийг өөрсдийг нь бас өөрчилсөн байна.

Тэд мэдэрсэн хүч чадал, хүлээн авсан адислалууддаа гайхан биширчээ. Тэд чуулгаараа эв нэгдлийг мэдэрснээ, мөн гэрийн даалгавар болон бусад үүрэг хариуцлагаа биелүүлэхдээ тэнгэрлэг тусламж хүлээн авснаа дүрслэн ярьсан юм. Одоо, тэдний тойрогт үйлчлэл хэрэгтэй болох үед багш нарын чуулга идэвх санаачлагатай хариулдаг. Тэд зөвхөн нэг долоо хоногийн турш үйлчлэх биш, өдөр бүр үйлчлэхийг хичээдэг.

Үйлчлэх болон Бурханы хаант улсыг байгуулах нь гайхамшигтай ажил билээ. Энэ нь эдгээр залуу эрэгтэйд баяр баясгаланг авчирсан бөгөөд та нар бусдыг өргөж, цэвэр ариун ба үнэнч хичээл зүтгэлээр өөрчлөгдсөн тэдний амьдралыг харах үед энэ нь та нарт баяр баясгаланг авчрах болно. Залуу эмэгтэйчүүдийн бүлгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл 48-р хуудсан дээр хэлсэнчлэн, Бурханд үйлчлэх нь онцгой боломж юм.

Яг одоо “бүхий л зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа” (С ба Г 4:2) Бурханд үйлчилж эхлэгтүн. Бид та нарын үйлчлэлийн туршлагуудын талаар мэдэхийг хүсэж байна! Үйлчлэл хийж байгаа бичлэгээ хийж, зурагнуудаа аваад тэдгээрийг олон нийтийн мэдээллийн сайтууд руу оруулж, гэр бүлийнхэн болон найз нөхөдтэйгөө хуваалцан, lahona@ldschurch.org хаяг руу э-мэйл бичиж болно. Та нар бас өсвөр үеийнхний вэбсайт дээр тавигдсан зүйлүүдийнхээ талаар бусдад хэлж болно. Энэхүү гайхамшигтай ажилд та нар өөрсөдтэйгөө нэгдэхэд бусдыг уригун, тэгээд бид дэлхийг хэр их өөрчилж чадахаа харцгаая. ■

НЭГ УДАА НЭГ АЛХМААР

Италийн өсвөр үеийнхэн Бурханг хэрхэн бүхий л зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа үйлчилдэг тухайгаа хуваалцаж байна.

Хиллари Олсэн

Та нар энэ жилийн Мючелийн уриа нь үйлчлэлийн талаар гэдгийг мэдсэн учир юу хийх гэж байна вэ? Их Эзэн та нарыг *бүхий л зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа үйлчлээсэй* гэж хүсдэг билээ (С ба Г 4:2-ыг үзнэ үү). Энэ нь үнэхээр их, дааж давшгүй мэт санагдаж болох юм. Гэвч тийм биш.

“Энэ нь ууланд авирахтай л адил” гэж Италийн Тарантогийн Марко Д. хэлэв. “Нэг удаад бүхэл ууланд нэгмөсөн авирах талаар бодох нь хэцүү ч гэсэн хэрэв та нэг удаад нэг алхмаар урагшлах юм бол энэ нь маш амар болно. Нэг хөлөө нөгөөгийнх нь урд тавьж, нэг удаад нэг алх, ‘Би үүнийг хийчихлээ’ гэж бодсоны дараа дараагийн алхмаа хий.”

Италийн пицца, гоймон болон замын хучлагын чулуунуудын дунд, өмнөд Италийн өсвөр үеийнхэн *бүхий л зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа үйлчлэхээр хичээхдээ анхаарлаа хандуулах ашиг тустай хэдэн алхам олж мэджээ.*

СҮНСЛЭГ УДИРДАМЖ ЭРЭЛХИЙЛ

Сүнслэг удирдамж хүлээн авах нь Их Эзэнд үйлчлэх чухал алхам бөгөөд өөрөөсөө хамаарах хүчин чармайлтыг гаргахгүй л юм бол энэ нь боломжгүй гэдгийг 15 настай Давиде С. мэддэг ажээ. “Би Бурханы мутар дахь зэмсэг байхыг хүсэж байна,” “Би Сүнсний өдөөлтүүдийг хүлээн авч, дагахад бэлэн байх ёстой. Үүнийг хийхийн тулд би өөрийгөө Их Эзэний зүйлүүдээр байнга хүрээлүүлэх хэрэгтэй” гэж тэр хэлэв.

Давиде болон түүний гэр бүлийнхэн Сүмд хөрвөгдсөн. Давиде баптисм хүртэхээсээ өмнө судраас судлах нь хэр чухал болохыг сурчээ. Ах нь хамгийн түрүүнд баптисм хүртсэн бөгөөд удалгүй эцэг эх нь баптисм хүртсэн байна. Давиде хувийн гэрчлэлтэй болох хэрэгтэй гэдгээ мэдэж байлаа. Тэр Мормоны Номыг судалж байхдаа Сүнсийг мэдэрчээ. Мэдэрсэн сайхан мэдрэмжүүд нь Сүмд нэгдэх шийдвэр гаргахад нь түүнд тусалсан байна.

Дөрвөн жил өнгөрсөн ч Давиде Сүнсний удирдамжинд найдсаар байна. “Бид тууштай байх ёстой. Бид судраас судалж, залбирахдаа хайнга хандаж болохгүй” гэж тэр хэлдэг.

ЦЭВЭР АРИУН БАЙ

17 настай Марко Д. зарлигуудад, ялангуяа ариун явдлын хуулинд дуулгавартай байхын ач холбогдлыг онцлон тэмдэглэж байна. “Дайсан биднийг гутаан доромжлохыг хичээж, бүх төрлийн арга замаар уруу татдаг.” “Найзууд бас муу нөлөө үзүүлж болно” гэж Марко хэлэв. Хэдэн жилийн өмнө Марко найзууд нь сонголтоо хийхэд нь сөргөөр

нөлөөлж байгааг олж мэдсэн учраас цагийг хамтдаа өнгөрүүлдэг байсан найзуудаа солих ёстой болжээ.

Заримдаа бид ууланд авирах үедээ бүдэрч унаж болно. Ийм зүйл тохиолдох үед “бишоп дээрээ очиж, түүнтэй илэн далангүй ярилц” гэж Марко уриалав. “Бишоп бол бидний ах. Бид түүнд итгэж болно.”

Дуулгавартай, цэвэр ариун байх хүчин чармайлт нь Маркод одоо Бурханд үйлчлэх боломж олгож байгаа бөгөөд мөн тэдгээр нь түүнийг хожмын нэгэн өдөр номлолд үйлчлэхүйц зохистой байхад бэлтгэж байгаа юм.

ЦАГ ГАРГА

17 настай Мануел М. Бурханд үйлчлэх нь үргэлж амар байдаггүйг ойлгодог. “Бид заримдаа соригддог” гэж Мануел хэлжээ. “Бид заримдаа өөр зүйл хиймээр санагддаг. Заримдаа унтаж, хөл бөмбөгийн тоглолт үзэж, эсвэл найзуудтайгаа хамт зугаалмаар санагддаг. Гэвч бид Их Эзэнд үйлчлэхийг сонгох ёстой гэж ээж надад үргэлж заадаг юм. Өөр бусад зүйлийг хийж болох ч Их Эзэнд үйлчлэхийг бид эн тэргүүнд тавих ёстой.”

14 настай Мириам Д. түүний хувьд өдөр бүр залбирдаг бөгөөд судраас судалж, залбирах цорын



ганц арга зам бол тодорхой цаг гаргах гэдгийг мэддэг. “Цагаа төлөвлөсөн үед илүү ихийг хийх боломжтой юм шиг надад санагддаг” гэж Мириам хэлжээ. “Үүнээс гадна, бид Их Эзэнд илүү их цаг заваа зориулах үед энэ нь биднийг хүчирхэг болгосноор бид ихээр уруу татагдаж чадахгүй.”

САЙН ДУРААРАА ҮЙЛЧИЛ

15 настай Сабрина Д.-гийн хувьд бүхий л зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа үйлчилнэ гэдэг нь *buona volontà* гэсэн утгатай ажээ. Энэ нь аливаа зүйлийг хүсэлтэй, баяр хөөртэй хийх гэсэн үг юм.

12 настай Алессио Ай: “Танай бишоп эсвэл эцэг эх чамд хэлж байгаа учраас л үүнийг хийх нь утгагүй хэрэг юм. Чи заавал биелүүлэх ёстой гэж бодох хэрэггүй. Их Эзэн биднийг зөв учир шалтгаанаар үйлчлээсэй л гэж хүсдэг.”

Бид үйлчилж байхдаа хэрхэн илүү их *buona volontà*-тай болж болох вэ? “Судруудыг унших нь үйлчлэл бол хийх зөв зүйл гэдгийг бидэнд заадаг учраас тэдгээр нь надад тусалдаг” гэж Сабрина хэлжээ.

Цагаатгалыг илүү сайн судалж, ойлгох нь бидэнд илүү их хүсэлтэй, бас баяр хөөртэй үйлчлэхэд тусалдаг. 17 настай Элвиса Д. “Бидний төлөө бүх зүйлээ золиосолсон Өөрийн Хүүг илгээсэн Тэнгэрлэг Эцэгтэй адил, бид Их Эзэнд үйлчлэхдээ чадах бүхнээ зориулах хүсэлтэй байх хэрэгтэй” гэж хэлжээ.



БУСДАД АНХААРЛАА ХАНДУУЛ

16 настай Гиулиа, 14 настай Вэроника Д. эгч хоёр бусдад анхаарал хандуулах нь чухал гэдгийг мэддэг. “Үйлчлэл нь хүмүүсийг өөрөөр харахад бидэнд тусалдаг. Та нар хэн нэгэнд үйлчлэх үед аль аль нь адислагддаг” гэж Гиулиа хэлэв.

Вэроника: “Нэг удаа би сайн мэдээг хуваалцахыг үнэхээр их хүсэж байсан ч бэлэн биш юм шиг

санагдсанаас айж байлаа. Гэвч би үйлчилж байсан хүмүүстээ анхаарлаа төвлөрүүлэх үед Их Эзэн надад туслах болно гэдгийг мэдэж байсан учраас илүү их итгэлтэй болсон” гэж хэлжээ.

Гиулиа, Вэроника хоёр найз Виржинидаа амьдралыг нь өөрчлөх арга замаар үйлчлэх боломжтой байлаа. Тэд өөрсөдтэйгөө хамт Сүмийн үйл ажиллагаануудад ирэхэд түүнийг урьж эхлэв. Тэд бас Виржиниягийн гэр бүлийг өөрсдийнхөө гэр бүлтэй хамт ямар нэгэн зүйл хийхэд урьдаг байлаа. Удаалгүй Виржиниягийн гэр бүл номлогчидтой уулзаж эхлэв. Нэг жилийн дараа Виржиния бяцхан эмэгтэй дүүгийнхээ хамт баптисм хүртжээ.

Тэр одоо Сүмийн гишүүн болсон учир эргэн тойрныхоо хүмүүст үйлчлэх арга замыг хайж байна. Заримдаа сургуулийнх нь найзууд түүний шинэ шашныг шоолон тохуурхдаг. Тиймээс тэр хэнтэй ярилцах хэрэгтэйгээ мэдэхийн тулд залбирдаг. Нэг өдөр Сүнс түүнд таньдаг нэг охиндоо ярих хэрэгтэй гэж шивнэжээ. “Би түүнд Мормоны Ном өгөөд, надтай хамт сүм дээр

ирэхэд урив. Тэр ирсэн! Тэр одоо Мормоны Ном уншиж байгаа.”

14 настай Самуэл Д. чуулгын гишүүдээ хүчирхэгжүүлэх боломжийг хайж байна. “Би чуулгынхаа бусад эрэгтэй хүүхдийг ангидаа урамшуулан дэмжсэнээр тэдэнд туслахыг хичээдэг. Заримдаа тэд хичээлд оролцохоос ичдэг эсвэл айдаг. Бусдыг өөртөө итгэх итгэлтэй болоход туслах нь тэднийг Бурханд үйлчилж, ирээдүйн үүрэг хариуцлагууддаа бэлтгэж чадах нэг арга зам мөн” гэж тэр ярьжээ.


ОДОО ЭХЭЛ

Тиймээс *та нар* одоо юу хийх гэж байна вэ? Алесслио Ай: “Би өөрчлөлт хийхийн тулд том болох хүртлээ хүлээх хэрэггүй. Би үүнийг яг одоо л хийх хэрэгтэй” гэжээ.

Та нар Их Эзэний ажлын үнэ цэнэтэй хэсэг гэдгээ ойлгох үед тань эдгээр алхам нь та нарт ч бас туслах болно. Нэг удаад нэг алхам хий. Та нар Их Эзэнд үйлчлэхдээ бүхнээ зориулж сурах үед чухал өөрчлөлтүүдийг бий болгох болно. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.






БУХ

ЗҮРХ СЭТГЭЛЭЭРЭЭ

БУРХАНД ҮЙЛЧИЛ



БУХ

ОЮУНААРАА

БУРХАНД ҮЙЛЧИЛ



БУРХАНД БУХ

ХҮЧ ЧАДЛААРАА

ҮЙЛЧИЛ

БУХ

ХҮЧ ЧАДЛААРАА

БУРХАНД ҮЙЛЧИЛ



БҮХ ОЮУНААРАА БУРХАНД ҮЙЛЧИЛ

“Эргэцүүлэн бодох хүч нь Бурханы бэлэг юм. ... Бид хэрхэн сэтгэн бодох нь хандлага хийгээд зан төлөв, түүнчлэн энэ амьдралын дараах бидний байдалд ихээр нөлөөлнө” (Судруудын удирдамж, “Бодол санаа” scriptures.lds.org). Хэрэв бид сайн сайхныг эрэлхийлэх аваас бидний оюун илүү сайн суралцаж мөн өөрчлөгддөг. Энд Бурханд бүх оюунаараа үйлчлэх хэдэн санааг дор дурдав:

- Судруудыг болон хожмын үеийн бошиглогчдын үгсийг судал.
- Бусдын талаар болон өөрийнхөө талаар эерэг бодолтой бай.
- Мэдлэгийг, ялангуяа ухаан бодлыг сэнхрүүлдэг зүйлсийг эрэлхийл.
- Үр дүнтэй, урам хайрласан үйл ажиллагааг сонго.
- Өөрийнхөө хувьд чухал ямар нэгэн зүйлийг, жишээ нь, Сүмийн түүхэн дэх аль нэг үйл явдлыг, эсвэл өвөг дээдсээ судал.
- Ариун ёслолын үеэр бодол санаагаа Аврагч дээр төвлөрүүл.
- Тэмдэглэл хөтөлж, үүнийгээ үе үе эргэн харж бай.

БҮХ ЗҮРХ СЭТГЭЛЭЭРЭЭ БУРХАНД ҮЙЛЧИЛ

Зүрх бол амьдралыг тэтгэгч эрхтэн. “Зүрх” гэдэг үг нь ямар нэгэн зүйлийн гол эсвэл үндсэн хэсэг бөгөөд хүсэл бодол, сэтгэлийн хөдөлгөөн оршдог газар юм. Бурханд бүхий л зүрх сэтгэлээрээ үйлчилнэ гэдэг нь бүх хүсэл, эрч хүч, хайраа Түүнд зориулна гэсэн үг юм. Тэрээр биднийг Түүний зарлигуудыг дагаж, бусдыг хайрласнаараа Түүнийг хайрлахыг биднээс хүсдэг. Үүнийг хийх хэдэн санааг дор дурдав:

- Залбирах, судраас судлах, Сүмд явахыг хувийнхаа хүслээс дээгүүр тавь.
- Гэр бүлдээ эсвэл сургууль дээрээ хэн нэгэнд өрөвч, сайхан сэтгэл гарга.
- Өөр хэн нэгний хийхийг хүсэж байгаа зүйлийг хийхэд цагаа зарцуул.
- Хэн нэгэнд ямар байгааг ойлгохыг хичээ.
- Хэн нэгэнд чин сэтгэлийн талархал илэрхийл.
- Ганцаардаж байгаа хэн нэгэнтэй ярилц эсвэл хажууд нь суу.

БҮХ ХҮЧ ЧАДЛААРАА ҮЙЛЧИЛ

Бидний Бурханд үйлчилдэг эрч хүч нь Түүнд бүх хүч чадлаа зориулахын нэг хэсэг нь юм. Хүч чадал нь түүнчлэн сүнслэг хүч, дотоод шийдвэр төгс байдал, уян хатан байдал болон сайн үйлс бүтээх хичээл зүтгэл юм. Бид Аврагчийн амьдарсан тэр зарчмуудын дагуу амьдарснаар хүч чадлаа үзүүлж чадна. Дараа нь бид тэнгэрлэг сүнслэг хүч чадлыг хүлээн авч чадна. Бүх хүч чадлаараа үйлчлэх хэдэн санааг доор дурдав:

- Судар судлахдаа анхаарлаа бүрэн төвлөрүүл.
- Тойрог эсвэл салбарынхаа хүмүүстэй эв нэгдэлтэй хамтран ажилла.
- Ёс суртахууны жишгүүдээ тууштай хамгаал.
- Бусдыг адислахын тулд Ариун Сүнснээс хүлээн авсан өдөөлтүүдийнхээ дагуу үйлд.
- Зөв шударга амьдрах амлалт өгч, уруу таталтууд ирэх үед амласандаа хүр.
- Тэжээллэг хүнс ба дасгалаар дамжуулан бие махбоддоо анхаарал тавь.
- Илүү агуу сүнслэг хүч олж авахын тулд гэрээнүүдээ сахь.

БҮХ ХҮЧ ЧАДЛААРАА ҮЙЛЧИЛ

Хүч чадлаараа үйлчилнэ гэдэг нь энгийнээр бол хийх боломжтой зүйлээ сүнслэгээр болон биеийн хүчээр, аль алинаар нь хийж, мөн бусдад анхаарлаа хандуулахыг хэлдэг. Бид өөртөө байдаг (хэцүү нөхцөлд хүнд буйданг түвэгшээлгүй өргөхөөс эхлэн) ямар ч авьяас чадварыг бусдыг хүчирхэгжүүлэхдээ ашиглаж болно. Бүх хүч чадлаараа үйлчлэх хэдэн санааг дор дурдав:

- “Өнөөдөр хэнд миний тусламж хэрэгтэй вэ?” гэж өөрөөсөө асуу, тэгээд үүний талаар ямар нэгэн зүйл хий.
- Хэн нэгэнд үүдний довжоогоо шүүрдэх, өрөөгөө цэвэрлэх эсвэл аяга тавгаа угаах гэх мэт ямар нэг ажлыг нь хийж өг.
- Машин эсвэл компьютер засах, өрөөгөө гоёх, гараараа бэлэг хийх, шүлэг бичих гэхчилэн авьяас чадвараа ашигла.
- Анд найз ба сайн үлгэр жишээ байх арга замыг олж мэд.
- Сурсан чадвараа хэн нэгэнд заа.

ХӨЛӨГ ОНГОЦОНД СУУ

“Тиймийн тул, Ай, Бурханы үйлчлэлийг эхэлж байгаа та нар эцсийн өдөр Бурханы өмнө буруугүй зогсож чадал, оюун хийгээд болохын тулд та нар бүхий л зүрх сэтгэл, хүчин чадлаараа түүнд үйлчлэхээ мэдэгтүн.”

(С ба Г 4:2)



Есүс Христ

ЯАГААД МИНИЙ АМЬДРАЛД

Чухал

БАЙР СУУРЬ
ЭЗЭЛДЭГ ВЭ?

*Бид өөрсдийнхөө төлөө Аврагчийн
хийдэг бүх зүйлийг ойлгосон үед
Тэр бидний амьдралд хамгийн
чухал хүн болдог.*



**НЯМ ГАРГИЙН
ХИЧЭЭЛҮҮД**

.....
Энэ сарын сэдэв:

Бурхан Тэргүүтэн

Майкл Р.Моррис

Сүмийн сэтгүүлүүд

Аврагч өөрийнх нь өдөр тутмын амьдралд хэрхэн чухал байр суурь эзэлдэг тухай нэг зохиогчийн блог дээр тавигдсан өгүүллийг би саяхан уншсан юм. Би түүнийг санал бодлоо хуваалцах хүсэлтэй байсанд нь баяртай байсан ч өөр нэг уншигчийн “Тэр миний амьдралд хэзээ ч чухал байгаагүй, одоо ч, цаашид ч гэсэн чухал болохгүй” гэсэн хариулт намайг гуниглуулсан юм.

Тэр уншигчийн буруу ч гэж юу байхав дээ. Эрт орой хэзээ нэгэн цагт бидний хүн нэг бүрд Аврагч хэрэгтэй болно. Бид өөрсдөө засаж чадахгүй алдаа дутагдал гаргаж, нөхөж чадахгүй гарз хохирол үзэн; өвчин зовлон, хавчлага дарамт, гай гамшиг, ачаа дарамт хийгээд ганцаараа даван гарч чадахгүй урам хугаралттай тулгарах болно.

Бид эдгээрийг ганцаараа даван *туулахгүй* гэдэг нь сайн мэдээ юм.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Беднар: “Бид сул дорой байдлаасаа болж “Ийм хүнд ачааг хэн ч мэдэхгүй, хэн ч ойлгохгүй шүү дээ” хэмээн дуу алдан хашгирч мэднэ. Харин Бурханы Хүү төгс мэдэж, төгс ойлгодог, учир нь Тэр бидний хүн нэг бүрийн ачааг мэдэрч, үүрсэн юм. Тэр Өөрийн хязгааргүй хийгээд мөнхийн золиослолын улмаас (Алма 34:14-ийг үзнэ үү) сэтгэл санааны зовлонг төгс ойлгодог бөгөөд бидэнд нигүүлслийн мутраа сунгаж чадна” гэж хэлжээ.¹

Биднийг Есүст болон Түүний Эцэгт эргэн очих үед Тэр Өөрийн Цагаатгал, сургаалууд, найдвар, амар амгалан, үлгэр жишээгээрээ дамжуулан бидэнд амьдралаа өөрчилж, зовлон бэрхшээлтэй тулгарахад болон итгэлтэй урагшлахад тусалдаг учраас Тэр бидний амьдралд чухал байр суурь эзэлдэг.

Есүс наманчлалыг боломжтой болгосон

Есүс Өөрийг нь дагахаар чин сэтгэлээсээ хичээж буй хүмүүсийн хувьд чухал байгаа шалтгаануудын нэг нь бид бүгд унасан бөгөөд бидний хүн нэг бүрд Цагаатгалаар дамжуулан санал болгосон наманчлалын бэлэг хэрэгтэй байдаг явдал юм.

Биднийг бүдэрч, унах үед Сатан биднийг босож, зөв зам дээрээ эргэн гарах зохисгүй гэж бодуулахыг хүсдэг. Тэр биднийг сайн мэдээ бол “*наманчлалын* сайн мэдээ” (С ба Г С 13:1; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) гэдгийг мартаасай гэж хүсдэг. Гэвч “Нүглээ наманчлагч нүгэлтнийг өршөөж, цэвэршүүлдэг Христийн ач ивээл үнэн бодитойг бид мэднэ.”²

Есүс Христийн Цагаатгалын хүч нь бидний хүн нэг бүрд боломжтой хэдий ч бид үүнийг амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд сонголт хийх ёстой. Найздаа нэгэн онцгой бэлэг—түүнд үнэхээр их хэрэгтэй ямар



нэгэн зүйлийг, золиослол гарган бэлдсэн ямар нэгэн зүйлээ өгч байна гээд бод л доо. Тэгтэл найз чинь “Баярлалаа, гэхдээ би үнэхээр чиний бэлгийг авахыг хүсэхгүй байна” гэж хариулжээ гэж төсөөлөн бод. Танд ямар санагдах байсан бэ?

Бид наманчлалаар дамжуулан цэвэр болохдоо Есүсийг бидэнд туслахыг уриагүй бол бид түүний бэлгээс татгалзаж байгаатай адил юм.

Есүс үнэнийг заадаг

Нэг удаа, олон хүн Есүстэй цаашид хамт явахаас татгалзсаны дараа



Тэрээр 12 дагалдагчаасаа “Та нар бас явахыг хүсэж байна уу?” гэж асуухад Петр Түүнд “Эзэн, бид хэн рүү явах юм бэ” (Иохан 6:67–68) гэж хариулжээ.

Та нар Аврагчийн “мөнх амьдралын үгсийг” судруудаас, Түүний амьд бошиглогчдын сургаал, Ариун Сүнсний шивнээнүүдээс олж болно. Тэдгээр нь “энэ амьдралд аз жаргалыг, ирэх дэлхийд мөнх амьдралын”³ үндсийг санал болгодог бөгөөд Тэнгэрлэг Эцэгт болон Аврагчид аюулгүй эргэн очиход биднийг удирддаг юм.

Аврагчийн заасан агуу үнэнүүдийн зарим нь юу вэ? Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Дийтр Ф.Угдорф саяхан Ерөнхий чуулган дээр үг хэлэхдээ 4 зүйлийг дурдсан юм:

- “Бидний Эцэг аз жаргалын төлөвлөгөөг хүүхдүүдээ өгсөн билээ.”
- “Цагаатгалаар дамжуулан . . . бид хайртай хүмүүстэйгээ үүрд хамт амьдарч чадна.”
- “Бид өвчинд эсвэл эмгэг согогт автахгүй алдар суутай, төгс, үхэшгүй бие махбодтой болно.”
- “Бидний гуниг ба хагацлын нулимс элбэг дэлбэг аз жаргал, баяр баяслаар солигдох болно.”⁴

Есүс найдвар төрүүлдэг

Бид ноцтой сорилт бэрхшээлүүдтэй тулгарах үедээ Их Эзэнд итгэх нь хэцүү гэж боддог. Гэвч Түүнд итгэх нь сорилт бэрхшээлүүдээ даван туулахад хэрэгтэй итгэл найдварыг бидэнд авчирдаг.

Энэ нь Жийн А.Стивэнс эгчийн тойрогт амьдардаг Гатреллийн гэр бүлийн гишүүдэд тохиолдсон зүйл юм. Хүүхдийн хэсгийн ерөнхий

ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Стивэнс эгч хэлэхдээ: Гатрелл ахыг хавдартай гэж оношлогдсоны дараа ч тэр гэр бүл сайн мэдээнд болон ариун сүмийн гэрээнүүддээ үнэнч байв. Үүнийг хийснээр тэд энэ амьдралын дараа дахин хамт амьдрах болно гэсэн Бурханы амлалтуудад найдах найдварыг олсон юм гэжээ.

Нөхрөө өөд болохоос өмнөх тэр хүндхэн өдрүүдэд Гатрелл эгч: “Их Эзэн биднийг харж хандаж байсныг би мэдэж байсан. Бид Их Эзэнд итгэж найдвал амьдралын ямар ч бэрхшээлийг даван гарч чадна”⁵ гэж хэлжээ.

Цагаатгалын бэлэг нь бидэнд мөнх амьдралын итгэл найдварыг болон зовлон бэрхшээл тохиолдох эсвэл хайртай нэгнээсээ хагацах үед бидэнд хэрэгтэй ямар нэгэн зүйлийг өгдөг билээ.

“Гэсэн хэдий ч бидний Тэнгэрлэг Эцэг бидэнд Өөрийн Хайрт Хүү, Есүс Христ, бидний Аврагчийг бэлэг болгон өгсөн. Есүс Христийн Цагаатгалын агуу бэлэг ба адислалыг бүх хүнд боломжтой болгодог өв нь амилуулалтын амлалтыг болон мөнх амьдралыг төрөх бүх хүмүүнд боломжтой болгодог билээ” гэж Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Хэнри Б.Айринг хэлжээ.⁶

Есүс амар амгаланг өгдөг

Та нар байгалийн гамшигт өртөж, хорон санаат хов живэнд орооцолдож, амьдралыг тань өөрчилсөн сорилт бэрхшээлтэй тулгаран, найз нөхөдтэйгөө маргалдаж, эсвэл зөв зүйлийн төлөө зогсож үзсэн бол Аврагчийн амар амгалан хэрэгтэйг мэднэ. “Аврагчийн амар амгалан дэлхийн хуйларч буй хар салхийг ялан дийлдэг” гэж Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн хэлжээ.⁷



Саяхны нэгэн Ерөнхий чуулган дээр ахлагч Андэрсэн уламжлалт гэрлэлтийн талаарх итгэл үнэмшлийнхээ төлөө зогсоноосоо болж шоолуулж, нэр хоч авсан Лоорэлын насны нэг охины талаар хуваалцсан юм. Доог дохуу нь заримдаа “Бурханд болон Түүний амьд бошиглогчдын сургаалуудад үнэнч байх”-ын төлөөс болдгийг тэр мэджээ.⁸

Гэвч зогсоно гэдэг нь ганцаараа зогсоно гэсэн үг биш юм. Бидэнд ганцаардсан эсвэл цөхөрсөн, гуньсан эсвэл санаа зовсон, айсан эсвэл үнэ цэнэгүй юм шиг мэдрэмж төрөх үед бид үргэлж Энх амгалангийн Ханхүүд хандаж болно. Бид дараах зүйлсийг хийснээр үүнийг хийж болно:

- Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгахын төлөө Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирснаар
- Судруудаар болон амьд бошиглогчдоор илчлэгдсэн Их Эзэний үгсийг уншсанаар
- Ариун сүмд орсноор
- Сүм болон семинар дээр Аврагчийн амьдралыг судалснаар
- Нүглээ наманчилж, Түүний Цагаатгалыг хэрэгжүүлснээр
- Түүний талаарх гэрчлэлээ хуваалцсанаар

Бид Аврагчийн амар амгаланг мэдрэх үед бидний зүрх сэтгэл шаналах юм уу айх хэрэггүй болно (Иохан 14:26–27-г үзнэ үү).

Ерөнхийлөгч Томас С.Монсон “Зөвхөн бидний Эзэн л бидний сорилт, өвчин шаналал, зовлон бэрхшээлийн хүнд хүчрийг мэддэг. Зөвхөн Тэр л бидэнд гай зовлонгийн дунд мөнхийн амар амгаланг өгч чадна. Зөвхөн Тэр л бидний шаналж буй зүрх сэтгэлийг тайтгарлын үгсээр тайвшруулж чадна”⁹ гэж хэлжээ.

Есүс үлгэр жишээ үзүүлдэг

Есүс тохинууллынхаа туршид зөвхөн аз жаргалд хүрэх замыг заасан төдийгүй мөн тэр зам руу удирдсан билээ. Тэрээр Цагаатгалаараа дамжуулан биднийг хайрлахад удирдсан юм. Тэрээр Өөрийн сургаалуудаар дамжуулан биднийг мөнхийн үнэнүүд рүү удирдсан билээ. Тэрээр Өөрийн төгс амьдралаар дамжуулан биднийг дуулгавартай байдлын зам руу удирдсан юм.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скотт “Энэ дэлхий дээр оршиж байсан хамгийн агуу үлгэр жишээ бол бидний Аврагч Есүс Христ юм. Түүний мөнх бус тохинуулал бусдад зааж, үйлчилж, хайрлаж байсан” гэж хэлжээ. Тэр цааш нь “Аврагч биднийг Өөрийн төгс үлгэр жишээг дагахад урьдаг билээ” хэмээн хэлсэн юм.¹⁰

Аврагч наманчлал, амилуулалыг боломжтой болгож, чухал

үнэнүүдийг заан, найдварыг болон амар амгаланг санал болгож, мөн төгс үлгэр жишээ үзүүлснийг бид ойлгосон үед Тэр бидний амьдралд чухал байр суурь эзэлдэг. Бидний найзын хувьд Түүнтэй хамт бид айдсаа зайлуулж, итгэлтэй урагшлах зоригтой байдаг билээ. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Дэвид А.Бэднар, “Тэд ачаагаа амархан дааж чадахын тулд,” *Лиахона*, 2014 оны 5-р сар, 105.
2. Д. Тодд Кристоффэрсон, “Есүс Христийн амиалалт,” *Лиахона*, 2014 оны 5-р сар, 132.
3. “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл *Лиахона*, 2000 оны 4-р сар, 3.
4. Дийтр Ф.Угдорф, “Ямар ч нөхцөл байдалд талархалтай байх нь,” *Лиахона*, 2014 оны 5-р сар, 90.
5. Жийн А.Стивэнс, “Бүү айгтун; Учир нь Би чамтай хамт байна,” *Лиахона*, 2014 оны 5-р сар, 98.
6. Хэнри Б.Айринг, “Үнэлж баршгүй найдварын өв,” *Лиахона*, 2014 оны 5-р сар, 37.
7. Нийл Л.Андэрсэн, “Сүнслэг шуурганууд,” *Лиахона*, 2014 оны 5-р сар, 32.
8. Нийл Л.Андэрсэн, “Сүнслэг шуурганууд,” 19–20-ыг үзнэ үү.
9. Томас С.Монсон, “Би чамайг хаяхгүй мөн орхихгүй” *Лиахона*, 2013 оны 11-р сар, 87
10. Ричард Г.Скотт, “Би та нарт жишээ үзүүлсэн юм,” *Лиахона*, 2014 оны 5-р сар, 50.

ЯРИЛЦЛАГАД ОРОЛЦ

Ням гарагт тунгаан бодох зүйлс

- Есүс Христийн Цагаатгал таны амьдралыг хэрхэн адисалсан бэ?
- Есүсийн ямар үгс таныг тайвшруулдаг вэ?
- Та Ариун Сүнсээр дамжуулан Аврагчийн амар амгаланг мэдэрсэн үеэ бодож чадах уу?

Таны хийж болох зүйлс

- Дараагийн удаа зөвийг сонгоход тань туслах Аврагчийн үлгэр жишээ эсвэл сургаалуудыг тэмдэглэл дээрээ бич.
- Ариун ёслолоос хүртэхээр бэлтгэхдээ Цагаатгалыг судал.
- Гэр бүлийнхэнтэйгээ хамт, Сүм дээр эсвэл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр Есүс Христийн талаарх бодол санаагаа хуваалц.



Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын
ахлагч
Роберт Д.Хэйлс

МӨНХИЙН ЗОРИЛГУУДДАА ХЭРХЭН ХҮРЭХ ВЭ

Та нарыг энэ дэлхий дээрх зорилгоо биелүүлэхэд тань баяр баясгалан бэлэглэх амьдралын чухал хэдэн зорилгыг—Тэнгэр дэх Эцэгтээ хүндэтгэлтэйгээр эргэн очиход тань туслах мөнхийн зорилгуудыг би та нарт санал болгохыг хүсэж байна.

1. **Ариун сүмд гэрлэ** мөн гэр бүл, ажил мэргэжил, боловсролоо үргэлжлүүлэх, сонирхдог зүйл болон үзвэр үйлчилгээ гэх мэт амьдралын олон талт асуудлуудыг залбирч тэнцвэржүүлэн, **мөнхийн гэр бүлийн харилцаагаа сайжруул**.
2. **Итгэл бишрэлийнхээ дагуу** итгэлтэй, дуулгавартай амьдарч, мөн амьдралын **сайн зүйлүүдийг ямагт нөөцөлснөөр** баптисмд болон ариун сүмийн гэрээнүүддээ үнэнч бай.
3. Хаант улсын зүйлс нь мөнхийнх бөгөөд дэлхийн зүйлс нь материаллаг буюу цаг зуурынх гэдгийг санаж, **мөнхийн зорилгуудаа үргэлжлүүл**.

4. Амьдралынхаа турш **бүхнээ зориулан үйлчилж**, мөн та нарын **хайр** болон бусад **дэмжлэг** шаардлагатай байж болох **тэдгээр хүмүүст үргэлж анхаарлаа хандуул**.

Эдгээр нь гүйцэлдүүлэхэд анхаарал, цаг хугацаа шаарддаг амьдралын турш үргэлжлэх зорилгууд юм. Эдгээр зорилгыг тавих нь хангалттай биш; бид тэдгээрийг хэрэгжүүлэх **төлөвлөгөө гаргах** хэрэгтэй.

Өнөө орой эсвэл маргааш **амьдралынхаа** турш юунд хүрэхийг хүсэж байгаа болон **зорилгууд** тань юу байж болох **талаар** тунгаан бод. Тэднийг **бичиж тэмдэглэх цаг гаргаж**, мөн дараагийн жилүүдэд **тэдгээрийг эргэж дүгнэ**. Тэгээд өнөөдөр, маргааш, ирэх долоо хоногт болон хэдэн сарын дараа эдгээр зорилгодоо хүрэхийн тулд хийж чадах зүйлсээ өөрөөсөө асуухад цаг гарга.

Та нар эдгээр чухал, мөнхийн зорилгоо хэрхэн сонгож, тодорхойлогч вэ? Мөн тэдгээр нь чухал учраас та нар тэдгээрийг гүйцэлдүүлэх төлөвлөгөөг хэрхэн гаргах вэ? Санамж: Та нарынхаар цаг хугацаа бол чухал—бүр чухал хүчин зүйл юм.

Одоо та нарын зүгээс, мөнхийн зорилгуудаа биелүүлэхэд тодорхойгүй цаг хугацаа байгаа юм шиг санагдаж байж болох юм.

Хүн бүхэнд цаг зав байдаг. Энэ бол үнэн. Гэвч цаг өнгөрч байна гэдэг нь бид өсөж дэвшиж байна гэсэн үг биш юм.

“Учир нь болгоогтун, энэ амьдрал бол хүмүүн Бурхантай уулзахаар бэлтгэх үе; тийм ээ, болгоогтун энэ амьдралын өдөр бол хүмүүн өөрсдийн хөдөлмөрийг гүйцэтгэх өдөр юм” (Алма 34:32).

Нууц нь тэнгэрлэг сүнслэг зорилгуудаа хүрэхэд бидэнд туслах үйл ажиллагааг ухаалгаар сонгох явдал юм. Тэгээд биднийг мөнхийн хувь тавилангаас маань сарниулах эсвэл холдуулах ямар нэгэн зүйлээс зайлсхийх хүч чадалтай бай.

Хэрэв та нар **цагаа ухаалгаар ашиглах** юм бол та нарын дэлхий дээрх цаг хугацаа бэлтгэлээ хийхэд мөн амьдралын зорилгоо хэрэгжүүлэх ажил хөдөлмөрөө гүйцэтгэхэд хангалттай гэдгийг би гэрчилж байна. Та нарт өсвөр насандаа одоо үүнийг хийхээс илүү дээр цаг гэж үгүй билээ (Алма 37:35-ыг үзнэ үү). ■

2004 оны 12-р сарын 11-нд Айдоха дахь Бригам Янгийн Их Сургууль дээр хэлсэн нээлтийн үгээс авав.





МИНИЙ АМЬДРАЛЫН ЧУХАЛ ЗҮЙЛ

*Би Христийн тохинууллын талаар Библээс мэддэг байсан.
Харин Тэр үнэхээр Америк тивд айлчилж очсон гэж үү?*

Робэрто Пакэсо Прэтэл

Намайг 18 нас хүрэхэд аав маань намайг хүссэн сүмдээ баптисм хүртэхийг зөвшөөрсөн юм. Би хэд хэдэн цуглаанд явж, Библийг судалж, Есүс Христэд итгэдэг байсан учир Христийн сүмд нэгдэхийг хүсэж байв.

Нэг өдөр манай авга ах хоёр эмэгтэй номлогчийг манай гэрт урьсан байв. Тэд Есүс Христийг Америк тивд айлчилсныг дурдаад, Түүний өөр нэгэн гэрч болох Мормоны Номонд итгэдэг тухайгаа маш итгэлтэй ярьсан юм.

Тэр үед би амьдралдаа энэ талаар хэзээ ч сонсож байгаагүй учраас тэд андуурсан байх гэж бодсоноо хэлсэн юм. Номлогчдын нэг нь нүдэндээ нулимстай, бас эелдгээр “Робэрто ах аа, та Мормоны Ном үнэн гэдгийг мэдэхгүй учраас бид андуурч байгаа гэсэн үг биш шүү дээ. Есүс Христ бидэнд хайртай. Тэр энэ тивд хүрч ирэн, Ариун газарт заасан шигээ Өөрийн

сайн мэдээг заасныг би мэднэ” гэж хэлсэн юм.

Тэд дараагийн долоо хоногт над дээр дахин ирэхийг зөвшөөрөн, анхны ярилцлагынхаа үеэр миний олон асуулт ба эргэлзээнд туслахаар хичээж байв.

Тэр шөнө би Мормоны Номыг гүйлгэн харж эхэлсэн юм. Намайг оршил хэсгийг уншиж байтал: “Есүс бол өөрийгөө бүх үндэстэнд батлан харуулж буй Христ, Мөнхийн Бурхан” гэсэн нэг өгүүлбэр анхаарлыг минь татав. Би бас Америк тивд айлчилсан Аврагчийн талаар 3 Нифай 11-ийг уншиж, зүрх сэтгэлдээ баяр баясгаланг мэдрэв. Тиймээс би номлогчдын хийхийг хүссэн тэр зүйлийг хийж, өвдөг сөгдөн суугаад, Тэнгэрлэг Эцэгээс энэ ном үнэн эсэхийг асуусан билээ.

Би залбирч дуусаад, амар амгаланг болон энэ ном үнэн гэдгийг баттай мэдрэв. Хэсэг хугацаанд би эгч нарын нулимс миний сэтгэлийг

хөдөлгөснийг, мөн тэдний гэрчлэлд итгэх боломжийг надад олгосныг тунгаан бодож билээ. Тиймээс би өглөөний 4 цаг бага зэрэг өнгөртөл Мормоны Номыг үргэлжлүүлэн уншив. Би залбирах бүрдээ Христ Америк тивд очсон гэсэн баталгааг болон Тэр намайг Түүний үнэн сайн мэдээний талаар илүү ихийг сураасай гэж хүсэж байгааг илүү хүчтэй мэдэрч байлаа.

Хэдэн долоо хоногийн дотор би Мормоны Номыг уншиж дуусгасан бөгөөд үнэн Сүмд баптисм хүртэх хэрэгтэй гэдгээ мэдэрсэн юм.

Мормоны Номыг унших нь надад Есүс Христэд илүү ойртоход, мөн Түүнийг амьдралынхаа төвд тавихад надад тусалсан юм. Аврагчийг номлогчдоо болон Өөрийн Сүмийг миний зам дээр байрлуулсанд би маш их талархалтай байна. ■

Зохиогч нь Перугийн Арекуйнад амьдардаг.

НҮДЭЭ ОЛСОН ХАРИУЛТ

Би харамч байсан боловч өөрчлөгдсөн. Одоо би сайн мэдээг хуваалцахыг хүсэж байна. Би муу нэр хүндээ хэрхэн залруулж болох вэ?

Юуны өмнө айдас тань та нарыг бүү зогсоог. Хэрэв та нар Сүнсийг мэдэрч, наманчилж, өөрчлөгдөхөөр хичээж байгаа бол энэ нь гайхалтай зүйл юм. Энэхүү өөрчлөлт нь Есүс Христийн ач ивээлийн боломж олгогч хүчээр хэрэгждэгийг сана. Түүний тусламжтайгаар та нар шинэ хүн болж, нэр хүндээ өөрчилж чадна. Тэр та нарт сайн мэдээг хуваалцахад тань туслах болно. Нэр хүндээ өөрчлөх нь цаг шаардах хэдий ч энэ нь үнэ цэнэтэй зүйл юм. Та нарын тэрхүү үйл явцдаа хийж болох зөвхөн цөөн зүйлийг дор жагсаав:

- Гомдоосон гэж мэдэж байгаа хүмүүсээсээ уучлал гуй.
- Өмнө нь сайхан сэтгэлээр хандаж байгаагүй хүмүүст сайхан сэтгэлээр хандах арга замыг ол.
- Үргэлж чин сэтгэлээсээ, байгаагаараа бай.
- Хэрэв таны хамтдаа цагаа өнгөрүүлж байгаа хүмүүс бусдад таагүй хандаж байгаа бол тэднийг болиул эсвэл тэдэнтэй нийлэхээ боль. Эс тэгвээс хүмүүс чамайг тэдэнтэй адил мэт ойлгох болно.
- Моронай 7-г судалж, энэрлийн төлөө залбир. ■

Аврагч зөрчилдөөний сүнс нь чөтгөрөөс ирдэг хэмээн хэлсэн (3 Нифай 11:29-ийг үзнэ үү).

Хүмүүстэй санал нийлэхгүй байх болон тэдэнтэй зөрчилдөхийн ялгаа нь юу вэ?

Хүмүүс өөр өөр үзэл бодолтой байх нь хэвийн зүйл бөгөөд Есүс Христийн дагалдагчдад итгэдэг зүйлсийнхээ төлөө зогсох шаардлагатай үеүд байдаг. Гэвч бид уурлан, хурц ширүүн аргаар, үг хэлээр

доромжлолгүй эерэг, үнэн зөв арга замаар байр сууриа илэрхийлэх хэрэгтэй. Тиймээс бид маргаан зөрчилдөөнөөс хэрхэн зайлсхийж чадах вэ?

Бид “санал зөрөлдөөнөө илэрхийлэхгүйгээр санал нийлэхгүй” байж

болно гэдгийг та нар магадгүй сонссон байх. Зөрчилдөөнөөс зайлсхийх нь та нарын хүсэл, эрмэлзлээс эхэлдэг. Судруудад “их зан маргаан мэтгэлцээнд л хүргэдэг” (Сургаалт үгс 13:10) хэмээн өгүүлдэг. Хэрэв та нар “маргаанд ялахад” юм уу, “өөрийгөө зөвтгөхөд” илүү анхаарах юм бол зөрчилдөөний сүнсийг дагаж байгаа нь бараг тодорхой юм.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Рассэлл М.Нэлсон зөрчилдөөнөөс зайлсхийх зарим

арга замыг заасан юм: (1) “бусдад хайр энэрлээ үзүүлэх”, (2) “хувийн эрх ашгийнхаа төлөө эсвэл алдар хүнд хүлээн авахын тулд зөрчилдөөний сүнстэйгээр ярих эсвэл бичих хүслээ хазаарлах”, мөн (3) “хүлцэнгүй даруухнаар Бурханыг үнэнчээр [хайрлах].”¹ Тэгснээр бид зөрчилдөөний Сүнсийг биш, харин Их Эзэний Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгаж чадна. ■

ЭШЛЭЛ

1. Рассэлл М.Нэлсон, “The Canker of Contention,” *Ensign*, 1989 оны 5-р сар, 70–71.

Хамгийн сайн бэлгээ ӨГӨХ НЬ

Би найздаа өмнө нь хэзээ ч авч байгаагүй төрсөн өдрийн хамгийн сайхан бэлгийг өгсөн.

Мариэла Родригүз

Намайг 13 настай байхад бошиглогч тэр жилийн эцэс гэхэд Мормоны Номыг 5 сарын дотор уншихыг Сүмийн гишүүдээс хүссэн бөгөөд ийнхүү уг номыг уншсанаараа бид адислагдах болно гэж амласан юм. Намайг нэг өдөр автобусан дотор Номоо уншиж байтал Синтия гэдэг охин миний хажууд суугаад, энэ ямар ном болохыг асуув. Би адислал авахын тулд энэ номыг он дуусахаас өмнө уншиж дуусгахыг хүсэж байгаа гэдгээ түүнд хэллээ.

Тэр өөр олон зүйл асууж эхэлсэнд энэ номын талаар илүү дэлгэрэнгүй ярилцахын тулд түүнийг манай гэрт ирж болно гэж би түүнд хэлсэн. Тэр миний урилгыг хүлээн авч, бид дараагийн хэдэн өдөр Мормоны Ном болон Сүмийн талаар ярилцахад хэдэн цагийг зарцуулсан билээ.

Дараагийн даваа гарагт би түүнийг гэр бүлийнхээ үдэшт уриад, тэнд номлогчидтой танилцуулсан юм. Тэд түүнд хичээл зааж эхэлсэн. Тэгээд тэр сүмд, өсвөр үеийнхний бүх үйл ажиллагаанд болон Сүмийн бусад цуглаанд ирдэг болов.

Синтия баптисм хүртэхээр шийдэж, эцэг эхийнхээ зөвшөөрлөөр тэр жил төрсөн өдрөөрөө баптисм хүртсэн юм. Тэр үүнийг өмнө нь авч байсан бэлэгнүүдээс хамгийн агуу нь байсан гэж хэлж билээ. Ээж болон ах дүүс нь түүний баптисмд оролцов. Тэр надаас “Бурханы Сүнс” (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу 28) дууг дуулахыг, мөн манай заваас түүнд баптисм хүртээхийг хүссэн. Түүнийг уснаас гарч ирэхэд бид тэврэлдээд, уйлж билээ. Би ийм гайхалтай аз жаргалыг мэдэрсэн тул

тэр өдрийг хэзээ ч мартахгүй.

Нэг жилийн дараа манайх нүүсэн юм. Синтия бид хоёр сайн мэдээгээр дамжуулан сайн найзууд, эгч дүүс болсон байсан учир энэ нь хэцүү байв.

Бид дахин бие биетэйгээ ойрхон амьдраагүй ч гэсэн сайн найзууд хэвээрээ байгаа. Бид заримдаа утсаар ярьдаг. Тэр саяхан над руу залгаад, ээж нь номлогчдын хичээлд сууж байгааг хэлсэн. Өмнө нь түүний ээж хичээлүүдийг сонсохыг хүсдэггүй байсан учраас энэ нь баяртай мэдээ байв. Синтия хэзээ нэгэн өдөр бүх гэр бүлийнхэнтэйгээ сүмд явдаг болно гэж найддаг тухайгаа надад хэлсэн. Тэр надад Сүмийг өөрт нь танилцуулсанд талархал илэрхийлсэн юм. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Техаст амьдардаг.



Бидэнд гараа сунгаач!

Өдөр бүр дэлхий даяар хүүхдүүд бусдад туслах арга замуудыг олсноор анхаарал халамжаа харуулдаг!



АЗ ЖАРГАЛЫН ДУУНУУД

Бид үйлчлэлийнхээ онцгой өдрөөр асрамжийн төвүүдэд айлчилж очдог байв. Биднийг Хүүхдийн хэсгийн болон бусад дууг дуулж эхлэхэд хүмүүс алга ташин, хамт дуулж эхэлдэг. Тэдний зарим нь бүр бүжиглэнэ гээч! Бид тэднийг тэврээд, тэдэнд зориулан хийсэн картуудаа үлдээдэг байлаа.

Португаль, Лэйриа дүүрэг



ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРААС Ч ИЛҮҮ


Аав, ээж хоёр маань өдөржин ажиллаад ядарсан байв. Би аяга тавагнуудаа угааж, хураагаад; шал, ширээ болон гал тогооны ширээгээ цэвэрлэв. Дараа нь би зочны болон тоглоомын өрөөгөө цэвэрлэв. Ээж, аав хоёр сэрээд, Христийн мэндэлсний баяраас ч илүү сайхан байна гэж хэлэв!

Камбри Г., нас 11, АНУ, Жоржия

ЖИГНЭМЭГ БА ХҮҮХЭЛДЭЙНҮҮД

Манай гэр бүлд “үйлчлэл хийдэг улирал” байдаг байв. Ах бид хоёр асрамжийн газрын хүүхдүүдэд зориулан хүүхэлдэйнүүд хийдэг байлаа. Бид бас гал унтраагчдад шоколадтай жигнэмэгүүд хүргэж өгч, нуурын эрэг цэвэрлэдэг байсан юм. Бид үйлчлэл хийдэг байсанд би баяртай байдаг!

Тобин П., нас 9, АНУ, Айдахо



ГАРНЫХАА ЗУРГИЙГ БИДЭНД ИЛГЭЭ

Дэлхий даяарх бүх замаар явахад хэчнээн тусламжийн гар шаардлагатай вэ? Сайн үйлс бүтээж, сайн үйлсийг олж мэдэхэд бидэнд тусал!

1. Цаасан дээр гараа зурж, үүнийгээ хайчилж ав.
2. Хэн нэгний төлөө хийсэн өөрийнхөө үйлчлэлийн талаар— эсвэл чиний төлөө хийсэн хэн нэгний үйлчлэлийн тухай ярилц. Энэ нь жижиг эсвэл том юу ч байж болно.
3. Өөрийнхөө зургийг нэм.
4. Хүсэлтээ lahona@ldschurch.org хаяг руу илгээхэд, эсвэл 3-р хуудсан дээрх хаягаар явуулахад эцэг эхээсээ эсвэл хэн нэгнээс туслахыг хүс.

Бид одооноос эхлэн 2015 оны 10-р сар хүртэл тусламжийн гар цуглуулах болно.

ОЙМСТОЙ ХАЙРЦАГ ТӨСӨЛ

Гэр оронгүй хүмүүс өвөл маш их даардаг! Бид бүсийнхээ гэр оронгүй хүмүүст зориулан дулаан оймс цуглуулахаар шийдэв. Залуу эрэгтэй, эмэгтэйчүүд энэ ажилд тусалснаар удалгүй бидний хайрцаг орон гэргүй хүмүүст зориулсан хэдэн зуун оймсоор дүүрсэн юм!

Канад, Альберт



ШИНЭ ГЭРЭЭНИЙ СУДРУУДЫГ УНШИХ ДААЛГАВАР

Хоньдоо хайрладаг бөгөөд төөрсөн нэг хонио хайж олохоор явсан нэгэн хоньчны тухай түүхийг Есүс ярьжээ. Энэ жил та нар Шинэ Гэрээн дэх Есүсийн сургаалуудын талаар илүү их сурч мэдэх болно. Та нар 68-р хуудсан дээрх судруудын нэгийг унших бүрдээ дараагийн дугаарыг нь буд. Хэрэв та нар долоо хоног бүр уншвал жилийн эцэс гэхэд дуусах болно!

Энэ хүснэгтийг liahona.lds.org хаягаар орж, хэвлэж авах бол насанд хүрсэн хүний туслалцаа ав. ■





Шинэ Гэрээний судруудыг унших даалгаврын дагуу долоо хоног тутмын унших зөвлөмжүүд (66–67-р хуудсыг үзнэ үү).

ДОЛОО ХОНОГ	УНШИХ ЗҮЙЛ
1	Иохан Баптист Есүс Христийн замыг бэлтгэсэн Матай 3:1–6; Лук 1:5–25, 57–80
2	Есүс Христийн төрөлт Матай 1:18–25; Лук 1:26–38; 2:1–20
3	Есүс Христийн хүүхэд нас Матай 2; Лук 2:21–52
4	Есүс Христийн баптисм Матай 3:13–17; Иохан 3:5
5	Сатан Есүс Христийг сорив Матай 4:1–11; Марк 1:12–13; Лук 4:1–13
6	Есүс Христ ариун сүмийг цэвэр болгов Матай 21:12–14; Лук 19:45–48; Иохан 2:13–16
7	Есүс Христ төлөөлөгчдөө дуудав Матай 4:18–22; 16:13–19; Марк 3:13–19; 16:15; Лук 5:1–11; 6:12–16
8	Уулан дээрх номлол Матай 5:1–6:4; 7:12; Лук 6:17–36
9	Есүс Христ залбирлын талаар заав Матай 6:5–13; 7:7–11; 26:36–46; Лук 9:28–29; 11:2–4, 9–13; Иаков 1:5–6
10	Есүс Христ өвчтэй хүмүүсийг эдгээв Матай 8:5–10, 13; 25:34–40; Марк 1:40–45; Лук 4:38–40; 7:11–17; Иохан 4:46–54; 13:34–35
11	Есүс Христ ба хүндэтгэлийн өдөр Матай 12:1–13; Марк 2:23–28; 3:1–6; Лук 13:11–17; 14:1–6; Иохан 5:2–16
12	Есүс Христ бусдыг адислахдаа санваарын хүчээ ашигладаг байв Матай 14:23–33; Марк 4:35–41; 6:33–44; Лук 9:37–43; Үйлс 10:38
13	Есүс Христ гайхамшгуудыг үйлдэв Марк 2:1–12; 5:21–43
14	Тариачин, улаан буудай ба хогийн ургамал Матай 13:1–9, 18–30, 37–43; Марк 4:14–20; Лук 8:11–15
15	Төөрсөн хонь, алдагдсан зоос ба үрэлгэн хүү Матай 18:12–14; Лук 15
16	Сайн самари хүн ба хадан дээр баригдсан байшин Матай 7:24–27; 22:34–40; Лук 6:47–49; 10:25–37
17	Есүс Христ уяман өвчтэй 10 хүнийг, бас нэг хараагүй хүнийг эдгээв Лук 17:12–19; Иохан 9
18	Сайн Хоньчин Матай 19:13–15; Марк 10:13–16; Иохан 10:1–18
19	Хатуу сэтгэлт боол Матай 6:12, 14–15; Матай 18:21–35
20	10 онгон охин, талант ба бэлэвсэн эмэгтэйн зоос Матай 25:1–13, 14–46; Марк 12:41–44; Лук 21:1–4
21	Есүс Христ Лазарыг үхэгсдээс босгов Иохан 11:1–46
22	Есүс Христийн ялгуусан ирэлт ба сүүлчийн зоог Матай 21:1–11; Марк 14:12–26; Лук 19:29–38; 22:15–20
23	Есүс Христ Гетсеманид Матай 26:36–46; Лук 22:40–46; Иохан 3:16; 15:12–13
24	Есүс Христээс урваж, түүнийг баривчлан, шүүх хурлаар оруулав Матай 26:14–16, 47–27:31; Лук 22:47–23:25
25	Есүс Христийн цовдлолт ба булш Матай 27:32–66; Лук 23:26–56; Иохан 10:17–18; 15:13; 19:13–42
26	Есүс Христийн амилалт Матай 27:52–53; 28:1–20; Лук 24; Иохан 20; Үйлс 1:3, 9–11; 1 Коринт 15:5–6, 22
27	Хонинуудыг минь тэжээ Марк 16:15; Иохан 21:1–17
28	Пентекостын өдөр Иохан 14:25–27; Үйлс 2:1–24, 32–33, 36–47
29	Төлөөлөгч Петр Матай 4:18–19; 14:22–33; 16:13–17; 17:1–9; Лук 22:31–34, 54–62; Үйлс 3:1–9, 19–21; 4:6–20; 5:12–42
30	Барнаб, Ананиа болон Сапфир; Стефан, тамлан зовоогчид Үйлс 4:32–5:10; 6; 7:54–60
31	Петр ба Корнел Үйлс 10:1–11:18
32	Саулын хөрвөлт Үйлс 7:57–60; 8:1–3; 9:1–30; 26:9–23
33	Паулын анхны номлол Үйлс 13:4–11, 14–43; 14:5–10
34	Паулын хоёр дахь номлол Үйлс 15:36–41; 16:16–34
35	Паулын гурав дахь номлол Үйлс 18:23; 19:1–7, 11–12, 20
36	Есүс Христ дахин ирэх болно Үйлс 1:9–11; Иосеф Смит—Матай 1:1–4, 21–55
37	Паулын ромчуудад бичсэн захидал Ром 1:16; 8:13–18, 31–39; 12:3–21
38	Паулын коринтчуудад бичсэн анхны захидал 1 Коринт 6:19–20; 12:4–27; 13; 15:20–22, 40–42
39	Паулын коринтчуудад бичсэн хоёр дахь захидал 2 Коринт 4:5–18; 9:6–8; 12:6–10
40	Паулын галатчуудад бичсэн захидал Галат 2:16–21; 5:22–23; 6:7–10
41	Паулын ефесчүүдэд бичсэн захидал Ефес 1:3–12; 4:11–16; 6:10–18
42	Паулын филиппойчуудад бичсэн захидал Филиппой 1:2–11; 2:12–13; 4:4–13
43	Паулын колоссайчуудад бичсэн захидал Колоссай 1:9–20; 3:1–16
44	Паулын тесалоникчуудад бичсэн захидал 1 Тесалоник 2:1–12; 4:1–7; 2 Тесалоник 2:1–4; 3:10–13
45	Паулын Тимотод бичсэн захидлууд 1 Тимот 1:12–17; 5:1–3; 2 Тимот 3:1–5, 14–17
46	Паулын Титэд болон Филемонд бичсэн захидал Тит 1:1–4; 2; Филемон 1:3–9
47	Паулын еврейчүүдэд бичсэн захидал Еврей 1:1–6; 5:1–4; 11:1–11; 12:1–2
48	Иаковын сургаалууд Иаков 1:5–6; 2:17–18; 3:2–13; 5:12
49	Петрийн сургаалууд 1 Петр 1:3–11; 3:18–20; 4:6; 2 Петр 1:2–8
50	Иохан, Иуда нарын сургаалууд 1 Иохан 2:1–6; 3:10–18, 23; 4:7–10; 5:1–3; 2 Иохан 1:4; 3 Иохан 1:4; Иуда 1:20–22
51	Иоханы илчлэлт Илчлэлт 1:1–3; 2:7; 4; 12:7–9; 20:12
52	Есүс Христэд ирэгтүн—Тэр бол дэлхийн гэрэл ба амь мөн Матай 11:28–30; Иохан 4:3–14; 6:35–51; 8:12; 14:6, 15

Цагаа ашиглан ямар нэгэн сайн зүйл хийх нь

Клэйтон В., нас 10, АНУ, Миссури

Бидний амьдардаг газар заримдаа маш хүйтэн, цастай байдаг. Бид заримдаа сургуулиасаа тараад, гэртээ байхдаа гэрийнхээ ойролцоох том гүвээн дээрээс доошоо чаргаар гулсдаг. Нэг өдөр биднийг цасны хувцас, малгай, бээлийгээ өмсөхөөр бэлдэж байтал ээж гадаа хэтэрхий хүйтэн, салхитай байна

гэв. Бид гэртээ байх ёстой болсон учир би ууртай байв. Намайг гомдоллож эхлэхэд ээж надад “Чи өрөөндөө ороод цагаа ашиглан хийж болох ямар нэгэн сайн зүйл олох хэрэгтэй” гэж хэлсэн.

Би өрөөндөө ороод, Аврагч намайг юу хийгээсэй гэж хүсэж байгаа талаар бодов. Би итгэлийн тунхгийг чээжлэхээр шийдэв. Би хэдэн цагийн дараа доош бууж ирээд, ээж, ах, эгч нартаа уурласанд намайг уучлаарай гээд, итгэлийн тунхгийг нэг бүрчлэн чээжилснээ тэдэнд хэлсэн юм. Тэд үнэхээр их гайхаж байв! Би тэдэнд нэг бүрчлэн чээжээр уншиж өгснийхөө дараа цагаа сайн зүйлд ашигласандаа баяртай байлаа.

Аврагч намайг Түүний талаар илүү ихийг суралцахын тулд тэр өглөө цаг гаргахаар шийдсэнд баяртай байсан гэж би боддог. Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүү, Есүс Христийн талаар илүү ихийг сурахад бидэнд туслах гэр бүлийг болон судруудыг надад өгсөнд би талархаж байна. ■



БИДНИЙ ХУУДАС



*Манай аав тойргийн бишоп. Аав на-
дад баптисм хүртээхээсээ өмнө надтай
ярилцлага хийсэн. Би маш их баяртай
байв. Би баптисмдаа сургуулийнхаа
хамгийн сайн найзаа болон түүний гэр
бүлийг урихаар шийдсэн юм. Тэд ч ирсэн!
Би тэр онцгой өдрийг хэзээ ч мартаггүй.
Эфрайн В., нас 8, Испани*



*Би гэр бүлийн түүхийн вэбсайт руу орж,
өвөг дээдсийнхээ нэрийг олж мэднэ.
Өвөг дээдэст маань ариун сүмийн ажил
хэрэгтэй байгаа эсэхийг би шалгаж
чадна. Энэ бол Их Эзэний ажлыг хийхэд
миний оруулж байгаа хувь нэмэр юм.
Стэфэн С., нас 6, Филиппин*



Лаура Д., нас 8, Бразил





Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын
ерөнхийлөгч
Бойд К.Пакэр

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд бол Есүс Христийн онцгой гэрчүүд юм.

СУДРУУД надад хэрхэн тусалж чадах вэ?



СУДРУУД...

- Бидэнд хаашаа явж, юу хийхийг заадаг.
- Бидэнд итгэл найдвар болон мэдлэг өгдөг.
- Бидэнд Есүс Христийн тухай гэрчлэл олж авахад тусалдаг.
- Бидэнд сүнслэг хамгаалалт болдог.

Судраас тогтмол унш, тэгвэл адислалууд нь ирэх болно.

Хэрэв чи бага байхаасаа эхлэн судраас суралцвал явах ёстой замаа мэдэж авах болно. ■

“Сүнслэг хамгаалалтын түлхүүр” сэдэвт хэлсэн үгээс авав, Лиэхона, 2013 оны 11-р сар, 26–28.

Нууц



Жэссика Ларсэн

Бодит түүхээс сэдэвлэв

“Хүн бүрд өгч чадах зүйл байдаг”
Children’s Songbook 236).

Айвиг авахгүй шүү! Тэр чинь
“Аохин” гэж Брадэн Адамын
араас шивнэв.

Гэвч Адам тэр өдөр бөмбөгнөөс
бултдаг тоглоомын (дожболлын)
багийн ахлагч болжээ. Тиймээс
тэр сонголтоо хийчихсэн байв.
“Би Айвиг авлаа” гэж тэр нэлээн
чанга давтан хэлэв. Нөгөө багийн
ахлагч Тайлер ёжтой инээмсэг-
лэв. Дасгалжуулагч Гарсия ч гэсэн
Адамын хоёр дахь сонголтод
гайхсан янзтай байлаа.

Айви ч бас гайхсан харагдаж
байв. Дараа нь тэр ичингүйрхэн
урагш алхав. Брадэн урамгүйхэн
санаа алдлаа.

Айви зүгээр нэг охин биш,
ангидаа хамгийн жижиг биетэй нь
байв. Тэр хурдан гүйж чадах юм
шиг харагддаггүй, бөмбөг хүртэл
түүнээс том мэт санагдаж байлаа.
Айвиг урагш алхах зуур “Тэр бараг
бөмбөгөө ч өргөж дийлэхгүй байх
даа” гэж Брадэн хэлэв.

“Тэр магадгүй бидний нууц
зэвсэг болж мэдэх юм” гэж Адам
сонсогдохоор хэллээ. Гэвч энэ нь
түүнийг сонгосон шалтгаан биш
байлаа. Айви өөрийг нь хамгийн
сүүлд сонгодог учраас спортоор
хичээллэх дургүй гэж Адамд нэг
удаа хэлж байжээ. Хөвгүүд Айви-
гаар даажигнадаг байсан ч Адамын
аав, ээж нь хөвгүүд охидод хүндэт-
гэлтэй хандах хэрэгтэй гэж захидаг

байв. Тиймээс тэр Айвиг сонгожээ.
Тайлерыг ангийнхаа хамгийн том
биетэй эрэгтэй хүүхдийг сонгохыг
хараад, Адам зөв шийдвэр гарга-
сандаа итгэлтэй байв

Баг бүрдсэний дараа дасгалжуу-
лагч Гарсия шүгэлдэхэд, багууд
өрсөлдөхөөр заалны зах руу гүйв.
Дасгалжуулагч Гарсия бөмбөгийг
Тайлерт дамжуулж өгөхөд Тайлер
Айвид анхаарлаа хандуулахаасаа
өмнө Адамын багийнхныг гүйлгэн
харав. Тэр гараа буцаан татаад,
бөмбөгөө шидэв.

Хараач! Бөмбөг газар цохиж,
хэнийг ч онолгүй буцаад ойв.
Адам харсан зүйлдээ итгэсэнгүй.
Айви ч яг цагаа олж бултаж байв.
Эргэн тойрных нь хүн бүр гайхсан

ЗЭВСЭГ



Хүн бүр Айвигийн чадварыг дутуу үнэлж байв.

харагдаж байв. Харин Адам инээмсэглэж байлаа. Айвиг сонгосон нь зөв байжээ.

Тоглолт үргэлжилсээр. Тайлер Айвиг бөмбөгөөр цохихыг хичээж байсан ч тэр замаас нь зайлж, бултсаар байв. Хэн ч түүнийг бөмбөгөөр цохиж чадсангүй. Тайлер болон багийнх нь зарим гишүүн Айвиг гаргах гэж хичээгээд маш завгүй байсан учир өөр хэн нэгнийг цохиход их цаг зарцуулсангүй. Айвигийн жижигхэн биетэй мөн хурдан байгаа нь түүнийг цохихыг илүү хэцүү болгож байсан учир жижигхэн бие нь түүнийг дожболл тоглоход илүү сайн болгож байгааг хараад, Адам инээмсэглэж байлаа

Сүүлд нь Адамын баг тоглолтод хожсон юм. “Нууц зэвсэг зөв байжээ. Айви маш сайн байна” гэж Брадэн хэлэв.

“Тийм байна” гэж Тайлер хэллээ. “Дараагийн удаа тэр манай багт тоглоно. Бид заавал хожно!” Айви анги руугаа явахдаа багийнхнаараа хүрээлүүлэн, инээмсэглэж байв.

Адам бүлгийнхээ хүүхдүүдийг дагаж явахдаа инээхгүй байж чадсангүй. Тэр Айвид сайн хандаж, хөвгүүдэд охидыг жаахан ч гэсэн хүндлэхэд нь тусалсан байв. Хамгийн нууц зэвсэг нь ямар ч нууц зүйл байгаагүй, харин энэ нь зөвхөн сайхан сэтгэл байсан юм. ■
Зохиогч нь АНУ-ын Аризонад амьдардаг.



**БУРХАНЫ
ХААНТ УЛСАД
ХУВЬ НЭМРЭЭ
ОРУУЛЖ
ЧАДАХГҮЙ НЭГ
Ч ХҮН БАЙХГҮЙ**

“Хүн бүр өөр бөгөөд өөр өөр хувь нэмэр

оруулж чадна. Хэн ч бүтэлгүйтэхээс ангид төрдөггүй” гэжээ.

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх ерөнхийлөгч Хэнри Б.Айринг “Өндөр зорилго тавихад нь хүүхдүүддээ тусал,” *Лиакона*, 2012 оны 10-р сар, 60

Есүс Христийн талаар суралцах аялал



Энэ жил Хүүхдийн хэсэгт Шинэ Гэрээ номноос Есүсийн үлгэр жишээг даган, гайхалтай аялал хийх бөгөөд Түүний амьдралаас суралцах болно. Та нарын эцэг эх ч бас ангидаа эдгээр судрыг судлах болно.

Чамд болон танай гэр бүлд Шинэ Гэрээний талаар илүү ихийг хамтдаа суралцахад туслах зарим үйл ажиллагааг энд жагсаав.

ГЭР БҮЛЭЭРЭЭ ЯРИЛЦАХ САНААНУУД

Шинэ Гэрээг судлах нь яагаад чухал бөгөөд сэтгэл хөдлөм байдаг вэ? Аврагчийн талаар илүү ихийг судлах нь бидэнд илүү хүчтэй байхад хэрхэн тусалдаг вэ? Хуваалцах боломжийг хүн бүрд олгох хэрэгтэй. Үүний дараа та "The Books of the New Testament" (Шинэ Гэрээний номнууд) дууг (Хүүхдийн дууны ном 116) дуулж болно. Та нар бас картууд хийж, номны нэрүүдийг бичээд, дарааллаар нь байрлуулж болно.

ДУУ БА СУДАР

- "Tell Me the Stories of Jesus" (*Children's Songbook*, 57).
- Матай 11:29

СУДАР ДЭЭР АЖИЛЛАХ ЗӨВЛӨМЖ

Судрууд дээрээ тэмдэглэл хийх нь дараа нь дуртай шүлгүүдээ олоход та нарт тусалж чадна!

Та нар харандаа, үзэг эсвэл өнгийн харандаа ашиглаж болно.

Есүсийн талаар гарч байгаа шүлэгнүүдийн доогуур зур эсвэл зөвхөн шүлэгний дугаарыг дугуйл.

Танай эцэг эх store.lds.org хаягаар орж, Шинэ Гэрээг англи эсвэл испани хэлээр захиалж болно.

ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭЭРЭЙ

Мариа, Иосеф хоёр засгийн газраас явуулсан хүн амын тооллогод орохоор энд ирэв.

ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭЭРЭЙ

Херод хаан Есүст атаархсан учраас Есүсийг аюулгүй байлгахын тулд Иосеф, Мариа хоёр Түүнийг энд авчрав.

ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭЭРЭЙ

Матай 2:23

ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭЭРЭЙ

Есүсийг төрсний дараа хоньчид болон мэргэн хүмүүс Түүнд мөргөхөөр энд ирэв.

ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭЭРЭЙ

Матай 24:14

ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭЭРЭЙ

Иосеф, Мариа хоёр Есүсийг нялх байхад нь энд авчирсан бол Түүнийг 12 настай байхад дахин авчирсан байна. Тэр үлдээд, ариун сүмд байсан хүмүүст заав.

ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭЭРЭЙ

Матай 2:1

ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭЭРЭЙ

Тэнгэр элч Габриел Есүс төрөх болно гэж хэлэхээр Мариад үзэгдэх үед тэр энд амьдарч байсан.

ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭЭРЭЙ

Херодын бариулсан ариун сүм хэрмээр хүрээлүүлсэн энэ том хотод байсан.

ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭЭРЭЙ

Энэ улс Израильтай ойрхон байв.

ИЛҮҮ ИХИЙГ СУР

Есүс бага байхдаа Мариа, Иосеф хоёртой энд амьдардаг байсан.

ИЛҮҮ ИХИЙГ СУР

Лук 2:48–49

ЕСҮС ХААШАА ЯВСАН БЭ?

“Илүү ихийг мэдээрэй” картнуудаас нэг нэгээр нь ээлжлэн сонгож ав. Үйл явдлуудыг унш эсвэл судрыг олж, унш. Дараа нь газрын зураг дээрх байрлалаар нь картыг тохируул.



Назар




Египет



Иерусалим

Бетлехем





Рөүзмэри М.Виксом

Хүүхдийн хэсгийн ерөнхий
ерөнхийлөгч

Аббигийн хамгийн чухал 10 зорилгын жагсаалт

*“Энэ бол бүх хүмүүний авралын
төлөвлөгөө юм” (Мосе 6:62).*

Намайг залуу эмэгтэйчүүдийн
Нангид сууж байтал багш нь
ангийнхнаасаа амьдралынхаа
хамгийн чухал 10 зорилгыг
бичихийг хүссэн юм. Дараа нь
тэр бичсэн зүйлүүдээ хуваалца-
хыг тэднээс хүсэв. Саяхан
12 нас хүрсэн Абби миний
хажууд сууж байв. Энэ бол
Аббигийн жагсаалт:

1. Колежид сурах
2. Дотоод засал чимэглэлийн загвар
зохион бүтээгч болох
3. Энэтхэгт номлолд үйлчлэх
4. Буцаж ирсэн номлогчтой арцун сүмд гэрлэх
5. Таван хүүхэдтэй мөн гэр оронтой болох
6. Хүүхдүүдээ номлолд явуулж, колежид
суралцуулах
7. Ач, зээ нартаа “жигнэмэг өгдөг” эмээ болох
8. Ач, зээ нараа эрхлүүлэх
9. Сайн мэдээний талаар илүү ихийг мэдэж,
амьдралын баяр баясгаланг эдлэх
10. Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт амьдрахаар
эргэн очих

Абби бид бүхэнд зориулсан
Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө-
ний талаар үзэгдэл харжээ. Та
нарын зам Тэнгэрлэг Эцэгтээ
эргэн очих хамгийн чухал зо-
рилго дээр төвлөрсөн үед
та нар тэнд очиж чадна! ■

*“Ярилцаж мөн сонсох цаг гаргах нь”
сэдэвт хэлсэн үгээс авав. Лиахона,
2012 оны 4-р сар 37.*

ЧИНИЙ ХАМГИЙН ЧУХАЛ 10 ЗОРИЛГЫН ЖАГСААЛТ

Амьдралынхаа 10 зорилгыг бич. Дараа
нь тэдгээрийг тэмдэглэл дээрээ, мөн ханан
дээрээ, эсвэл байнга хардаг газартаа
байрлуулж болно.

Ариун сүмд зааж буй Есүс Лук 2:42–47


Энэ хуудсыг зузаан цаасан дээр юм уу, картон цаасан дээр наа. Тэгээд зургуудыг хайчилж, тэднийг модон савхан дээр наа, эсвэл цаасан уутанд хий. Дээр нь судрын эшлэлээ бичээд, дугтуйнд хадгал. ■
liahona.lds.org хаягаар орж, илүү олон хувийг хэвлэж авч болно.



Мариа, Иосеф хоёр



12 настай Есүс



Багш нар

АВТОБУСАН дотор

Мици Жимэнээ Рамирээ

Бодит түүхээс сэдэвлэв

София бараг 8 нас хүрч, баптисм хүртэхэд бэлэн болж байв. Тэр олон чухал зүйл сурч байлаа. Түүний сурсан нэг зүйл нь залбирал байв. Тэр Тэнгэрлэг Эцэгтээ хандан хүссэн цагтаа, хүссэн газраа залбирч болно гэдгийг мэддэг болжээ.

Нэг өдөр София ээжтэйгээ хамт аавынхаа ажил дээр

зочилж очихоор шийдэв. Энэ нь урт аялал болох байв. Аав нь өөр тосгонд ажилладаг байлаа. Тэд эхлээд автобусаар, дараа нь ачааны машинаар, тэгээд таксигаар явах хэрэгтэй байв.

Автобусаар явж байхдаа София унтжээ. Тэр хүүхэд уйлахыг сонсоод, сэрэв. Хүүхдээ авч явсан эцэг эх

автобусанд суусан ажээ. Хүүхэд өвчтэй байсан болохоор чанга уйлж байлаа. Тэр хүүхдийн эцэг эхийн санаа зовсон харагдаж байв.

София өвчтэй хүүхдэд, бас эцэг эхэд нь санаа зовж байлаа. Түүнд нэг санаа төрөв. Тэр ээжийнхээ чихэнд: “Би залбирч, хүүхдийг адислахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйж болох



ХЭЛСЭН ЗАЛБИРАЛ

уу?” гэж шивнэв.

Ээж нь “Мэдээж, бололгүй яахав” гэж инээмсэглэн хариуллаа.

София толгойгоо бөхийлгөөд, чимээгүйхэн залбирав. Тэр хичээнгүйлэн залбирч, Тэнгэрлэг Эцэгээсээ хүүхдийг адислахыг, мөн хүүхдийн биеийг сайжирч, уйлахаа болиход нь туслахыг гуйв.

София залбирсан болгоноо үргэлж авдаггүйг, бас бидний залбирлууд үргэлж тэр дороо хариулагддаггүй гэдгийг мэддэг байсан. Гэтэл хэсэгхэн хугацааны дараа хүүхэд тайвшрав. Дараа нь хүүхэд уйлахаа болилоо. Түүний бие сайжирсан юм шиг түүнд санагджээ. Эцэг эх нь

ч бас тийм их санаа зовсон харагдахгүй байв.

Софиягийн санаа сэтгэл сайхан болж, их баяртай байлаа. Тэр хүүхдийн төлөө бас эцэг эхийнх нь төлөө баяртай байв. Тэнгэрлэг Эцэг залбирлыг нь сонссоныг тэр мэдэж байлаа. ■

Энэ өгүүллийг зохиогч Мексикт амьдардаг.





Ерөнхийлөгч
Харолд Б.Лий
(1899–1973)

ИХ ЭЗЭН НАМАЙГ ӨРШӨӨСӨН ЭСЭХИЙГ БИ ХЭРХЭН МЭДЭХ ВЭ?

Хэн нэгэн энэ асуултыг асууж, тан дээр ирвэл та юу гэж хариулах вэ?

Хэдэн жилийн өмнө ерөнхийлөгч [Марион Ж.] Ромни [1897–1988] бид хоёр миний оффист сууж байв. Хаалга онгойлгож, шаналсан царайтай ч нүдэнд дулаахан нэг залуу орж ирлээ. Тэр “Ах нар аа, би маргааш анх удаа ариун сүм явах гэж байна. Би өмнө нь алдаа гаргаж байсан. Тэгээд бишоп, гадасны ерөнхийлөгч хоёр дээр очиж, бүгдийг нь ярьсан. Наманчилж, тэр алдаануудаа дахин давтаагүй хэсэг хугацаа өнгөрсөн учир тэд одоо намайг ариун сүм явахад бэлэн болсон гэж үзэж байгаа юм. Гэвч ах нар аа, энэ хангалтай биш байна. Их Эзэн намайг уучилсан эсэхийг би хэрхэн мэдэх вэ? Би үүнийг л мэдмээр байна” гэж хэлэв.

Хэн нэгэн энэ асуултыг асууж, тан дээр ирвэл та юу гэж хариулах вэ? Бид хэсэг зуур тунгаан бодоод, Мозаягийн номон дээрх хаан



Бенжамины хэлсэн үгийг санасан юм. Тэнд баптисм хүртэхийг хүссэн хэсэг хүмүүс байсан бөгөөд тэд өөрсдийн эгэл байдлыг олж харснаа хэлжээ.

“Ай нигүүлсэж хайрла, мөн бид нүглүүддээ өршөөлийг хүлээж авч болохын тулд мөн зүрх сэтгэл маань ариуссан байж болохын тулд Христийн цагаатгагч цусыг нөлөөлүүлээч. . . .

“ . . . тэд эдгээр үгсийг ярьсны дараа Их Эзэний Сүнс тэдний дээр ирж, мөн тэд нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авч, улмаар тэд ухамсрын амар амгаланг хүлээн авсан учир, мөн тэд баяр хөөрөөр дүүргэгдсэн байв” (Мозая 4:2–3).

Хариулт нь үүнд л байлаа!

“Та хэн ч байсан, мөн хаана ч байсан нүглээ наманчлахын тулд чадах бүхнээ хийж, хамгийн сайнаараа өөрчлөгдөн, төлөөсөө төлсөн бол; хэрэв энэ нь таны сүмийн гишүүнчлэлд нөлөөлөх ямар нэгэн зүйл байгаад, мөн та зохих эрх мэдэлтэнтэй уулзсан бол Их Эзэн таныг хүлээн зөвшөөрсөн эсэх талаар та баттай хариулт авахыг хүсэх болно. Та бодол эргэцүүлэлдээ ухамсрын амар амгаланг эрэлхийлж мөн үүнийгээ олсон бол, энэхүү тэмдгээр Их Эзэн таны наманчлалыг хүлээн авсныг мэдэж болно. Сатан таныг өөрөөр бодуулахыг хүсдэг бөгөөд тэр нэгэнт алдаа гаргасан бол буцах боломжгүй гэж таныг ятгахыг хүсдэг. Энэ бол агуу худал хуурмагуудын нэг юм. Өршөөлийн гайхамшиг нь муу үйлүүдээсээ эргэж, дахин үйлдээгүй бүх хүнд боломжтой билээ. ■

“Stand Ye in Holy Places” хэлсэн үгээс авав, Ensign, 1973 оны 7-р сар, 122.

ОЙЛГОЛТ



Амьдрал хэцүү байгаа үед би хэрхэн баяр баясгалантай байж чадах вэ?

“Амьдралд өдий төдий зүйл бидний зан байдлаас шалтгаалдаг. Юмсыг ойлгохоор бидний сонгосон арга зам болон бусадтай харилцах бидний харилцаа юм бүхэнд нөлөөлдөг. Хэрэв бид чадах бүхнээ хамгийн сайнаар хийж, байгаа нөхцөлдөө аз жаргалтай байхаар сонгох юм бол амьдралын нөхцөл нь ямар ч байлаа гэсэн аз жаргал, сэтгэл ханамжийг авчрах болно.”

Энэ дугаарт

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

ҮРГЭЛЖ ХАМТДАА ЗӨВЛӨЛД

Гэр бүлээрээ амжилттай
зөвлөлдөхдөө эдгээр зургаан
зарчмыг ашиглана уу.



42-р
хуудас

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ



48-р
хуудас

2015 ОНЫ МЮЧЕЛИЙН СЭДЭВ

Залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийн бүлгийн ерөнхий
ерөнхийлөгчийн зөвлөлүүд Сургаал ба Гэрээ 4:2
шүлгэн дээрх санаануудыг хуваалцав.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Шинэ Гэрээний Судрын УНШИХ ХЭСЭГ

Энэ жил Шинэ Гэрээний эдгээр шүлгийг
уншихдаа энэхүү будах үйл ажиллагааг
ашиглаарай.



66-р
хуудас